



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үр дүнд
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Үнэ тарифыг гүйцэтгэлд үндэслэн тогтоож байгаа нь
хуулиар тогтоосон зарчимтай нийцэхгүй байна



Аудитыг гүйцэтгэсэн:

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор

М.Давааням

Аудитын менежер:

З.Ариунзаяа

Ахлах аудитор:

Ж.Эрдэнэ

Аудитор:

Г.Баатархуяг
М.Доржмаа
С.Одонцэцэг
Ж.Ганчимэг
И.Туяадарь

Шинжээч:

Т.Аварзэд

Аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, лавлах, холбогдох саналаа өгөхийг хүсвэл 261456 дугаарын утсаар харилцана уу.

Уг тайланг УАГ-ын www.audit.mn цахим хуудаснаас үзнэ үү.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160
Монгол Улс

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
Хүснэгтийн товъёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
Ерөнхий мэдээлэл	7
Бүлэг 1. Үнэ тарифыг бодит өртөг зардалд бус гүйцэтгэлд үндэслэж байгаа нь хуулиар тогтоосон зарчимтай нийцэхгүй байна	11
Үнэ тариф тогтооход баримталж байгаа аргачлал нь хуулиар тогтоосон зарчмыг хангаагүй, бодит өртөг, зардалд тулгуурлаагүй байна	11
Эрчим хүчний үнэ тарифт тооцох зардлын 30 хувийг бүрдүүлж байгаа түлшний хэмжээг тооцоолох коэффициентүүдийг туршилтаар баталгаажуулах, шинэчлэн тогтоох шаардлагатай байна	15
Зарим тохиолдолд зохицуулагчид эрчим хүчний үнэ тарифыг үндэслэлгүй тогтоож иржээ	17
Сэргээгдэх эрчим хүчний үнэ тарифыг хуулиар тогтоож байгааг өөрчлөн зах зээлийн зарчимд үндэслэн тогтоох нь зүйтэй байна	18
Зарим аргачлал оновчтой боловсруулагдсанаар эерэг үр дүн гарчээ	19
Зохицуулах хороо болон ТӨБЗГ-аас төрийн өмчит компаниудын төлөвлөлтийг харилцан уялдаатай хянах эрх зүйн зохицуулалт байхгүй байна	20
Бүлэг 2. Үнэ, тарифын талаархи өнөөгийн хууль, эрх зүйн болон санхүү удирдлагын бодлого зохицуулалт нь эрчим хүчний салбарын урт хугацааны тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөхөөр байна	21
Үнэ тариф тогтвортой байгаа боловч ТЗЭ-дэд хуримтлал бүрдэх боломжгүй байна	21
Хэрэглэгчийг бага өртөгтэй эрчим хүчээр хангахад чиглэгдсэн тооцоо судалгааг үндэслэн, зарим журам, аргачлалыг шинээр болон шинэчлэн боловсруулснаар зохих үр дүн гарчээ	21
Борлуулалтын орлогыг хуваарилахдаа ДҮТ ХХК зөрчил гаргажээ	22
Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансны үлдэгдлийг өдөрт нь хуваарилаагүй зөрчил гарсан байна	22
ДҮТ ХХК нь эрчим хүчний хэрэглээний балансын батлагдсан төлөвлөгөөг мөрдөөгүйгээс үр ашиггүй худалдан авалт хийсэн байна	23
Бүлэг 3. Үнэ тарифын зохицуулалт болон тусгай зөвшөөрөл олголтод тавигдах хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрэн бүрдээгүй байна.	24
Үнэ тарифыг тогтоох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн, байнгын хяналтын тогтолцоо шаардлагатай байна	24
Үнэ тарифын зохицуулалтыг хэрэгжүүлэх талаар Зохицуулах хорооноос ТЗЭ-дэд хийсэн шалгалтын хамрах хүрээ хангалттай биш, ХШХ-ийн үйл ажиллагаа үр дүнгүй байна	25
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйн улмаас тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд зөрчил, дутагдал давтагдан гарсаар байна	25
Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг зохих ёсоор хэрэгжүүлээгүй байна	26
Зохицуулалтын үйлчилгээний хөлс хяналтгүй зарцуулагдаж байна	28
Холбогдох байгууллагын санал	30
Дүгнэлт	36
Зөвлөмж	38
Хавсралтууд	40



Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АУНС	Алтай Улиастайн нэгдсэн сүлжээ
ББНС	Баруун бүсийн нэгдсэн сүлжээ
БЗӨБЦТС	Багануур Зүүн Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ
БОШХ	Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
ДЗДЦС	Даланзадгадын дулааны цахилгаан станц
ДСЦТС	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ
ДДЦС	Дархан дулааны цахилгаан станц
ДТЗЭ	Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч
ДЭХ	Дулааны эрчим хүч
ЗБНС	Зүүн бүсийн нэгдсэн сүлжээ
ИТА	Инженер техникийн ажилчид
МЭХГУУ	Монголын эрчим хүч, геологи уул уурхай
МЭХА	Монголын эрчим хүчний ассоциаци
НХА	Нэг худалдан авагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОСНААУГ	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
ӨБНС	Өмнөд бүсийн нэгдсэн сүлжээ
СЭХ	Сэргээгдэх эрчим хүч
ТБНС	Төвийн бүсийн нэгдсэн сүлжээ
ТЗЭ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЗУГ	Төрийн захиргаа удирдлагын газар
ТТЗЭ	Түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч
ТЭХС	Төвийн эрчим хүчний систем
УЦС	Усан цахилгаан станц
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
УИХ	Улсын Их Хурал
YAГ	Үндэсний аудитын газар
ҮТЗЭ	Үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч



ҮТХ	Үнэ тарифын хэлтэс
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХТЗЭ	Хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч
ХШХ	Хяналт шалгалтын хэлтэс
ХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ЭБЦТС	Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ
ЭДЦС	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц
ЭХБББ	Эрчим хүчний барилга байгууламж барих
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХТХ	Эрчим хүчний тухай хууль
ЭХС	Эрчим хүчний сайд
ЭХЯ	Эрчим хүчний яам

**Хүснэгтийн товъёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Айл өрхийн хэрэглэгчдэд үзүүлж буй хөнгөлөлт	8
Хүснэгт №2	Тарифт тооцсон ажилтнуудын орон тооны өөрчлөлт	14
Хүснэгт №3	Зорилтот түвшин болон хянасан саналын зөрүү /сая төгрөг/	21
Хүснэгт №4	Үйлдвэрлэлийн бус зардлыг тарифт тооцсон байдал /сая төгрөг/	26

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг №1	2015-2016 оны салбарын алдагдлын хэмжээ /тэрбум төгрөг/	8
Зураг №2	2016 оны тариф тооцсон зардлын бүтэц	8
Зураг №3	Эрчим хүчний нийт үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн эзлэх хувь	9
Зураг №4	Тарифт тооцсон зардал хэрэглэгчийн дундаж тарифын харьцуулалт	11
Зураг №5	Төвийн бүсийн ҮТЗЭ-дийн цахилгаан үйлдвэрлэлийн ВЕР шинжилгээний үр дүн	12
Зураг №6	Цахилгааны нэгжийн өртгийн шинжилгээ	12
Зураг №7	Төвийн бүсийн ҮТЗЭ-дийн дулаан үйлдвэрлэлийн ВЕР шинжилгээний үр дүн	12
Зураг №8	Дулааны нэгжийн өртгийн шинжилгээ	12
Зураг №9	Төвийн бүсийн ҮТЗЭ-дийн цахилгаан, дулаан үйлдвэрлэлийн ВЕР шинжилгээний үр дүн”	13
Зураг №10	Бусад бүсийн ТЗЭ-дийн үйл ажиллагааны ВЕР шинжилгээний үр дүн	13
Зураг №11	ҮТЗЭ-ийн /ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4, ДДЦС, ЭДЦС/ хүчин чадлыг ажиллагсдын тоотой харьцуулсан харьцуулалт	14
Зураг №12	Дамжуулах, түгээх, хангах ТЗЭ-ийн хүчин чадлыг ажиллагсдын тоотой харьцуулсан харьцуулалт	14
Зураг №13	ДЦС бүрийн тарифт тооцсон нүүрсний биет хэмжээ ба гүйцэтгэл, ЦЭХ, ДЭХ-ний үйлдвэрлэлт, төлөвлөгөөний харьцуулалт	16-17
Зураг №14	СЭХ-ний үнэ болон уламжлалт ДЦС-ын үнийн харьцуулалт /ам.цент/кВт.ц/	19
Зураг №15	Дэмжих тарифын төсөөлөл	19
Зураг №16	Тусгай зөвшөөрөлгүй иргэн, ААН-ын борлуулалтын орлогын харьцаа /сая.төг/	29

Бүдүүвчийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Бүдүүвч №1	Нэг худалдан авагчтай загвар	9

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт №1	Сэргээгдэх эрчим хүчний ТЗЭ-дийн үнэ тарифын санал хянаж, баталсан байдал	40
Хавсралт №2	2015, 2016 онд төвлөрүүлээгүй зохицуулалтын үйлчилгээний хөлсний үлдэгдэл	40
Хавсралт №3	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөгүй ААН	41
Хавсралт №4	Хөрөнгө оруулалтын гэрээ, санхүүгийн эх үүсвэрийн баталгаагүй ААН-үүд	41
Хавсралт №5	Ажиллагсдын цалингийн сан, орон тооны харьцуулалт	42
Хавсралт №6	Түлшний зардлын өөрчлөлт	42
Хавсралт №7	Тарифт тооцсон элэгдлийн зардлын өөрчлөлт	42
Хавсралт №8	Тэг үлдэгдэлтэй орлогын дансанд шилжүүлэх хувь хэмжээ	42
Хавсралт №9	Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данснаас хуваарилах хувь хэмжээ	42
Хавсралт №10	Хэрэглэгчийг бага өртгөөр хангах чиглэлээр УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн үүрэг даалгаврын хэрэгжилтийн байдал	43
Хавсралт №11	ДЦС-4 ТӨХК-ийн хөргөх цамхаг №4-т аудитын дүгнэлт гарсан тухай	44-49
Хавсралт №12	ДЦС-4 ТӨХК ПТ-80-130 ТГ-6 турбины хүчин чадлыг 20 МВт-аар нэмэгдүүлсэн өөрчлөлтийн ажилд аудитын дүгнэлт гаргасан тухай	49-51
Хавсралт №13	Хүчний трансформаторын чадлыг нэмэгдүүлсэн ажилд аудитын дүгнэлт гаргасан тухай	51-52
Хавсралт №14	“ДзДЦС” ТӨХК-ийн турбин генераторыг шинэчлэн солих ажлыг хэрэгжүүлсэн тухай	53
Хавсралт /тусгай/	Аудитад илэрсэн зөрчилтэй холбоотой албан тушаалтны нэрс	54

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл****Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

“Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитыг дараах 3 зорилтын хүрээнд төлөвлөж, хэрэгжүүлсэн болно. Үүнд:

- Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, дамжуулах, хангах үйл ажиллагааны үнэ тариф бодитой тогтоогдож буй эсэх;
- Үнэ тарифын зохицуулалт хийснээр эрчим хүчний салбарт үр дүн гарч буй эсэх;
- Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалтад тавих хяналт үр дүнтэй эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Эрчим хүчний яамны бодлого төлөвлөлтийн газар, хэлтсүүд, Эрчим хүчний зохицуулах хороо, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ, Диспетчерийн үндэсний төв ХХК, Төв, Өмнөд болон Алтай-Улиастайн, Баруун, Зүүн бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээ мөн эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл бүхий бусад холбогдох байгууллагуудын үнэ тарифын зохицуулалттай холбоотой үйл ажиллагааг 2015-2017 оны эхний улирлыг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 3000-3100, гүйцэтгэлийн аудитын арга зүйг үндэслэн ЭХЯ-ны холбогдох газар, хэлтсийн болон ЭХЗХ, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн компанийн удирдах болон бусад ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, баримт материалд дүн шинжилгээ хийх, үнэ тарифын санал, зардалд дүн шинжилгээ хийх, холбогдох тайлан, мэдээллийг судлан Эрчим хүчний тухай хууль, СЭХ тухай хууль ЭХЗХ-ноос баталсан журам, аргачлалуудыг ашиглав.

Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням удирдаж, аудитын менежер З.Ариунзаяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ж.Эрдэнэ, аудитор М.Доржмаа, С.Одонцэцэг, Д.Баатархуяг, И.Туяадарь, Ж.Ганчимэг нар гүйцэтгэж, эрчим хүчний Зөвлөх инженер Т.Аварзэд, Д.Мягмарсүрэн нар шинжээчээр ажиллав. /Д.Баатархуяг, Ж.Ганчимэг нар Гүйцэтгэлийн аудитын газрын захирал М.Даваанямын үүрэг болгосны дагуу аудитад ажилласан. Зөвлөх инженер Т.Аварзэд МҮЕА-ын баталсан 2017 оны 05 дугаар сарын 26-ны гэрээний дагуу шинжээчээр ажиллав./

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайланг ерөнхий мэдээлэл, аудитын үндсэн зорилтын дагуу нэгдүгээр бүлгийг “Үнэ тарифыг бодит өртөг зардалд бус гүйцэтгэлд үндэслэн тогтоож байгаа нь хуулиар тогтоосон зарчимтай нийцэхгүй байна”, хоёрдугаар бүлгийг “Үнэ, тарифын талаархи өнөөгийн хууль, эрх зүйн болон санхүү удирдлагын бодлого зохицуулалт нь эрчим хүчний салбарын урт хугацааны тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөхөөр байна”, гуравдугаар бүлгийг “Үнэ тарифын зохицуулалт болон тусгай зөвшөөрөл олголтод тавигдах хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрэн бүрдээгүй байна.” гэсэн нэртэйгээр бүлэглэн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт гэсэн бүтэцтэйгээр бичсэн.

Аудитыг 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 09-ний хооронд хийж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг гүйцэтгэлийн аудитын журмын 8, 9, 10 дугаар маягтын дагуу бэлтгэж, ажлын баримт материалд хавсаргав.



Ерөнхий мэдээлэл

Эрх зүйн орчны талаар

Эрчим хүчний үнэ тарифыг 2001 оны 02 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан “Эрчим хүчний тухай” болон УИХ-ын 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр батлагдсан “Сэргээгдэх эрчим хүчний тухай” хууль, УИХ-ын 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 63 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс эрчим хүчний талаар 2015-2030 онд баримтлах бодлого”¹, Засгийн газрын болон салбарын яамны холбогдох шийдвэрийн хүрээнд зохицуулж иржээ.

Эрчим хүчний зохицуулах газар нь 2001 онд байгуулагдсан бөгөөд Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу Засгийн газрын 2012 оны 49 дүгээр тогтоолоор тус газрыг Эрчим хүчний зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэх/ болгон өөрчлөн зохион байгуулжээ.

Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8.1²-т зааснаар Зохицуулах хороо нь эрчим хүчний үнэ тарифыг тогтоох, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй бөгөөд мөн хуулийн 9 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд эрчим хүчний үнэ тарифыг зохицуулах дараах журам, аргачлалуудыг баталж, мөрдүүлсэн байна. Үүнд:

- Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох аргачлал,
- Үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн цахилгааны чадал болон энергийн тариф тооцох аргачлал,
- Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн цахилгаан эрчим хүчний үнэ тариф, бие даасан цахилгаан /дулаан/ эрчим хүч үйлдвэрлэгчийн гэрээний гарааны үнийг тогтоох аргачлал,
- Цахилгааны чадлын төлбөр тооцох аргачлал,
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн “Тарифын саналыг хянан шалгах журам”,
- ДЦС-ын ТЭЗҮ тооцох аргачилсан заавар,
- Эрчим хүчний зохицуулалттай үйлчилгээний хөлс тооцох аргачлал,
- Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлал,
- Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам,
- Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам зэрэг болно.

Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8.2³-т зааснаар Зохицуулах хороо нь орон тооны гурав, орон тооны бус хоёр, нийт таван зохицуулагчтай ажиллах ёстой боловч Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 68, 74, 88, 2017 оны 53 дугаар захирамжаар нийт дөрвөн зохицуулагч томилогдсон, орон тооны бус нэг зохицуулагч одоогоор томилогдоогүй байна.

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4⁴-т зааснаар ТЗЭ-дээс ирүүлсэн үнэ тарифын саналыг тус хорооны Эрчим хүчний зохицуулалтын газар хянан үзсэний үндсэн дээр Зохицуулагчдын зөвлөлөөр хэлэлцүүлж, эрчим хүчний үнэ тарифыг баталж байна.

Эрчим хүчний салбарын талаар

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын 1.4.2-т зааснаар Монгол Улсын эрчим хүчний салбар газар нутгийн алслагдмал байдал, дэд бүтцийн хөгжлөөс хамааран Баруун, Төв, Зүүн, Өмнөд бүс болон Алтай-Улиастайн эрчим хүчний сүлжээ гэсэн 5 хэсгээс бүрдэж байна.

2016 оны байдлаар эрчим хүчний салбар улсын хэмжээнд нийт 1037.3 мВт суурилагдсан хүчин чадлын 60.5 хувийг ашиглан 5802.4 сая кВт.ц үйлдвэрлэж, импортоор 1419.1 сая кВт.ц худалдан авч нийт 606.9 мянган хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр, 8727.0 мян.Гкал дулаан үйлдвэрлэж 308.8

¹ Тус бодлогын баримт бичигт “Улс орны өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээг тасралтгүй, найдвартай хангах, цаашид эрчим хүч экспортлогч орон болох, бодит өртөг, ашгийн зохих түвшинг хангасан, үнэ тарифын тогтолцоог бий болгож, салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах нь Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын гол зорилт” гэж тодорхойлсон.

² Эрчим хүчний зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэх/ нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах, үнэ тарифыг тогтоох, эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.


³ Зохицуулах хороог орон тооны гурав, орон тооны бус хоёр, нийт таван гишүүний бүрэлдэхүүнтэй зохицуулагчид удирдана.

⁴ тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх.

мянган хэрэглэгчийг дулааны эрчим хүчээр хангаж, 695.8 тэрбум төгрөгийн зардал гарган, 695.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлогыг төвлөрүүлжээ.

Зураг №1 “2015-2016 оны салбарын алдагдлын хэмжээ” /тэрбум төг/

2015 оны 3 дугаар улиралд эрчим хүчний хэрэглэгчийн дундаж тариф 121.7 төг/кВт.ц-аас 143.8 төг/кВт.ц буюу 18.1 хувиар өссөний нөлөөгөөр 2016 онд эрчим хүчний салбарын хэмжээгээр 167.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь 2015 оны үр дүнгээс (тус онд 18.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан) 99.8 хувиар сайжирчээ. /Зураг №1-д харуулав./



Эх сурвалж: 2016 оны эрчим хүчний статистик үзүүлэлтүүд

Үнэ тарифын талаар


ТБНС-ний ЦЭХ-ний нэгжийн өртөг 141.5 төг/кВт.ц, дундаж үнэ 143.8 төг/кВт.ц бол ББНС-ний ЦЭХ-ний нэгжийн өртөг 201.6 төг/кВт.ц, дундаж үнэ 124.5 төг/кВт.ц, АУНС-ний ЦЭХ-ний нэгжийн өртөг 239.0 төг/кВт.ц, дундаж үнэ 129.6 төг/кВт.ц байна. Баруун бүсэд ЦЭХ-ний дундаж үнэ өртгөөсөө 1.8 дахин доогуур түвшинд байгаа нь тус бүсийн нэгдсэн сүлжээн дэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн онцлог болон том чадлын эх үүсвэр байхгүйгээс импортоор эрчим хүч авдаг, өртөг өндөртэй дизель станц ажиллуулж эрчим хүчээр хангаж байгаатай холбоотой байна.

Эрчим хүчний салбарын хэмжээнд дулааны эрчим хүчний дундаж үнэ нэгжийн өртгөөсөө 50-75 хувиар бага байна. Дулааны эрчим хүчний борлуулалтын алдагдлыг хөндлөн татаасаар⁵ нөхөж ирсэн бөгөөд үүнд 2016 онд нийтдээ 16.3 тэрбум төгрөгийг олгожээ.

Эрчим хүчний үнэ тариф тогтоох зардлыг тооцоолохдоо ТЗЭ-дийн нийт 38 нэр төрлийн зардлын сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийг үндэслэл болгодог байна. Эдгээр зардлуудын бүтцийг 2016 оны байдлаар зураг №2-д харууллаа.

2016 онд хэрэглэгчийн төлбөрийн чадвартай уялдуулан айл өрхийн цахилгаан эрчим хүчний тарифт 28-103 төг/кВт.ц буюу нийт дүнгээр 44.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна.

Зураг №2 “2016 оны тариф тооцсон зардлын бүтэц”



Эх сурвалж: 2016 оны эрчим хүчний салбарын үйл ажиллагааны тайлан

Дээрх хөнгөлөлтийг бүсүүдээр ангилан харуулсан мэдээллийг хүснэгт 1-д харууллаа.

Хүснэгт №1. “Айл өрхийн хэрэглэгчдэд үзүүлж буй хөнгөлөлт”

Айл өрхийн хэрэглэгч	Дундаж үнэ /төг/кВт.ц/	Нэгжийн өртөг /төг/кВт.ц/	Зөрүү /төг/кВт.ц /	Айл өрхийн хэрэглэгчдэд үзүүлж буй хөнгөлөлт /сая төг/
ТБНС	111.06	141.55	27.5	34,083.0
ББНС	108.68	221.06	103.4	6,460.6
ЗБНС	117.00	142.63	21.9	863.9
АУНС	121.21	238.97	97.1	3,075.1
ӨБНС	122.05	142.85	17.0	318.7
Дүн				44,801.3

Эх сурвалж: 2016 оны эрчим хүчний салбарын үйл ажиллагааны тайлан

⁵Цахилгаан дулааны эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох аргачлалын 2.4-т зааснаар цахилгааны тарифт шингээх дулааны үйлдвэрлэлийн санхүүгийн алдагдлын хэмжээ.



Сэргээгдэх эрчим хүчний талаар

Нар, салхи, ус, газрын гүнийн дулаан, биомасс зэрэг байгаль орчинд ээлтэй эх үүсгүүрээр эрчим хүч үйлдвэрлэх, нийлүүлэх харилцааг зохицуулах зорилгоор Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль 2007 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр батлагдсан байна.

Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогод нийт суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 онд 30 хүртэл хувиар, мөн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүй, татварын таатай орчныг бүрдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн механизмыг бий болгохоор тусгасан байна.

Эрчим хүчний нийт үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн эзлэх хувийг сүүлийн 3 жилийн байдлаар зураг №3-т харууллаа.

Зураг №3 “Эрчим хүчний нийт үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн эзлэх хувь”



Дамжуулах сүлжээнд холбогдсон СЭХ-ний үүсгүүрээр үйлдвэрлэж, нийлүүлэх эрчим хүчний үнэ тарифыг салхины эрчим хүчний тухайд 0.08-0.095 ам.доллар/кВт.ц, 5000 кВт хүртэл хүчин чадалтай усан цахилгаан станцын тухайд 0.045-0.06 ам.доллар/кВт.ц, нарны эрчим хүчний тухайд 0.15-0.18 ам.доллар/кВт.ц байхаар тус хуулиар тогтоосон байна.


Зохицуулах хороо дэмжих тарифыг⁶ ТБНС болон ӨБНС-нд 3.95 төг/кВт.ц, ББНС болон АУНС-нд 8.3 төг/кВт.ц-аар тогтоожээ.

Эх сурвалж: 2016 оны эрчим хүчний статистик үзүүлэлтүүд

Нэг худалдан авагчтай загварын талаар

Төвийн бүсийн цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах ТЗЭ-дийн хүрээнд мөрдөх төвийн бүсийн нэгдсэн сүлжээний Нэг худалдан авагчтай арилжааны загвар⁷-ыг ЭХС-ын 2015 оны 178 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна.

Бүдүүвч №1. “Нэг худалдан авагчтай загвар”



Эх сурвалж: ЭХС-ын 2015 оны 178 дугаар тогтоолоор батлагдсан НХА-тай загвар

⁶ Дэмжих тариф: сэргээгдэх эрчим хүчийг дэмжих зорилгоор эрчим хүчний үнэд шингээсэн тарифыг хэлнэ.

⁷ НХА: Төвийн бүсийн хэрэглэгчдээс цуглуулсан цахилгааны орлогыг тэг үлдэгдэлтэй орлогын дансууд болон нэгдсэн дансаар дамжуулан урьдчилан тогтоосон хувь хэмжээний дагуу банк нь үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгчдийн дансанд өдөр бүр автоматаар хуваарилж байдаг загвар



НХА загвараар 5 ДЦС, 4 ЦТС, түгээх зөвшөөрөл бүхий төр, орон нутаг, хувийн хэвшлийн 12 ААН, 2 СЭХ үйлдвэрлэгч, нийт 23 ААН, ДҮТ ХХК, ЦДҮС ТӨХК-аас гадна эрчим хүчний экспорт, импортын орлого төвлөрүүлэлт, ЦЭХ-ний төлбөр, мөнгөн урсгалын хуваарилалтыг дамжуулан зохицуулж байна. /Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данснаас хуваарилах хувь хэмжээг хавсралт №9-өөс үзнэ үү./

Хяналт шалгалтын тогтолцооны талаар

Зохицуулах хорооны 2016 оны 144 дүгээр тогтоолоор “Эрчим хүчний зохицуулалтын хяналт, шалгалтын журам”, “Дотоод хяналт шалгалтын журам”-ыг тус тус баталж, мөрдүүлж байна.

Дээрх журмын дагуу Зохицуулах хорооны ХШХ нь төлөвлөгөөт хяналт шалгалтыг байгууллагын стратеги төлөвлөгөөний хүрээнд, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, ТЗЭ болон магадлан итгэмжлэл эзэмшигчийн хүсэлт, хоорондын маргаан болон хөндлөнгийн мэдээ, мэдээлэлд үндэслэн хийдэг байна.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2015 оны 02 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2015 оны 54 дүгээр тушаалын дагуу 2015 оны 2 дугаар улиралд ЭХЯ-ны ХШҮДАГ, Зохицуулах хороо төрийн өмчийн 14 компанийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Зохицуулах хорооны Хяналт шалгалтын хэлтсээс 2016, 2017 онд нийт 7 ТЗЭ-д төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн байна.

ҮАГ-аас Эрчим хүчний тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үр дүнд 2016 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар Зохицуулах хорооны даргад зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж мөрдөх, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хөндлөнгийн болон дотоод хяналтын тогтолцоог холбогдох хууль, журмын дагуу бий болгон мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн байна.



Бүлэг 1. Үнэ тарифыг бодит өртөг зардалд бус гүйцэтгэлд үндэслэж байгаа нь хуулиар тогтоосон зарчимтай нийцэхгүй байна

Үнэ тариф тогтооход баримталж байгаа аргачлал нь хуулиар тогтоосон зарчмыг хангаагүй, бодит өртөг, зардалд тулгуурлаагүй байна

1.1 ЭХТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.2.1-д тариф тогтоох зарчмыг “*үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах*” гэж заасан боловч Зохицуулах хорооноос баталж, мөрдүүлж байгаа “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох аргачлал”-ын 1.2⁸, 3.1⁹-ыг баримтлан, өмнөх 3 жилийн зардлын гүйцэтгэлд үндэслэн үнэ, тарифыг тогтоож иржээ.


1.2 Энэ нь эрчим хүчний үйлдвэрлэлийн өртөгт орж тооцогдох түүхий эд материал, шатахуун, тээвэр, сэлбэг хэрэгсэл, хангамж, цалин зэрэг зардлын нормативыг тодорхойлоогүй байгаатай холбоотой байна. Эндээс үзэхэд тарифт тооцсон зардал бодитой тооцоологдохгүй байна.

1.3 Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох аргачлалын дагуу тогтоосон тариф нь эрчим хүчний үнэ тарифыг хямдруулах, үйлдвэрлэлийн өртөг, зардлыг бууруулах, арвилан хэмнэх хөшүүрэг болж чадахааргүй байна. Харин үүний эсрэгээр, үйлдвэрлэлийн өртөг, зардал жилээс жилд нэмэгдэх нь эрчим хүчний хэрэглэгчийн үнэ тарифыг дараагийн онд шинэчлэн тогтоох шууд үндэслэл болох зохицуулалт үйлчилж байна.

1.4 Үнэ тариф тогтоох аргачлалыг зохицуулалттай өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллахад бэлтгэн сайжруулалт хийх шаардлагатай байна.

1.5 Эрчим хүчний ТЗЭ-дийн тарифт тооцох зардал жилээс жилд өсөж байхад орлогыг бүрдүүлэх хэрэглэгчийн тариф өөрчлөгдөөгүй байна. Үүнийг зургаар үзүүлбэл,

Зураг №4 “Тарифт тооцсон зардал хэрэглэгчийн дундаж тарифын харьцуулалт”



Эх сурвалж: Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын 2014-2016 оны үйл ажиллагааны нэгдсэн дүн

1.6 Төвийн бүсийн ҮТЗЭ-дийн 2013-2016 оны үйл ажиллагааны орлого, зарлага, үйлдвэрлэсэн эрчим хүчний гүйцэтгэлд үндэслэн ашиг алдагдлын үзүүлэлтийг судлахад дараах үр дүнтэй байна.

Зураг №5 “Төвийн бүсийн ҮТЗЭ-дийн цахилгаан


Зураг №6 “Цахилгааны нэгжийн өртгийн шинжилгээ”

⁸ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны сүүлийн 3 жилийн бодит зардлын гүйцэтгэлд тулгуурлан энэхүү аргачлалын дагуу тарифыг тооцож, саналыг ЭХЗХ-нд оруулна”


⁹ “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүрэн өөрийн өртгийг сүүлийн 3 жилийн бодит өртөг зардлын гүйцэтгэлд үндэслэн тогтоох...”



Үйлдвэрлэлийн ВЕР шинжилгээний үр дүн”



Эх сурвалж: Аудитын багийн тооцоолол




Эх сурвалж: Аудитын багийн тооцоолол

1.7 Зураг №5-д ВЕР¹⁰ шинжилгээгээр төвийн бүсийн ҮТЗЭ-дийн цахилгаан үйлдвэрлэлт үр ашигтай, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Цахилгааны нэгжийн өртөг дундаж хувьсах зардлаас их байгаа учраас төвийн бүсийн ЦЭХ үйлдвэрлэлт ашигтай ажиллаж байна. /Зураг №6/


1.8 Гэвч дулаан үйлдвэрлэлт ашиг, алдагдал тэнцүү байх түвшинд хүрээгүй, 2016 онд дулаан үйлдвэрлэлийн алдагдал 70.8 тэрбумд хүрснээр орлого зарлагын зөрүү ихсэж, хэвийн үйл ажиллагааны нөхцөлийг хангах боломжийг хязгаарлаж байна. /Зураг №7/ Дулааны нэгжийн борлуулалтын дундаж үнэ дундаж хувьсах зардлаас /AVC/ доогуур байгаа нь нэгж дулаан нэмж үйлдвэрлэхэд алдагдал нэмэгдэж байгааг харуулж байгаа бөгөөд алдагдлаа нөхөж ажиллаж чадахгүй байгаа гол шалтгаан болж байна. Үүнийг зураг №8-аар харууллаа.

Зураг №7 “Төвийн бүсийн ҮТЗЭ-дийн дулаан үйлдвэрлэлийн ВЕР шинжилгээний үр дүн”



Эх сурвалж: Аудитын багийн тооцоолол

Зураг №8 “Дулааны нэгжийн өртгийн шинжилгээ”




Эх сурвалж: Аудитын багийн тооцоолол

¹⁰ ВЕР – ашиг, алдагдал тэнцүү байх цэг /хугарлын цэгийн шинжилгээ/




1.9 Дулаан үйлдвэрлэлийн энэхүү алдагдлыг хөндлөн татаасаар нөхөн ажиллаж байна. Төвийн бүсийн ҮТЗЭ-дийн эрчим хүчний үйлдвэрлэл, орлого, зардлыг үндэслэн хийсэн ВЕР шинжилгээний үр дүнг зураг №9-өөр харуулбал,

Зураг №9 “Төвийн бүсийн ҮТЗЭ-дийн цахилгаан, дулаан үйлдвэрлэлийн ВЕР шинжилгээний үр дүн”



Эх сурвалж: Аудитын багийн тооцоолол

Зураг №10 “Бусад бүсийн ТЗЭ-дийн үйл ажиллагааны ВЕР шинжилгээний үр дүн”



Эх сурвалж: Аудитын багийн тооцоолол

1.10 Төвийн бүсийн ҮТЗЭ-дийн эрчим хүч үйлдвэрлэл үр ашигтай, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх эхлэлийг тавьсан боловч зардал нь орлогоо даган огцом өссөн үр дүнг үзүүлж байна. Орлогын өсөлт нь хэрэглээний өсөлтөөс 29.7 хувь, тарифын өөрчлөлтөөс 70.2 хувь нь хамаарсан бол зардлын өсөлт нь хувьсах зардлын өсөлтөөс 33.5 хувь, тогтмол зардлын өсөлтөөс 66.5 хувь нь хамаарч өссөн байна.

1.11 Төлөвлөсөн үйлдвэрлэл төдийлөн өсөөгүй байхад зардал огцом нэмэгдэж ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхгүй байгаа нь цаашид тогтмол зардлын өсөлтийг хязгаарлаж, арвилан хэмнэлтийн бодлого баримталж ажиллах шаардлагатай болсныг илэрхийлж байна.

1.12 Зураг №10-т үзүүлсэн бусад бүсийн ТЗЭ-дийн үйл ажиллагаа алдагдалтай ажиллаж байна. Энэ нь дулааны нэгжийн борлуулалтын дундаж үнэ дундаж хувьсах зардлаас /AVC/ бага байгаатай холбоотой байна. Импортоор авч буй цахилгааны үнийн болон валютын ханшийн өсөлт дундаж хувьсах зардлыг өсгөх гол нөлөөг үзүүлсэн байна.


1.13 Тарифт тооцсон зардал өмнөх онтой харьцуулахад 2016 онд 79.5 тэрбум төгрөг буюу 13.4 хувиар, 2017 онд 37.0 тэрбум төгрөгөөр буюу 5.5 хувиар нэмэгдсэн нь нийт зардлын 84 хувийг бүрдүүлдэг түлш, цалин, элэгдэл гэсэн гурван гол нэр төрлийн зардал өмнөх онуудад өссөнтэй холбоотой байна.

1.14 Түлшний зардал: Өмнөх онтой харьцуулахад тарифт тооцсон түлшний зардал 2017 онд 13.2 тэрбум төгрөг буюу 6.1 хувиар, 2016 онд 24.8 тэрбум төгрөг буюу 13.0 хувиар тус тус өссөн нь жишмэл түлшний хувийн зарцуулалт буурснаас нүүрсний бодит хэмжээ, цахилгаан дулааны эрчим хүчний түгээлт, нүүрсний үнэ, төмөр замын тээврийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна. /Хавсралт №6/

1.15 Цалин, урамшууллын зардал: Өмнөх онтой харьцуулахад тарифт тооцсон цалингийн зардал 2017 онд 6.5 тэрбум төгрөг буюу 3.5 хувиар, 2016 онд 28.7 тэрбум төгрөг буюу 18.2 хувиар өссөн нь ЭХЯ, МЭХГУУ-н үйлдвэрчний эвлэлийн холбоо, МЭХА нарын хамтарсан 3 талт “Эрчим хүчний салбарын хамтын /тариф/ хэлэлцээр”-ийг үндэслэн ТУЗ болон гүйцэтгэх захирлын шийдвэрээр цалин, урамшуулал, тэтгэмж, орон тоог нэмэгдүүлсэн байна.

1.16 Эрчим хүчний салбарт ажиллагсдын орон тоог нийт хүчин чадал нэмэгдсэн үед л нэмдэг тогтолцоо байхгүй, үндэслэлгүйгээр нэмдэг дүр зураг харагдаж байгаа бөгөөд ТӨБЗГ, ТУЗ, Гүйцэтгэх

удирдлагын түвшинд хүний нөөцийн бодлогогүй, үр ашиггүй ажиллаж байгаагаа илтгэж байна. Үүнийг зураг №8, №9-өөр харуулбал, Зураг №11. “ҮТЗЭ-ийн /ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4, ДДЦС, ЭДЦС/ хүчин чадлыг ажиллагсдын тоотой харьцуулсан харьцуулалт”



Эх сурвалж: ЭХЗХ-ноос гаргасан судалгаанууд

Зураг №12. “Дамжуулах, түгээх, хангах ТЗЭ-ийн хүчин чадлыг ажиллагсдын тоотой харьцуулсан харьцуулалт”



Эх сурвалж: ЭХЗХ-ноос гаргасан судалгаанууд

1.17 ТЗЭ-дийн ТУЗ болон гүйцэтгэх захирал нар “Эрчим хүчний салбарын хамтын /тариф/ хэлэлцээр”-ээр “халхавч” хийж ийнхүү орон тоо, цалин, үр дүнгийн урамшуулал зэргийг нэмэгдүүлсэнийг Зохицуулах хороо хэдийгээр тарифт хасаж тооцож байгаа ч тарифт тооцох цалингийн зардал болон орон тоо жилээс жилд нэмэгдсээр байна. Үүнийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №2. “Тарифт тооцсон ажилтнуудын орон тооны өөрчлөлт”

	Нийт ажилтны тоо		Үүнээс:		
		Удирдах ажилтан	ИТА, албан хаагч	Ажилчид	
2015 он	9994	96	2847	6707	
2016 он	10528	87	3012	7085	
2017 он	11211	108	3370	7733	
Зөрүү	1217	12	523	1026	

Эх үүсвэр: Зохицуулах хорооны 2015, 2016, 2017 оны тариф тооцсон материал

1.18 Аудитаар цахилгаан дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх хангах томоохон ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4, УБДС, ЦДҮС, УБЦТС компаниудыг түүвэрлэн авч цалингийн зардлын өсөлтийн шалтгааныг авч үзлээ. Түүвэрлэн авсан компаниудын цалингийн зардлын өсөлтийг ажиллагсдын орон тооны өсөлттэй харьцуулав. /Хавсралт №5-аас үзнэ үү./ 2016 онд ТӨХК-ийн цалингийн сан болон ажиллагсдын тоо өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн нь дараах шалтгаантай байна. Энэ нь:

- ДЦС-2 ТӨХК-ийн цалингийн сан 817.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бүтцийн өөрчлөлтөөр орон тоог 5 хүнээр /дэд захирал-1, турбин генератор №2 шинээр ашиглалтад орсноор 4 машинч/,
- ДЦС-3 ТӨХК-ийн цалингийн сан 2,381.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь орон тоог 4 хүнээр, ИТА-ын цалингийн зөрүүг багасгах зорилгоор ИТА-ын цалинг 8-12 хувиар,
- ДЦС-4 ТӨХК-ийн цалингийн сан 4,037.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь орон тоог 8 хүнээр, нийт ажиллагсдын цалинг 10 хувиар,
- ЦДҮС ТӨХК-ийн цалингийн сан 3,170 сая төгрөгөөр нэмэгдсэн нь орон тоог 33 хүнээр /2015 оноос улсын төсвийн хөрөнгөөр нийт 9 дэд станц ашиглалтад орсон/ нэмэгдүүлсэн болон ажилчдын үндсэн цалингийн жишгийг шинэчлэн баталсантай,
- УБДС ТӨХК-ийн цалингийн сан 841.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь орон тоо 21 хүнээр нэмэгдүүлсэнтэй,
- УБЦТС ТӨХК-ийн цалингийн сан 3,307.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь орон тоо 109 хүнээр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

1.19 Цалингийн зардал 2017 онд 6.5 тэрбум төгрөг, 2016 онд 28.7 тэрбум төгрөгөөр өссөнийг тооцож үзэхэд хэрэглэгчийн тариф 2017 онд 1.59 төг/кВт.ц-аар, 2016 онд 7.05 төг/кВт.ц-аар нэмэгдэх тооцоолол гарч байна.

1.20 Элэгдлийн зардал: Үндсэн хөрөнгийн элэгдлийг “Журам батлах тухай” Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын дагуу тооцож байсныг 2014 оны 297 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцох, бодит бус зардлын өсөлтийг хязгаарлах зорилгоор 2015 оны Хорооны 86 дугаар тогтоолоор “ТЗЭ хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”-ыг батлан мөрдүүлж, 2016 оны 53 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан байна.

1.21 “Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”-ын 3.10 дахь заалтад “Засгийн газрын буцалтгүй тусламж, Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон бусад хандив, тусламжаар авсан үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгахдаа НББОУС 20-ын 12¹¹ дахь заалтыг баримтлана.” гэсэн заалт оруулж, хэрэгжүүлэхдээ “Цахилгаан дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлал”-ын 3.1¹² дэх заалтад эдгээр эх үүсвэрээр авсан үндсэн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийснээс нэмэгдэх элэгдлийн зардлыг тарифын тооцоонд авч үзэхгүй байна. Ингэснээр 2017 онд 9.1 тэрбум төгрөгийг тарифт тооцох элэгдлийн зардлаас хасаж тооцсон байна.

1.22 Эдийн засгийн утгаараа тухайн хөрөнгөөс өгөөж хүртэж байгаа бол элэгдлийн зардлыг байгуулж үр ашиг, элэгдэл хорогдлыг тооцоолж байх нь бодит өртөг зардлыг үнэн зөв гаргаж ирэх ач холбогдолтой. Элэгдлийн зардлыг хасаж тооцсоноор ТЗЭ-д алдагдалтай байх тарифын бодлого үйлчилж байгаа бөгөөд энэ нь тарифт тооцох зардал бодитой бус тооцоологдож байгааг харуулж байна.

1.23 Элэгдлийн зардлын өсөлтөд тусгай зөвшөөрөл эзэмшигч томоохон компаниудын үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэн нь нөлөөлсөн байна. Өмнөх онтой харьцуулахад тарифт тооцсон элэгдлийн зардал 2017 онд 6.4 тэрбум төгрөг буюу 5.3 хувиар, 2016 онд 3.7 тэрбум төгрөг буюу 3.1 хувиар тус тус өссөн нь зарим томоохон компаниуд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэнтэй холбоотой байна. Тухайлбал,

- ДЦС-3 ТӨХК-ний тарифт тооцсон элэгдлийн зардал 2016 онд 238.2 сая төгрөгөөр буюу 1.1 хувиар,
- ЦДҮС ТӨХК-ний тарифт тооцсон элэгдлийн зардал 2017 онд 3,040.4 сая төгрөгөөр буюу 37.4 хувиар,
- УБДС ТӨХК-ний тарифт тооцсон элэгдлийн зардал 2016 онд 1,837.3 сая төгрөгөөр буюу 34.6 хувиар төгрөгөөр буюу 46.1 хувиар,
- ЭБЦТС ТӨХК-ний тарифт тооцсон элэгдлийн зардал 2016 онд 937.8 сая төгрөгөөр буюу 33.8 хувиар,
- УБЦТС ТӨХК-ний тарифт тооцсон элэгдлийн зардал 2015 онд 2,714.5 сая төгрөгөөр буюу 26.6 хувиар тус тус өссөн. /Хавсралт №7/

1.24 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэнээр тарифт тооцсон элэгдлийн зардал 2017 онд 6.4 тэрбум төгрөг, 2016 онд 3.7 тэрбум төгрөгөөр өссөнийг тооцож үзэхэд хэрэглэгчийн тариф 2017 онд 1.5 төг/кВт.ц-аар, 2016 онд 0.9 төг/кВт.ц-аар нэмэгдэх тооцоолол гарч байна.

1.25 Бусад зардал: Өмнөх онтой харьцуулахад тарифт тооцсон бусад зардал 2017 онд 10.9 тэрбум төгрөг буюу 7.5 хувиар, 2016 онд 22.3 тэрбум төгрөг буюу 18.1 хувиар тус тус өссөн нь дотоод хэрэгцээний цахилгаан, урсгал засвар, хөдөлмөр хамгаалал, ажиллагсдын нийгмийн зардал өссөнтэй холбоотой байна.

1.26 Тарифт тооцсон зардлыг үндэслэлтэй төлөвлөхийн тулд хувьсах зардлуудын нормативыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх шаардлагатай байна. Ингэснээр бодит өртөг зардалд үндэслэнэ гэсэн хуулийн зарчим хангагдах боломжтой болно.

Эрчим хүчний үнэ тарифт тооцох зардлын 30 хувийг бүрдүүлж байгаа түлшний хэмжээг тооцоолох коэффициентүүдийг туршилтаар баталгаажуулах, шинэчлэн тогтоох шаардлагатай байна


¹¹ Засгийн газрын буцалтгүй тусламжийг системтэй сууриар, холбоотой зардлыг харгалзан нөхөх байдлаар уг зардлыг хэрэгжих тайлангийн үеүдэд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

¹² ТЗЭ-ийн бүрэн өөрийн өртгийг сүүлийн 3 жилийн бодит өртөг зардлын гүйцэтгэлд үндэслэн тогтоох ба хөрөнгө оруулалт, шинэчлэлийн үр дүнд ирээдүйд бий болох хөрөнгө, хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн, Засгийн газрын буцалтгүй тусламжаар болон бусдаас үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнд тооцогдох элэгдэл, хорогдлын зардлыг тусгахгүй.



1.27 Түлшний зардлыг тооцохдоо ДЦС-ын ТЭЗҮ тооцох аргачлалд тусгагдсан туршилтаар баталгаажуулж коэффициентүүдийг хэрэглэж байгаагаас жишмэл түлшний хувийн зарцуулалт¹³ зөрүүтэй гарч, тарифт тооцсон түлшний зардлыг үндэслэлгүйгээр өндөр тогтоосон байна¹⁴. Үүнийг 2016 оны тарифт тооцсон нүүрсний биет хэмжээ, ЦЭХ болон ДЭХ үйлдвэрлэх төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулсныг зураг №13-д үзүүлээ.

Зураг №13 “ДЦС бүрийн тарифт тооцсон нүүрсний биет хэмжээ ба гүйцэтгэл, ЦЭХ, ДЭХ-ний үйлдвэрлэлт, төлөвлөгөөний харьцуулалт”



Эх сурвалж: 2016 оны эрчим хүчний статистик үзүүлэлтүүд

¹³ 1 кВт ЦЭХ үйлдвэрлэхэд шаардагдах нүүрсний хэмжээ

¹⁴ Дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэдэг станцуудын өртгийн хуваарилалтын аргачлалыг боловсронгуй болгох багцын судалгааны ажлын тайлан /2016 он/

1.28 Нүүрсний зарцуулалтыг төрийн өмчийн 5 компанийн 2016 оны гүйцэтгэлээр авч үзэхэд эрчим хүч үйлдвэрлэлд зарцуулсан нүүрсний хэмжээ төлөвлөснөөс 10.5-аас 224.3 мянган тонн буюу дунджаар 2.5 хувиар бага зарцуулжээ. Үүнд:

- ДЦС-2: Дулааны эрчим хүч үйлдвэрлэл 101.5 хувиар, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 100.5 хувиар биелсэн байхад нүүрсний зарцуулалт төлөвлөснөөс 4.4 хувиар буурсан,
- ДЦС-3: Дулааны эрчим хүч үйлдвэрлэл 111.1 хувиар, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 99.8 хувиар биелсэн байхад нүүрсний зарцуулалт төлөвлөснөөс 5.2 хувиар буурсан,
- ДЦС-4: Дулааны эрчим хүч үйлдвэрлэл 94.5 хувиар, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 99.8 хувиар биелсэн байхад нүүрсний зарцуулалт төлөвлөснөөс 6.8 хувиар буурсан,
- ДДЦС: Дулааны эрчим хүч үйлдвэрлэл 97.4 хувиар, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 101.1 хувиар биелсэн байхад нүүрсний зарцуулалт төлөвлөснөөс 2.0 хувиар буурсан,
- ЭДЦС: Дулааны эрчим хүч үйлдвэрлэл 101.2 хувиар, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 101.0 хувиар биелсэн байхад нүүрсний зарцуулалт төлөвлөснөөс 0.3 хувиар өссөн байна.

1.29 Дээрх жишээнээс үзэхэд эдгээр 5 үйлдвэрлэгчийн хэмжээнд нийт дулааны эрчим хүч үйлдвэрлэл 100.9 хувиар, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 100.4 хувиар биелсэн байхад нүүрсний зарцуулалт төлөвлөснөөс дунджаар 2.5 хувиар буурсан байна.

1.30 Нүүрсний зарцуулалт нь нүүрсний илчлэгээс хамаардаг ч ДЦС-ын ТЭЗҮ тооцох аргачлалд тусгагдсан коэффициентүүдийг дахин нягталж, туршилтаар баталгаажуулах, шинэчлэх шаардлагатай байгааг харуулж байна.

1.31 Хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үнэ тариф өөр өөрөөр тогтоогдож байгаа нь тухайн хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчлэх хүрээнд байгаа хэрэглэгчийн бүтцээс шалтгаалдаг байна. Тухайлбал,

- 2017 онд ЭБЦТС ТӨХК-ийн хангах тариф 156.56 төг/кВт.цаг байгаа нь гол хэрэглэгч болох Эрдэнэт УБҮ /уул уурхайн тариф бусад хэрэглэгчийн тарифаас өндөр/ байдагтай холбоотой байна.
- М-Си-Эс ХХК-ийн Эрчим сүлжээ ХХК-ийн тариф 146.27 төг/кВт.цаг, АПУ ХК-ийн Пауэр Юнит ХХК-ийн тариф 149.38 төг/кВт.цаг, Нолго ХХК-ийн тариф 144.63 төг/кВт.цаг байгаа нь ихэнх хэрэглэгч нь ААН нэгж учир бусад хангах ТЭЗ-ийн тарифаас өндөр байна.

Зарим тохиолдолд зохицуулагчид эрчим хүчний үнэ тарифыг үндэслэлгүй тогтоож иржээ

1.32 ЭХТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.8.2¹⁵ -т заасны дагуу орон тооны бус нэг зохицуулагч томилогдоогүй, Зохицуулах хороо хуульд заасан бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллахгүй байгаа нь үнэ тариф батлах явцад хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байр суурь хүчгүйдэх, хорооны шийдвэр гаргахад 4 гишүүний санал тэнцэх зэрэг сөрөг үр нөлөө гарч болзошгүй юм.

1.33 Зохицуулагчдын зөвлөлийн хурал нь гурван зохицуулагчийн ирц бүрдсэн үед хүчинтэй байхаар, зохицуулагчдын хурлын шийдвэрт өгсөн гишүүдийн санал тэнцсэн үед Зохицуулах хорооны даргын талд шийдвэрийг¹⁶ гаргахаар тус тус зохицуулсан байгаа нь хурлын шийдвэрт хэт нэг талын байр суурь давамгайлан нөлөөлөх эрсдэлтэй байна.

1.34 Зохицуулагчид эрчим хүчний үнэ тарифын саналыг хянаж, тогтоох асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэхдээ ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар мэдүүлэг гаргахгүй байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1¹⁷ дэх заалт болон УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан журмын 1.5¹⁸ дахь заалтыг тус тус зөрчжээ.

¹⁵ Зохицуулах хороог орон тооны гурав, орон тооны бус хоёр, нийт таван гишүүний бүрэлдэхүүнтэй зохицуулагчид удирдана.

¹⁶ Зохицуулах хорооны хурлын журмын 2.7-д “Хурлыг Хорооны зохицуулагчдын гурав нь биечлэн оролцсоноор хүчинтэйд тооцно.” 4.10-д “Хурал даргалагч хэлэлцэж байгаа асуудлаар санал, дүгнэлтийг илээр явуулах бөгөөд саналын зөрүүтэй байгаа асуудлыг ерөнхий зохицуулагч шийдвэрлэнэ.” гэж тус тус заажээ.

¹⁷ 8.1.Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

¹⁸ Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 1.5 дахь заалт Мэдүүлэг гаргагч нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нэн даруй хүргүүлнэ.

1.35 Зохицуулагчид эрчим хүчний үнэ тарифыг тогтоохдоо “ТЗЭ-ийн тарифын саналыг хянан, шалгах журам”-ын дагуу Зохицуулах хорооны ҮТХ-ээс хянаж, ирүүлсэн саналыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн баталсан тохиолдол цөөнгүй гарчээ. Тухайлбал, 2016 онд 94 удаагийн хурлаар эрчим хүчний үнэ тарифыг тогтоох асуудлыг хэлэлцэхдээ ҮТХ-ээс оруулсан саналыг дунджаар 3.19 хувиар нэмэгдүүлж Хорооны дарга С.Отгонбаярын саналын дагуу баталснаар зарим ТЗЭ-дэд ойролцоогоор 1.6 тэрбум төгрөгийн нэмэлт орлогын боломжийг бий болгожээ. Тухайлбал,

2016 онд үнэ тарифыг дээрх байдлаар нэмэгдүүлснээр дараах ТЗЭ-дэд:

- ДСЦТС ТӨХК-ний хувьд 538.6 сая төгрөгийн /2016 оны 1 сард тухайн үеийн дарга н.Нэргүй/
- БЗӨБЦТС ТӨХК-ий хувьд 467.3 сая төгрөгийн, /тухайн үеийн гүйцэтгэх захирал Ш.Доржрагчаа/
- ЭБЦТС ТӨХК-ий хувьд 283.9 сая төгрөгийн, /тухайн үеийн гүйцэтгэх захирал Ч.Баттуяа/,
- Эрчим сүлжээ ХХК-ний хувьд 112.9 сая төгрөгийн, /тухайн үеийн гүйцэтгэх захирал н.Ганболд/
- Хөвсгөл эрчим сүлжээ ХХК-ний хувьд 23.5 сая төгрөгийн, /тухайн үеийн гүйцэтгэх захирал н.Пүрэвсүрэн/
- Баянхонгор эрчим хүч ХХК-ний хувьд 23.49 сая төгрөгийн, /тухайн үеийн гүйцэтгэх захирал н.Батбаяр/
- Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ ХХК 123.6 сая төгрөгийн /тухайн үеийн гүйцэтгэх захирал н.Гантулга/ нэмэлт орлого олсон тооцоо гарсан.

Мөн СЭХ-ний гарааны үнийг дараах байдлаар нэмэгдүүлэн баталжээ. Үүнд:

- Мон-Кориа инженеринг ХХК-ний хувьд 15.9 ам.цент/кВт.ц саналыг нэмэгдүүлж 17.8 ам.цент/кВт.ц,
- Клинтек ХХК-ний хувьд 9.0 ам.цент/кВт.ц саналыг нэмэгдүүлж 9.5 ам.цент/кВт.ц,
- Сайншанд салхин парк ХХК-ний хувьд 9.0 ам.цент/кВт.ц саналыг нэмэгдүүлж 9.5 ам.цент/кВт.ц,
- Эвридэй ферм ХХК-ний хувьд 16.3 ам.цент/кВт.ц саналыг нэмэгдүүлж 17.3 ам.цент/кВт.ц,
- Тэнүүн гэрэл констракшн ХХК-ний хувьд 15.8 ам.цент/кВт.ц саналыг нэмэгдүүлж 16.2 ам.цент/кВт.ц,
- Эрэл ХХК-ний хувьд 11.5 ам.цент/кВт.ц саналыг нэмэгдүүлж 13.5 ам.цент/кВт.ц тус тус нэмэгдүүлж баталжээ.
- Солар повер интернейшнл ХХК-ний хувьд 16.0 ам.цент/кВт.ц саналыг нэмэгдүүлж 16.5 ам.цент/кВт.ц-аар нэмэгдүүлж баталснаар 2017 оны 1 дүгээр сараас ажиллаж эхэлсэн бөгөөд эхний 4 сард 6.2 сая кВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж 2.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, тариф нэмэгдүүлсний зөрүүгээс 76.0 сая төгрөгийн илүү орлого олсон тооцоо гарч байна.

1.36 Зохицуулах хорооны зохицуулагчдын эрчим хүчний үнэ тариф батлахтай холбоотой эрх үүргийг хуулинд тодорхой заагаагүй нь дээрх байдлаар үндэслэлгүй шийдвэр гаргах, холбогдох эрх зүйн акт зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Сэргээгдэх эрчим хүчний үнэ тарифыг хуулиар тогтоож байгааг өөрчлөн зах зээлийн зарчимд үндэслэн тогтоох нь зүйтэй байна

1.37 УИХ-аас 2007 онд батлагдсан СЭХ-ний тухай хуульд үнийг ам.доллараар илэрхийлж, шууд тогтоосон нь үйлдвэрлэлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг татах хөшүүрэг болж байгаа боловч олон улсад техник, технологи сайжирч, өртөг, зардал ихээхэн буурах хандлагатай байна¹⁹.

1.38 2009 онд төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль батлагдсанаас хойш СЭХ-ний тусгай зөвшөөрөл авсан ААН-үүдийн үнэ тарифыг ам.доллараар тогтоож байгаа нь уг хуулийн 7.7.1-д “Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж заасныг зөрчсөн байна.

1.39 СЭХ-ний тухай хуульд нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэх үнийг 0.15-0.18 ам.доллар/кВт.ц -аар тогтоосон ба дэлхийн жишгээс 20-30 орчим хувиар өндөр байгаа ба дотоотын үйлдвэрлэлийн үнэ тарифаас 4.4-5.2 дахин өндөр байгаа нь ЭХТХ-ийн 26.2.7-д заасан хамгийн бага өртгийн зарчмыг мөрдөнө гэсэнтэй нийцэхгүй байна.


1.40 1057.2 мВт суурилагдсан хүчин чадалтай СЭХ-ний үүсгүүр ашиглалтад орвол салхины эрчим хүчний үнээр бодвол дэмжих тариф одоогийнхоос 32.5 төг/кВт.ц-аар, нарны эрчим хүчний үнээр бодвол дэмжих тариф одоогийнхоос 88.7 төг/кВт.ц-аар нэмэгдэхээр тооцоолол гарч байгаа нь нэгдсэн сүлжээний горим ачаалал, хэрэглэгчийн үнэ өсөхөд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэл үүсгэж байна.

¹⁹ Сэргээгдэх эрчим хүчний технологи сайжирч өртөг зардал нь жилээс жилд буурч байна. 2005 онд салхин станцын өртөг 0.071 ам.доллар/кВт.ц байсан бол 10 жилийн дараа 2015 онд 0.06 ам.доллар/кВт.ц болж буурсан байна. Нарны станцын өртөг 2005 онд 0.285 ам.доллар/кВт.ц байсан бол 2015 онд 0.126 ам.доллар/кВт.ц болж буурсан байна. /Эх сурвалж: СЭХ-ний тухай хуулийн 11-р зүйл, World energy council 2016 IRENA/




1.41 Уламжлалт ДЦС-ын үнэ СЭХ-ний үнээс бага байгааг дараах зургаар харуулбал,

Зураг №14 “СЭХ-ний үнэ болон уламжлалт ДЦС-ын үнийн харьцуулалт /ам.цент/кВт.ц/”



Эх сурвалж: Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйл

Зураг №15 “Дэмжих тарифын төсөөлөл”



Эх сурвалж: Аудитын багийн тооцоолол

1.42 Энэ нь цаашид эрчим хүчний салбарыг алдагдалд оруулах, улмаар СЭХ-ний гадны хөрөнгө оруулалтыг эрсдэлд оруулж Монгол улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг бууруулах нөлөөлөл үзүүлж байна.

1.43 СЭХ-ний тухай хуульд заасан үнэ тариф зах зээлийн зарчим дээр үндэслэгдэн тогтоогддог байхаар, гадны хөрөнгө оруулалтыг татах нөхцөлийг бүрдүүлэх байдлаар нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

1.44 2017 оны 6 дугаар сарын байдлаар нийт 22 аж ахуйн нэгжид 1057.2 мВт хүчин чадалтай СЭХ-ний үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд энэ нь Монгол Улсын өнөөгийн эрчим хүчний суурилагдсан хүчин чадалтай ойролцоо байна.

1.45 Дунд хугацаанд буюу 2023 он гэхэд эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 2792.3 мВт болох зорилтыг эрчим хүчний салбарын хэмжээнд дэвшүүлж байгаа бөгөөд түүний 20 хувь буюу 562.4 мВт нь СЭХ-ний эх үүсгүүр байхаар тооцоо гарч байна.

1.46 Өнөөдрийн байдлаар СЭХ-ний талаар төрөөс баримтлах бодлого тодорхойлогдоогүй байхад СЭХ үйлдвэрлэл тусгай зөвшөөрлийг 1057.2 мВт-ын буюу 5 жилийн дараа хүрэх түвшингээс 2 дахин илүү хүчин чадлын хэмжээнд олгосон зөрчил илэрлээ.

1.47 Гэвч эдгээр тусгай зөвшөөрлүүд авсан төслүүд Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогод тусгагдаагүй бөгөөд тус бодлогын 1 дүгээр үе шатанд /2015-2023/ эрчим хүчний горим тохируулах Эгийн голын усан цахилгаан станц баригдсан байх, Ховд голд усан цахилгаан станц баригдсан байна гэсэн боловч эдгээр станцуудыг барих тусгай зөвшөөрөл олгогдоогүй байна.

1.48 Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг нарийн, тодорхой боловсруулаагүй, төлөвлөгөөнд тусгагдсан станцыг барих хөрөнгө оруулалтын талаар тодорхой тусгаагүйгээс төрийн бодлого хэрэгжихгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

1.49 Үндэслэл, тооцоололгүй олгосон СЭХ-ний тусгай зөвшөөрлүүдийг түдгэлзүүлж, СЭХ-ний талаар төрөөс баримтлах бодлого боловсруулагдаж, батлагдсаны дараа эргэж, нягталсны үндсэн дээр шийдвэрлэх нь зүйтэй байна.

Зарим аргачлал оновчтой боловсруулагдсанаар эерэг үр дүн гарчээ

1.50 ҮТЗЭ-ийн цахилгааны чадал болон энергийн тариф тооцох аргачлал, Цахилгааны чадлын төлбөр тооцох аргачлал, Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн цахилгаан эрчим хүчний үнэ тариф, бие



даасан цахилгаан /дулаан/ эрчим хүч үйлдвэрлэгчийн гэрээний гарааны үнийг тогтоох аргачлалууд оновчтой хийгдэж, зохих үр дүнгээ өгч байна.

- Цахилгааны бөөний зах зээлд системийн хэмжээнд шаардлагатай байгаа цахилгааны хэрэглээг хамгийн бага зардлаар үйлдвэрлэх төлөвлөгөө боловсруулан хуваарилах үүргийг ДҮТ ХХК-д олгосноор ҮТЗЭ-ийн цахилгааны чадал болон энергийн тариф тооцох аргачлал нь үйлдвэрлэгчдийг цахилгааны бөөний зах зээлд өрсөлдүүлэх, нийт өртгийг хямдруулах, эдийн засгийн үндэслэлтэй хийгдсэн оновчтой аргачлал болсон гэж үзэж байна.
- Цахилгааны чадлын төлбөр тооцох аргачлал нь эрчим хүчний системийн оргил ачааллын үеийн чадлын хэрэглээг бууруулах, хэрэглэгчдэд зохистой хэрэглээг бий болгох, ТЗЭ-дийн тогтмол болон хөрөнгө оруулалтын зардлыг нөхөх тарифын тогтолцоог бий болгох зэрэг ач холбогдолтой аргачлал болсон байна.
- Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн цахилгаан эрчим хүчний үнэ тариф, бие даасан цахилгаан /дулаан/ эрчим хүч үйлдвэрлэгчийн гэрээний гарааны үнийг тогтоох аргачлал нь төслийн барилга угсралтын үеэс эхлээд эрчим хүчний эх үүсвэрийг ашиглаж дуусах хүртэл бүх цаг хугацааны туршид гарах зардал болон үйлдвэрлэж түгээх эрчим хүчний биет хэмжээнд цаг хугацааны үнэ цэнийн хорогдуулалтыг тооцож, нэгж бүтээгдэхүүний үнэ өртгийг тооцож гаргасан оновчтой аргачлал болсон байна.

Зохицуулах хороо болон ТӨБЗГ-аас төрийн өмчит компаниудын төлөвлөлтийг харилцан уялдаатай хянах эрх зүйн зохицуулалт байхгүй байна

1.51 Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч ТӨХК-иуд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 2015 онд ТӨХ-гоор, 2016 онд ЭХЯ-аар, 2017 онд ТӨБЗГ-аар тус тус батлуулсан ба Зохицуулах хорооны тарифт хянасан зардлын түвшингээс уг зорилтот түвшин 28,204.8 сая төгрөгийн зөрүүтэй батлагдсан байна.

1.52 ТӨБЗГ-ын баталсан зорилтот түвшин хэрэглэгчийн тарифын 1 кВт.цагийг 171.38 төгрөг байхаар баталсан нь одоогийн хэрэглэгчийн тарифаас 29.48 төгрөгөөр илүү байна. Энэ нь эрчим хүчний салбарын ТӨХК-иудын зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг батлах, нэгдмэл байдлаар хянаж байх талаар эрх зүйн зохицуулалтгүй, ТӨБЗГ, Зохицуулах хороо харилцан уялдаагүй ажиллаж байгаагаас шалтгаалсан байна.

Хүснэгт №3. “Зорилтот түвшин болон хянасан саналын зөрүү” /сая.төг/

№	ТЗЭ	Он	Зорилтот түвшин	Тарифт хянасан санал	Зорилтот түвшин болон хянасан саналын зөрүү
1	ДЦС-2 ТӨХК	2017	19,895.90	19,361.50	534.40
2	ДЦС-3 ТӨХК	2017	111,084.10	106,363.40	4,720.70
3	ДЦС-4 ТӨХК	2016	218,229.30	216,122.90	2,106.40
		2017	230,197.90	223,428.10	6,769.80
4	ДДЦС	2016	34,259.20	35,796.20	-1,537.00
		2017	40,188.60	36,088.20	4,100.40
5	ЦДҮС	2015	35,043.60	32,291.20	2,752.40
		2016	36,163.40	35,333.10	830.30
6	УБЦТС	2015	56,006.80	50,715.70	5,291.10
7	ЭБЦТС	2015	14,437.60	14,142.80	294.80
8	БЗӨБЦТС	2015	12,878.50	10,536.90	2,341.60
Дүн			808,384.80	780,180.00	28,204.80

Эх сурвалж: ТӨБЗГ-ийн баталсан зорилтот түвшин, тариф тооцсон материалууд

Бүлэг 2. Үнэ, тарифын талаархи өнөөгийн хууль, эрх зүйн болон санхүү удирдлагын бодлого зохицуулалт нь эрчим хүчний салбарын урт хугацааны тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөхөөр байна

Үнэ тариф тогтвортой байгаа боловч ТЗЭ-дэд хуримтлал бүрдэх боломжгүй байна

2.1 Хэрэглэгчдэд борлуулах ЦЭХ-ний тарифыг нэгжийн өртөгт нь хүргэх зорилтын хүрээнд 2013 оноос хойш 5 удаагийн зохицуулалт хийгдэж ирсэн бөгөөд 2015 оны 07 дугаар сараас өнөөг хүртэл хэрэглэгчийн тарифыг өөрчлөөгүй харьцангуй тогтвортой байна.

2.2 ТБНС-ний ЦЭХ-ний нэгжийн өртөг 141.55 төг/кВт.ц, дундаж үнэ 143.88 төг/кВт.ц бол ББНС-ний ЦЭХ-ний нэгжийн өртөг 201.6 төг/кВт.ц, дундаж үнэ 124.5 төг/кВт.ц, АУНС-ний ЦЭХ-ний нэгжийн өртөг 239.0 төг/кВт.ц, дундаж үнэ 129.6 төг/кВт.ц байна.

2.3 Баруун бүсэд ЦЭХ-ний дундаж үнэ өртгөөсөө 1.8 дахин доогуур түвшинд байгаа нь тус бүсийн нэгдсэн сүлжээн дэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн онцлог болон том чадлын эх үүсвэр байхгүйгээс импортоор эрчим хүч авдаг, өртөг өндөртэй дизель станц ажиллуулж эрчим хүчээр хангаж байгаатай холбоотой байна. 2016 онд 16.3 тэрбум төгрөгийг улсын төсвөөс татаасаар олгожээ.

2.4 Эрчим хүчний салбарын хэмжээнд дулааны эрчим хүчний дундаж үнэ нэгжийн өртгөөсөө 50-75 хувиар бага байгаа дулааны эрчим хүчний борлуулалтын алдагдлыг хөндлөн татаасаар²⁰ өнөөг хүртэл нөхөж ирсэн байна.

2.5 Зохицуулах хорооноос баталсан тариф нь хэрэглэгчийн тарифыг тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлсэн хэдий ч эрчим хүчний өртөг зардлыг бууруулах арга хэмжээ аваагүй, эдийн засгийн хувьд үр ашигтай техник, технологийн шинэчлэл хийх, хуримтлал бүрдүүлэх нөхцөлийг бий болгоогүй байна.

2.6 2016 онд тарифт тооцсон зардлыг ТЗЭ-д 18.2 тэрбум төгрөгөөр хэтрүүлсэн ба ТЗЭ-чид тогтоосон тарифын хүрээнд олсон орлогоороо хуримтлалын сан бүрдүүлэх талаар хангалтгүй ажиллаж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлага үр ашигтай, арвилан хэмнэлттэй, сайн засаглалыг бүрдүүлэн ажиллаж чадахгүй байна.

2.7 Энэ нь хэрэглэгчийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах үйл ажиллагаа эрсдэлд орж болзошгүйг илтгэж байна.

Хэрэглэгчийг бага өртөгтэй эрчим хүчээр хангахад чиглэгдсэн тооцоо судалгааг үндэслэн, зарим журам, аргачлалыг шинээр болон шинэчлэн боловсруулснаар зохих үр дүн гарчээ

2.8 Зохицуулах хорооноос тодорхой чиглэлүүдээр ажлын хэсэг байгуулж, хэрэглэгчийн цахилгааны хэрэглээг зохицуулах, шөнийн бага ачааллын үед хэрэглээг дэмжих замаар эрчим хүчний системийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор ҮТЗЭ-ийн цахилгааны чадлын²¹ болон энергийн тариф²², цахилгааны чадлын төлбөр²³ тооцох аргачлалуудыг 2015 оноос хэрэгжүүлж, цахилгаан дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулснаар дараах үр дүн гарсан гэж Зохицуулах хороо үзсэн байна. Үүнд:

- Салбарын 2016 оны борлуулалтын орлогын 53.3 тэрбум төгрөг буюу 8.2 хувийг чадлын тарифаар бүрдүүлсэн.
- Оройн оргил ачааллын зөрүү 400 мВт байсан бол 2017 онд 381 мВт болж, 19 мВт-аар буурсан.
- 2016 онд 5 ДЦС-ын ДҮТ ХХК-нд худалдсан цахилгааны хэмжээ 17.6 сая.кВтц-аар нэмэгдсэнтэй холбоотой ХАЦ-ын өртөг 1,840.8 сая төгрөгөөр нэмэгдэх тооцоотой байсныг чадал, энергийн тарифыг нэвтрүүлснээр 1,343.3 сая төгрөгөөр бууруулж 497.5 сая төгрөгөөр тооцсон.
- Элэгдэл тооцох журамд Засгийн газрын буцалтгүй тусламжаар болон бусдаас үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийснээс нэмэгдэх элэгдлийн зардлыг тарифын

²⁰ Тариф болон бодит өртгийн зөрүүг цахилгааны тарифт шингээснийг хөндлөн татаас гэнэ.

²¹ ҮТЗЭ-ийн цахилгааны бөөний зах зээлд сар бүр чадал нийлүүлэхэд бэлэн байлгасны төлбөр

²² ҮТЗЭ-ийн бөөний зах зээлд гэрээний дагуу нийлүүлэх цахилгааны нэгж кВт.цаг бүрт төлөх үнэ

²³ Хэрэглэгчийн хэрэглэсэн чадлын утгыг чадлын тарифаар /хэрэглэгчийн чадлын төлбөрийн тооцоход зориулагдсан Зохицуулах хорооноос баталж нийтэлсэн үнэ/ үржүүлж тооцсон төлбөр

тооцоонд авч үзэхгүй байхаар өөрчлөлт оруулснаар 2017 онд 9.1 тэрбум төгрөгөөр элэгдлийн зардлыг бууруулсан.

- Дамжуулах, түгээх ТЗЭ-ийн тарифыг нэгж эрчим хүчинд ногдох байдлаар тогтоодог байсныг өөрчилж, үйл ажиллагааны онцлогт тохируулж сар бүр тогтмол мөнгөн дүнгээр тогтоож²⁴ эхэлсэн. Үүний үр дүнд цахилгаан түгээлт өссөн компаниудаас 2015 онд 792.9 сая төгрөг, 2016 онд 738.2 сая төгрөгөөр өртгийг хэмнэсэн.

2.9 2015 онд хэрэглэгчийг бага өртгөөр хангах, эрчим хүчний салбарын өртөг зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж, ЭХС-ын тушаал, Зохицуулах хорооны шийдвэрээр 5 ажлын хэсгийг байгуулж ажилласан боловч 2 ажлын хэсгийн үүрэг даалгавар бүрэн хэрэгжээгүй байна. /Хавсралт №10-аас үзнэ үү./

Борлуулалтын орлогыг хуваарилахдаа ДҮТ ХХК зөрчил гаргажээ

2.10 “Тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 8.6.9-д²⁵ заасны дагуу ДҮТ ХХК нь ХААН, Голомт, Худалдаа хөгжил, Капитал, Төрийн банкттай шуурхай үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна.

2.11 ДБЭХС ТӨХК Эрчим хүчний сайдын 2015 оны 178 дугаар тушаалаар батлагдсан НХА-тай загварт хамрагддаггүй бөгөөд тус загварт хамруулах ямар нэгэн шийдвэр гараагүй байхад “хүчин чадал хүрэлцэхгүй” шалтгаанаар төвийн бүсээс цахилгаан худалдан авч, төлбөрийг нь тус компанийн нэр дээрх болон “бусад” гэсэн дансанд төвлөрүүлж ирсэн байна.

2.12 Мөн тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансны мөнгөн урсгалыг зохицуулах програмд байршуулсан “бусад” гэсэн дансанд ДБЭХС ТӨХК-ний худалдан авсан болон экспортын цахилгааны төлбөр давхар төвлөрч байсантай холбоотой дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- ДБЭХС ТӨХК-аас 2016 оны 4 дүгээр сард ХХБ-аар төвлөрүүлсэн 389.1 сая төгрөгийн орлого програмын хуваарилалтад ороогүй,
- ХААН банкаар 2016 оны 6 сард төвлөрүүлсэн орлогод 36.0 сая төгрөгийн зөрүү гарсан байна.

Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансны үлдэгдлийг өдөрт нь хуваарилаагүй зөрчил гарсан байна

2.13 ДҮТ ХХК арилжааны 5 банкттай хийсэн “Шуурхай үйлчилгээний гэрээ”-нд түгээх компаниудаас нэгдсэн дансанд орлого төвлөрүүлэх цаг, тасалбар болгох хугацаа, дансыг тэг үлдэгдэлтэй болгох цагийн хуваарийг жигд тусгаагүйгээс хуваарилалт хийгдсэнээс хойш орсон орлогын гүйлгээ тухайн өдөртөө бүрэн хуваарилагдаагүй байна.

2.14 Тухайн өдөрт төвлөрсөн орлогыг амралт, баяр ёслол, хуваарилалтаас хойш хийгдсэн гүйлгээ зэргээс шалтгаалж цахилгааны төлбөр болон хүүгийн орлогыг өдөрт нь хуваарилаагүй, нэгдсэн дансыг 1-2 хоног 400.0 сая хүртэл төгрөгийн үлдэгдэлтэй байлгасан байна. Тухайлбал;

- ХХБ-аар 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдөр ДСЦТС ХХК-с төвлөрүүлсэн 400.0 сая төгрөгийг 6 дугаар сарын 24-ний өдөр хүртэл 2 хоног хуваарилаагүй;
- ХХБ-аар 2016 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ДСЦТС ТӨХК-с орсон 80.0 сая төгрөгийн гүйлгээ амралт, баяр ёслолын өдөр таарсан шалтгаанаар 2 хоног хуваарилаагүй;
- Эрчим сүлжээ ХХК-с 2016 оны 6 дугаар сарын 9-ний Пүрэв гарагт төвлөрүүлсэн 200.0 сая төгрөгийг 6 сарын 10-ны Баасан гарагт хуваарилсан;
- Эрчим сүлжээ ХХК-с 6 дугаар сарын 24-ний баасан гаригт төвлөрүүлсэн 415.0 сая төгрөгийг 6 дугаар сарын 27-ны өдрийн Даваа гарагт хуваарилсан гэх мэт.

2.15 ДҮТ ХХК нь тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансанд тухайн өдрийн гүйлгээг тасалбар болгосон цагаас хойш орсон үлдэгдэлд өдрийн 0.011, сарын 0.33, жилийн 3.0-4.0 хувийн хүү тус тус тооцуулж байгууллагын хүүгийн дансанд шилжүүлэхээр гэрээнд тусгажээ.

²⁴ Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох аргачлалын 4.1.3 дахь заалт

²⁵ ДҮТ нь тэг үлдэгдэлтэй орлогын болон орлогын нэгдсэн данснаас эрчим хүчний төлбөрийн мөнгөн урсгалын зохицуулалтад хамрагдагч тусгай зөвшөөрөл эзэмшигдийн зардлын дансуудад шилжүүлэх мөнгөний хувь хэмжээнд өөрчлөлт орсон тухай бүр энэ талаар “Эрчим хүчний төлбөрийн мөнгөн урсгалыг зохицуулагч арилжааны банк”-тай шуурхай гүйлгээ хийлгэх тухай үйлчилгээний аж ахуйн гэрээнд өөрчлөлт оруулж мөрдөнө.



2.16 2016 онд НХА-тай загварын борлуулалтын орлогын дансны үлдэгдэлд банкнаас 84.5 сая төгрөгийн хүү тооцож олгосон бөгөөд Зохицуулах хорооноос зөвшөөрсний дагуу ДҮТ ХХК нь өөрийн үйл ажиллагаанд зарцуулжээ.

2.17 ДҮТ ХХК НХА-ын загварыг тушаал, шийдвэрийн дагуу мөрдөөгүй, хууль, дүрмээр заасан үүргээ хангалтгүй хэрэгжүүлснээс нэгдсэн сүлжээний үйл ажиллагаа, тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансны үндсэн зарчим зөрчигдөж байна.

2.18 Иймд ДҮТ ХХК-аас арилжааны банкуудтай хийсэн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж хариуцлага тооцох, мөнгөн урсгалыг зохицуулж буй програм хангамжийг шинэчлэх талаар 825.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлагыг ДҮТ ХХК-ийн захирал Ц.Балдоржид хүргүүлэв.

2.19 Цаашид тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх нь зүйтэй.

ДҮТ ХХК нь эрчим хүчний хэрэглээний балансын батлагдсан төлөвлөгөөг мөрдөөгүйгээс үр ашиггүй худалдан авалт хийсэн байна

2.20 Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын даргын баталсан Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний 2017 оны цахилгаан эрчим хүчний хэрэглээний балансын төлөвлөгөөгөөр ДҮТ ХХК Соларповер интернэйшнл ХХК-иас 2017 оны 1 дүгээр улиралд 905.9 сая төгрөгийн 2.2 сая кВт.ц энерги худалдан авахаас 1,805.0 сая төгрөгийн 4.4 сая кВт.ц энерги худалдан авч өндөр үнэтэй цахилгаан станцыг ачаалласнаар 988.9 сая төгрөгийн /НӨАТ орсноор/ өглөг үүсгэн үр ашиггүй ажилласан байна.

2.21 ДҮТ ХХК нь батлагдсан төлөвлөгөөг мөрдөөгүйгээс үр ашиггүй худалдан авалт хийж Нэгдсэн сүлжээний дүрмийн 8.1.5 дахь “ДҮТ-өөс нэгдсэн сүлжээний өдөр тутмын горимын тохируулга хийхдээ хэрэглэгчийг хамгийн хямд өртөгтэй цахилгаанаар хангах зарчмыг баримтлан, техник технологийн шаардлагад нийцүүлэн зохицуулалт хийнэ.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Бүлэг 3. Үнэ тарифын зохицуулалт болон тусгай зөвшөөрөл олголтод тавигдах хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрэн бүрдээгүй байна.

Үнэ тарифыг тогтоох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн, байнгын хяналтын тогтолцоо шаардлагатай байна

3.1 Зохицуулах хороо 2016 онд нийт 94 удаа хуралдаж ТЗЭ-ийн үнэ тарифыг шинэчлэн тогтоох замаар 31.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байна. ҮТЗЭ-дэд тодорхой эх үүсвэрийг дахин шийдвэрлэж өгсөн нь Зохицуулах хорооны 2014 оны 231 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох аргачлал”-ыг баримтлаагүйг харуулж байна. Тухайлбал,

ДЦС-2:

- 2016 оны 189 дугаар тогтоолоор 1,178.3 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, нүүрсний үнэ нэмэгдсэнд /индексжүүлэлт/ 57.3 сая төгрөг, нүүрсний хуримтлагдсан өр төлбөр барагдуулахад 1,121.0 сая төгрөг,
- 2015 оны 302 дугаар тогтоолоор 873.5 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, нүүрсний хуримтлагдсан өр төлбөр барагдуулахад,

ДЦС-3:

- 2015 оны 318 дугаар тогтоолоор 1,300.0 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэж ДзДЦС ТӨХК-ийн турбины шинэчлэлийн төслийн ажилд санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор, /хавсралт №14-өөс дэлгэрэнгүйг үзнэ үү./

ДЦС-4:

- 2015 оны 303-р тогтоолоор 2,000.0 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, нүүрсний хуримтлагдсан өр төлбөр барагдуулахад,

ДДЦС:

- 2015 оны 320-р тогтоолоор 1,703.2 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, Шарын голын уурхайн нүүрсний үнэ нэмэгдсэнд /индексжүүлэлт/ 332.2 сая төгрөгийг хуримтлагдсан нүүрсний өр төлбөр барагдуулахад,
- 2016 оны 134-р тогтоолоор 1,122.0 сая төгрөгийг шийдвэрлэж, 2-р турбиныг худалдаж авах эх үүсвэр бүрдүүлэхэд,

ЭДЦС:

- 2016 оны 242-р тогтоолоор 500.0 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, 1-р зуухны удирдлага, хяналтыг компьютер системд шилжүүлэх ажлын хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр тус тус шийдвэрлэсэн байна.

3.2 Түлш, сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардлыг оны эхэнд тарифын тооцоонд тусгасан байхад нүүрсний өр барагдуулах, худалдан авалт хийх зэрэг үндэслэлээр ТЗЭ-ээс дахин тарифын санал ирүүлснийг Зохицуулах хороо хянаж, эх үүсвэр шийдвэрлэж байсан байна.

3.3 Мөн ЭХЯ, МЭХГУУ-н үйлдвэрчний эвлэлийн холбоо, МЭХА-ын хамтарсан 3 талт “Эрчим хүчний салбарын хамтын /тариф/ хэлэлцээр”-ийг үндэслэн урлаг, спорт олон нийтийн арга хэмжээ, баяр ёслол тэмдэглэх зэрэг 2,598.6 сая төгрөгийн үйлдвэрлэлийн бус зардлыг тарифт тооцсон нь Зохицуулах хорооны 2014 оны 231 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох аргачлал”-ын 3.4²⁶ дэх заалтыг баримтлаагүй байна.

Хүснэгт №4. “Үйлдвэрлэлийн бус зардлыг тарифт тооцсон байдал” /сая төг/

ТЗЭ	Он	ТЗЭ-ийн зорилтот түвшин	Хасагдах зардлын дүн			Тарифт тооцвол зохих дүн	Тарифт тооцсон дүн	Зөрүү
			Урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээ	Баяр ёслолын арга хэмжээ	Нийт дүн			
			1	2	3			
ДЦС-2	2016	472.3	52.8	67.2	120.0	352.2	452.8	100.5
	2017	552.7	26.3	54.0	80.3	472.3	542.7	70.3
ДЦС-3	2015	2,470.9	100.1	36.0	136.1	2,334.8	2,451.3	116.5
	2017	1,637.3	94.7	46.0	140.7	1,496.5	1,731.4	234.8
ДЦС-4	2016	2,543.6	88.8	9.6	98.4	2,445.1	2,543.6	98.4
	2017	2,971.5	117.3	9.6	126.9	2,844.5	2,904.7	60.1

²⁶ “Үнэ тариф тооцож буй зардалд тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд хамааралгүй, бүх төрлийн шагнал урамшуулал, тэтгэмж, бусад өгсөн хандив, бэлгэ дурсгал, хүлээн авалт, туслах аж ахуй, амралт, сувилал, гуанз, цайны газрын зардал ба бусад үйлдвэрлэлийн бус үйлчилгээний зардлыг оруулахгүй”

ЦДҮС	2016	1,845.4	79.5	176.3	255.8	1,589.5	2,421.9	832.3
	2017	2,096.4	71.7	181.4	253.2	1,843.3	2,097.7	254.4
УБДС	2015	533.5	44.8	-	44.8	488.6	1,212.2	723.6
	2016	672.6	38.0	9.0	47.0	625.6	672.6	47.0
	2017	849.0	41.0	45.4	86.4	762.6	822.9	60.3
Нийт		16,645.5	755.4	634.6	1,390.1	15,255.5	17,854.4	2,598.6

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо

3.4 Дээрх зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлж, цаашид тарифт эдгээр зардал тусгагдахгүй тул үр өгөөжөөр бүртгэв.

3.5 Эдгээр зөрчлүүд нь ТЗЭ-дийн тарифын саналыг Зохицуулах хорооны УТХ тооцоолох явцад дотоод болон хөндлөнгийн байнгын хяналт хийх зохицуулалт байхгүйтэй холбоотой байна.

Үнэ тарифын зохицуулалтыг хэрэгжүүлэх талаар Зохицуулах хорооноос ТЗЭ-дэд хийсэн шалгалтын хамрах хүрээ хангалттай биш, ХШХ-ийн үйл ажиллагаа үр дүнгүй байна

3.6 УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2015 оны 02 дугаар тогтоолын дагуу Эрчим хүчний сайдын 2015 оны 54 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэг 2015 оны 2 дугаар улиралд төрийн өмчийн 14 эрчим хүчний компанийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

3.7 Уг тушаалын хэрэгжилтийг шалгахад дараах асуудлуудыг хэрэгжүүлээгүй байна.

- Эрчим хүчний салбарын ажиллагсдын цалин, нийгмийн зардлыг нэмэгдүүлэхдээ салбарын хэмжээнд нээгдсэн бодлогоор зохицуулах асуудлыг судалж, санал боловсруулах ажлын хэсэг байгуулж дүгнэлт гаргах үүргийг тус яамны ТЗУГ хэрэгжүүлж ажиллаагүй,
- Компаниудын санхүүгийн байдал, ашиг алдагдлын шалтгаан нөхцөлийг судалж тогтоох, төлөвлөгөөнд тусгагдсан зардлуудын үндэслэл, тооцоолол хангалтгүй байгаад дүгнэлт хийж, эх үүсвэргүй хөрөнгө мөнгөний асуудал шийдвэрлэсэн компаниудын ТУЗ-д холбогдох арга хэмжээ тооцсон баримт байхгүй,
- Цалин нэмэгдүүлсэн зарим компанийн гүйцэтгэх удирдлагад арга хэмжээ тооцуулах шийдвэрийг ТУЗ-өөс хэрэгжүүлж ажиллаагүй,
- Өртөг зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх боломж бүхий компаниудын ТӨХ баталсан 2015 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тодотгол хийгээгүй байна.

3.8 Зохицуулах хорооны ХШХ 2016 онд 5, 2017 оны эхний хагаст 3 байгууллагад хяналт шалгалт хийхээс 2 байгууллагад хийсэн нь тоо хэмжээний хувьд хангалтгүй байна. Мөн эрчим хүчний гэрээт борлуулагч, эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах нүүрс нийлүүлэх уурхайд хяналт шалгалт тайлант онд хийгдээгүй нь журмын 3.1 дэх заалтын дагуу үйлчлэх хүрээнд хамаарах байгууллагыг бүрэн хамруулахгүй байгааг харуулж байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйн улмаас тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд зөрчил, дутагдал давтагдан гарсаар байна

3.9 УАГ-аас 2016 онд эрчим хүчний тусгай зөвшөөрөл олголтын байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн Зохицуулах хорооны үйл ажиллагаанд хамаарах зарим зөвлөмжийн биелэлтийг шалгахад дараах асуудлууд илэрлээ.

3.10 Зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж, мөрдөх чиглэлээр өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй, ТЗЭ-ийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тооцохдоо Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлалын 3.1.3-т заасан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг үл ялгаварлах” зарчмыг хангуулж ажиллаагүй байна.

3.11 Улсын төсөвт төвлөрүүлэх тэмдэгтийн хураамжийн бүрдэлтэд хяналт тавих, журамд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах чиглэлээр өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй, тэмдэгтийн хураамж төлөөгүй 10 ААН-д тусгай зөвшөөрөл шинээр олгосноор улсын төсөвт төвлөрөх 213.2 сая төгрөгийн орлого тасалдсан байна.

3.12 Зохицуулах хорооны үйл ажиллагаанд тавих дотоод аудитын нэгжийг байгуулах, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй, 2015, 2016 онд зохицуулалтын үйлчилгээний 306.5 сая төгрөгийн хөлс дутуу төвлөрүүлсэн ба зарим ТЗЭ зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөөгүй үйл ажиллагаа явуулж байгаа нь ЭХЗХ-ны 2014 оны 191 дүгээр тогтоолын хавсралт, тусгай

зөвшөөрлийн харилцааг зохицуулах журмын 6.2²⁷-т заасныг зөрчсөн байна. /Хавсралт №2-оос үзнэ үү/

3.13 Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд холбогдох хууль эрх зүйн зарим заалтуудыг мөрдөөгүй тохиолдол цөөнгүй байгаа бөгөөд өмнө хийгдсэн аудитаар илэрсэн зөрчил, дутагдал арилаагүй зэрэг нь тус хорооны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтын тогтолцоо шаардлагатай болохыг илтгэж байна.

3.14 Энэ нь тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт шалгалт дутагдалтай, үр нөлөө нь хангалтгүй байгааг нотолж байгаа тул 213.2 сая төгрөгийн акт тавьж, 306.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлагыг Зохицуулах хорооны дарга А.Тлейханд хүргүүлэв.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг зохих ёсоор хэрэгжүүлээгүй байна

3.15 Эрчим хүчний барилга, байгууламж барих тусгай зөвшөөрлийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө ирүүлээгүй 10 ААН-д, эрчим хүчний ашиглалтын тусгай зөвшөөрлийг хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэрийн бичиг баримт, хөрөнгө оруулалтын баталгаа ирүүлээгүй 2015-2016 онд 16 ААН-д тус тус олгосон нь ЭХТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.2.6-21.2.9²⁸, 21.7²⁹, ЭХЗХ-ны 2014 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах журам”³⁰-ыг зөрчжээ. /Хавсралт №3,4-өөс үзнэ үү./

3.16 Зохицуулах хороо нь ЭХТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.3-дахь “...шаардлагатай гэж үзвэл өргөдөл, түүнд хавсаргасан баримтын талаар дүгнэлт гаргуулахаар хөндлөнгийн шинжээч томилж болно” заалтыг хэрэгжүүлэх талаар санаачилга гаргаж байгаагүй, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрдээгүйгээс зөрчил дутагдал давтагдан гарсаар байна.

3.17 УБДС ТӨХК дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөлгүй 420 иргэн, ААН-тэй худалдах, худалдан авах гэрээ байгуулж, үйл ажиллагаа явуулж байгаа нь ЭХТХ-ийн 17.1³¹, 30.1.13³², Зохицуулах хорооны 2014 оны 190 дүгээр тогтоолын хавсралт тусгай зөвшөөрлийн зохицуулалтын бодлого чиглэлийн 6.3³³ дахь хэсэгтэй нийцэхгүй байна.

3.18 Эдгээр иргэн, ААН дулааны эрчим хүчийг УБДС ТӨХК-аас Зохицуулах хорооны баталсан дулааны тарифаар тооцож авдаг бөгөөд харъяалагдах аж ахуйн нэгж байгууллагаас эзлэхүүнээр төг/м³, айл өрхөөс талбайгаар м²-аар тооцож борлуулалтын орлогыг авдаг байна. 2017 онд эхний 8 сарын байдлаар нийт 23.8 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж 16.6 тэрбум төгрөг УБДС ТӨХК-д орж, борлуулалтын орлогын 33 хувь буюу 7.7 тэрбум төгрөг эдгээр иргэн, ААН-д үлдэж байна.

²⁷ хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн гэрчилгээг авахаас өмнө улсын тэмдэгтийн хураамжийн төлбөр, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан үйлчилгээний төлбөр, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг ЭХЗХ-нд төлсөн байна.

²⁸ 21.2. Сонирхогч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөлдөө эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан дараахь бичиг баримтыг хавсаргана:

21.2.1. техник, эдийн засгийн үндэслэл;

21.2.6. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

21.2.7. байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;

21.2.8. тухайн хуулийн этгээдийн санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи;

21.2.9. үйл ажиллагаагаа эхлэх хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр;

²⁹ Тусгай зөвшөөрлийг санхүүгийн чадавхитай, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан буюу явуулах боломжтой энэ хуулийн 9.1.3-т заасан нөхцөл, шаардлага хангасан хуулийн этгээдэд олгоно.

³⁰ Гурав. Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах суурь зарчмууд

3.1.4 байгаль орчинд сөрөг нөлөөгүй, цэвэр технологийг хэрэглэх буюу сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ төлөвлөгдсөн байх

2014 оны 11 дүгээр сарын 19 өдрийн 191 дүгээр тогтоолын хавсралт тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах журмын 2.6 дахь хэсэгт тусгай зөвшөөрлийн цахим системээс хуулийн этгээдийн өргөдлийг баталгаажуулсан талаар мэдээлэл ирэхэд тусгай зөвшөөрөл хүсээг дараах баримт материалыг эх хувиар ЭХЗХ-нд ирүүлнэ. 2.6.4 Байгаль орчны үнэлгээ,

Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах журмын хавсралт, Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх бичиг баримт

³¹ Эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс цахилгаан, дулаан худалдан авах, цахилгаан импортлох, цахилгаан, дулааныг хэрэглэгчид худалдах эрхийг олгоно.

³² Нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх.

³³ Цахилгаан, дулаан түгээх үйл ажиллагаа эдийн засгийн хувьд үр ашигтай байх нөхцөлийг шалгуур болгон жилийн нийт түгээлт 80 сая кВт-аас их, дулааны нийт чадал 10 Гкал-аас их байх нөхцөлд цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл олгох зарчим баримтална.


3.19 УБДС ТӨХК нь ЭХТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.3³⁴ дугаар заалтыг үндэслэн эдгээр иргэн ААН-тэй гэрээ байгуулж ажилласан боловч ДЭХ-ний хувьд гэрээт борлуулагч ажиллуулах нь аж аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8.3 дахь заалттай зөрчилдөж байгаа тул гэрээт борлуулагч ажиллуулах боломжгүй тухай зөвлөмж яам, зохицуулах хорооноос хүргүүлсний дагуу 2017-2018 оны халаалтын улиралд орон сууцны ашиглалтыг хариуцуулахаар тусгай зөвшөөрөлтэй компани руу гэрээг шилжүүлэх шаардлагатай байна. Эдгээр иргэн, ААН-ийн дулааны гэрээг ТЗЭ-чид шилжүүлэх асуудлыг шийдэхгүй өнөөг хүрсэн нь дараах хүндрэл бэрхшээлийг үүсгэж байна. Үүнд:

- Олон жилийн хуримтлагдсан өртэй ААН-үүдийг ОСНААУГ-ын харьяа ХҮТ-үүд өөрийн харьяалалд аваагүй,
- Удаан хугацаанд орон сууц барьж үйл ажиллагаа явуулж байгаа зарим компаниуд тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг хангахгүй байх,
- Өөрийн хөрөнгөөр ажилчдын орон сууц барьсан ААН тусгай зөвшөөрөлтэй компанитай нэгтгэн нийлүүлэхэд хөрөнгөтэй нь хамт худалдан авахгүй бол ТЗЭ-тэй нэгдэхгүй байх,
- Үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа зарим ААН-үүд 10 Гкал дулаан хэрэглээний хүчин чадал хүрдэггүй учир тусгай зөвшөөрөл авах боломжгүй байх,
- Орон сууцны барилгын дулааны ашиглалтыг нийслэлийн орон сууцны контор хариуцан ажилладаг боловч, өмч бүртгэгдээгүй шалтгаанаар гэмтэл, засварыг хийхгүй удааширч, хэрэглэгчдээр зардлыг гаргуулан засах зэрэг хүндрэл байна.

3.20 ЭХС-ын зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар хурал болон Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 107 дугаар тогтоолоор дулааны эрчим хүчний хангах тусгай зөвшөөрөлгүй иргэн, аж ахуйн нэгж, СӨХ-тэй дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг хуульд нийцүүлэн байгуулж ажиллахыг УБДС ТӨХК-д үүрэг болгосон байна.

3.21 УБДС ТӨХК-ийн захирлын 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/56 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан 420 хэрэглэгчдийг ДЭХ-ний тооцоот ачаалал болон бусад техникийн нөхцөл шаардлага зэргийг үндэслэн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага хангасан хэрэглэгч, Эрчим хүчний тухай хууль-ийн 17 дугаар зүйлийн 17.3-т заасны дагуу гэрээт борлуулагчаар ажиллах хэрэглэгч, бусад хэрэглэгч гэсэн ангилалаар хуваан ажилласан байна.

Зураг №16. “Тусгай зөвшөөрөлгүй иргэн, ААН-ын борлуулалтын орлогын харьцаа /сая.төг/”



Эх үүсвэр: ЭХЗХ. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн дулаан түгээх, хангах үйл ажиллагааны талаар хийсэн танилцуулга, УБДС ТӨХК-ний судалгаа.

3.22 Цаашид дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрлийн зохицуулалтын бодлого чиглэлийг хэрэгжүүлэхдээ хуульд нийцүүлэн худалдах, худалдан авах гэрээг ТЗЭ-тэй хийхээр зохицуулах шаардлагатай байна.

³⁴ 17.3.Эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэр дээрх зарим хэрэглэгчдийн цахилгаан, дулааны борлуулалтыг иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Гэрээт борлуулагчид худалдах үнэ, төлөх шимтгэлийг хоорондын гэрээгээр тохиролцох ба хэрэглэгчид Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон үнээр худалдана. /2015 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр орсон заалт/

3.23 Эдгээр хувийн хэвшлийн компаниудыг хууль, эрх зүй, бодлогын зохицуулалтад оруулснаар дулааны орлого нэмэгдэх, хэрэглэгчдийн дулаан хангамж найдвартай болох, өргөдөл гомдол буурах, цахилгааны хөндлөн татаас тодорхой хэмжээгээр багасах, эрчим хүчний тусгай зөвшөөрөл эмх цэгцтэй болох боломж бүрдэнэ.

3.24 Зарим ТЗЭ-дийн хэрэгжүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалт үр ашиггүй болсон байна. Тухайлбал,

- ДЦС-4 ТӨХК-д хэрэгжсэн хөргөх цамхаг байгуулах төсөл арга хэмжээ нь технологийн хувьд станцын хүчин чадал нэмэгдүүлэх чухал төсөл байсан боловч захиалагч байгуулага нь хууль журмын дагуу ажлаа зохион байгуулаагүйгээс чадваргүй гүйцэтгэгч шалгаруулж, чанаргүй байгууламж бариулснаас хойш 3.6 сая ам долларын хөрөнгө зарцуулсан боловч өнөөг хүртэл үр дүн гараагүй байна. Хөргөх цамхаг ажиллагаанд ороогүй тохиодолд 5.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж өргөтгөсөн ТГ-6 турбин генераторыг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах боломжгүй болох эрсдэл үүссэн байна. /Хавсралт 11-ээс үзнэ үү./
- ДЦС-4 ТӨХК ПТ-80-130 ТГ-6 турбины хүчин чадлыг 20 МВт-аар нэмэгдүүлсэн шинэчлэлийн ажил хийгдсэнээр турбины хүчин чадал нэмэгдэж, станцад эдийн засгийн хувьд ашигтай байсан ч худалдан авах ажиллагаа, ашиглалтад оруулах үйл явц хууль тогтоомжийн хүрээнд хийгдээгүй байна. /Хавсралт 12-оос үзнэ үү./
- ЦДҮС ТӨХК-ийн удирдлага “Үйлдвэрлэл, техникийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүдийн ээлжит бус хурал”-аас трансформаторыг буцаан солих шийдвэр гаргасан нь техникийн хувьд хамгийн боломжтой боловч эдийн засгийн хувьд 2.8 тэрбум төгрөгийн шууд алдагдал хүлээсэн байна. /Хавсралт 12-оос үзнэ үү./

Зохицуулалтын үйлчилгээний хөлс хяналтгүй зарцуулагдаж байна

3.25 Зохицуулах хорооны 2017 оны үйл ажиллагааны зардал 2015 оноос 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба зарим төрлийн зардал хэтэрсэн, үр ашиггүй зарцуулсан нь зохицуулалтын үйлчилгээний хөлсний төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт хангалтгүйтэй холбоотой байна.

3.26 Мөн тарифт тооцсон зардалд туссан зохицуулалтын үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлж авсан тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал,

- 2015 онд ДЦС-2 ТӨХК-аас 45.1 сая төгрөгийг,
- 2016 онд ДЦС-4 ТӨХК-аас 147.0 сая төгрөгийг,
- 2017 онд ЭБЦТС ТӨХК-аас 20.3 сая төгрөгийг тус тус илүү тооцож авсан гэх мэт.

3.27 Энэ нь Зохицуулах хорооны баталсан зохицуулалттай үйлчилгээний хөлс тооцох аргачалд ТЗЭ-дэд үзүүлж байгаа үйлчилгээ адил атал тооцон авч байгаа зохицуулах үйлчилгээний хөлс тухайн ТЗЭ-ийн суурилагдсан хүчин чадлын хэмжээнээс хамаарч ялгаатай байдлаар тогтоогдож байгаатай холбоотой байна.

3.28 Зохицуулах хорооны ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тусламж, дэмжлэг үзүүлэх зардал байнга хэтэрч иржээ. Тухайлбал:

- Ажилтнуудад үзүүлсэн тусламж, дэмжлэг өнгөрсөн онд 77.3 сая төгрөгөөр хэтэрсэн бол 2017 оны эхний улирлын байдлаар бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотой энэ зардал төлөвлөгөөнөөс 20.8 сая төгрөгөөр илүү зарцуулагдсан байна;

3.29 Монгол Улсын Ерөнхий сайдын “Ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай” 2016 оны 88 дугаар захирамжаар Зохицуулах хорооны өмнөх удирдлага 2016 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр ажлаас чөлөөлөгдсөн байтал ахлах нягтлан бодогч Д.Мөнхболд 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүртэлх хугацаанд С.Отгонбаярын гарын үсгээр нийтдээ 6 удаагийн 216.2 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 5.1.2³⁵, 5.1.3³⁶, 5.1.5³⁷, 6.3.2³⁸, 6.4.1³⁹, 6.6.8⁴⁰, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.2.4⁴¹, 14.14.3⁴², 20.1.2⁴³ гэж заасныг тус тус зөрчсөн байна. Үүнд:

³⁵ “төсвийн иж бүрэн үнэн зөв байдлыг хангасан байх”;

³⁶ “санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”;

³⁷ “хариуцлагатай байх”;

³⁸ “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж тайлагнах”;

³⁹ “төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах”;

⁴⁰ “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”;

⁴¹ төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь 4.1.1-т заасныг дагаж мөрдөнө”;

⁴² “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэх”

⁴³ нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах”

- Эрчим хүчний зохицуулах хорооны даргын 2016 оны “Мөнгөн тусламж үзүүлэх тухай” А/96 тоот тушаалаар нэр бүхий 15 ажилтанд орон сууцны зээлэнд хамрагдах, нөхцөл сайжруулах зорилгоор 11 дүгээр сарын 4-ний өдөр нийт 155.0 сая төгрөгийн,
- 2016 оны “Тэтгэмж олгох тухай” А/113 тоот тушаалаар орон тооны зохицуулагчид бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөний тэтгэмжинд олгох 11 дүгээр сарын 4-ний өдөр 12.5 сая төгрөгийн,
- Ажилтан албан хаагчдын 11 дүгээр сарын урьдчилгаа цалинд 11 дүгээр сарын 10-ны өдөр 45.5 сая төгрөгийн,
- Таванбогд ХХК-с автомашины өвлийн дугуй худалдан авахад 11 дүгээр сарын 11-ний өдөр 1.9 сая төгрөгийн; СЭБОЦЭ ХХК-с автомашины өвлийн дугуй худалдан авахад 11 дүгээр сарын 11 -ний өдөр 0.7 сая төгрөгийн;
- Юнивишн ХХК-д интернет үйлчилгээний төлбөрт 11 дүгээр сарын 11-ний өдөр 0.6 сая төгрөгийн гүйлгээг тус тус хийсэн байна.

3.30 Иймд эрх зүйн чадамжгүй хүний гарын үсгээр зарцуулагдсан 216.2 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж, арилгуулах шаардлагатай гэж үзлээ.

3.31 Зохицуулах хорооны ажлын алба нь эрчим хүчний зохицуулалтын болон хэмнэлтийн газар, 6 хэлтэст нийт 68 орон тоотой үйл ажиллагаа явуулж байгаа боловч гэрээт ажилтан хөлсөөр ажиллуулж байгаа нь үндсэн чиг үүргийн давхардал бий болгож байна. Тухайлбал:

- Эрчим хүчний үнэ тариф тооцох аргачлал өнөөгийн байдал, олон улсын туршлагыг нэвтрүүлэх боломжтой эсэхийг судлах, ДЦС-уудын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах арга замыг судалж, сайжруулах;
- Эрчим хүчний үндэсний балансын бүтэц, аргачлалыг судлах зэрэг байгууллагын үндсэн чиг үүрэгт хамрах мэргэжлийн ажлуудыг гүйцэтгүүлэх, ТЗЭ-д эрчим хүчний гэрээт борлуулагчийн үйл ажиллагаанд зохицуулалтын хяналт шалгалт хийхэд дүгнэлт гаргах;
- Хяналт шалгалт хийх удирдамж төлөвлөгөө боловсруулах, шалгалтын тэмдэглэл, танилцуулга холбогдох материал боловсруулах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний шийдвэрийн төслийг боловсруулах, үр ашгийг нэмэгдүүлэх өртөг зардлыг бууруулах талаар санал боловсруулах гэх мэт.

3.32 Зохицуулах хорооны удирдлагын болон санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн, байнгын хяналтын тогтолцоо бүрдүүлэх замаар үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй үйл ажиллагааг гаргуулахгүй байх боломжтой.

Холбогдох байгууллагын санал



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 29,
Утас: 32-01-28, Факс: (976-11) 31-93-35,
E-mail: info@eng.mn

2017.04.16 № 5/724

таний _____ -ны № _____ -т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ
С.ОЮУНБИЛЭГ ТАНАА**

Үндэсний аудитын газраас Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад, холбогдох саналыг хавсралтаар хүргүүлж байна.



ДАРГА  АТЛЕЙХАН

20170416



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС
ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ**

Үндэсний аудитын газраас Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Тайлбар №1-ийг харна уу.

- 1. Бүлэг 1. Үнэ тарифыг хуулиар тогтоосон зарчмын дагуу тогтоогоогүй байна:** Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-д тариф тогтооход баримтлах зарчмуудыг нарийвчлан тодорхойлсон байдаг. Бүлэг 1-ийн хүрээнд бичигдсэн тайланд хуулиар тодорхойлсон аль зарчмыг хэрхэн зөрчсөн нь тодорхойгүй байна. Иймд Бүлэг 1-ийн агуулгыг “Эрчим хүчний үнэ тарифыг хуульд тодорхойлсон зарчмын хүрээнд тогтоох явцад зарим хүндрэл гарч байна” гэж өөрчлөх саналтай байна.

Тайлбар №2-ыг харна уу.

- 2. Бүлэг 1. Дэд хэсэг. Зарим тохиолдолд зохицуулагчид эрчим хүчний үнэ тарифыг үндэслэлгүй тогтоож иржээ, Тайлангийн 1.1-1.5 хэсэг:** Дэд хэсгийн агуулгыг “Зарим тохиолдолд зохицуулагч нар эрчим хүчний үнэ тарифыг ТЗЭ-гчдийн саналд үндэслэн тогтоож иржээ” гэж өөрчлөх саналтай байна.

Зохицуулагч нар зарим тохиолдолд Хорооны хуралд тарифын асуудал хариуцсан хэлтсийн танилцуулсан саналаас нэмэгдүүлэх байдлаар шийдвэр гаргасныг үнэ тарифыг үндэслэлгүй нэмэгдүүлсэн гэж дүгнэсэн байна. Тарифын санал хянах, шалгах журмын 8.3-ийн дагуу зохицуулагч нар Хорооны тарифын асуудал хариуцсан хэлтэс болон бусад оролцогч (тусгай зөвшөөрөл эзэмшигч)-оос ирүүлсэн саналыг үндэслэн шийдвэр гаргах эрхтэй байдаг.

Тайлбар №3-ыг харна уу.

- 3. Бүлэг 1. Дэд хэсэг. Үнэ тариф тогтооход баримталж байгаа аргачлал нь хуулиар тогтоосон зарчмыг хангаагүй, бодит өртөг, зардалд тулгуурлаагүй байна, Тайлангийн 1.15-1.23 хэсэг:** Дэд хэсгийн агуулгыг “Үнэ тариф тогтоох аргачлалыг зохицуулалттай өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллахад бэлтгэн сайжруулалт хийх шаардлагатай байна” гэж өөрчлөх саналтай байна.

1.15 хэсэг: Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын санхүүгийн тайланд эрх бүхий аудиторов компаниуд хөндлөнгийн аудит хийж, үнэн зөв байдлыг баталгаажуулдаг. Энэхүү баталгаажсан санхүүгийн тайлан дээр тусгагдсан өртөг, зардлыг тус Хорооны зүгээс бодит өртөг, зардал гэж авч үздэг. Аудитаар баталгаажсан



Тайлбар №4-ийг харна уу.

санхүүгийн тайлан дээрх өртөг, зардлаас өөр бодитой гэж авч үзэх баримт материал байхгүй байна.

Тайлбар №5-ыг харна уу.

1.16 хэсэг: ТЗЭ-ийн тухайн ажил үйлчилгээнд зарцуулагдах норматив хэмжээг холбогдох дүрэм, журам (аюулгүй ажиллагааны дүрэм, техник ашиглалтын дүрэм, татвар, хууль шийдвэрийн өөрчлөлт, цахилгаан, дулааны хэрэглээ гэх мэт)-ын дагуу гарч байгаа зардлын өмнөх 3 жилийн гүйцэтгэлд үндэслэн, үйлчилгээний биет хэмжээнээс хамааруулан тооцдог. Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүчин чадлын өргөтгөл, үйлчлэх хүрээний өөрчлөлттэй хамааруулан авч үздэг.

Тайлбар 6. Мэдээллийн чанартай тайлбар тул тайланд оруулах шаардлагагүй

1.17 хэсэг: Үнэ тариф тогтоох аргачлалын 3.5, 3.6 дах хэсэгт эрчим хүчний үнэ тарифыг хямдруулах, үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулах чиглэлээр зохицуулалт хийх боломжтой талаар тусгасан байдаг. Гэхдээ олон улсын практикт үнэ тарифыг хямдруулах, өртөг зардлыг бууруулах, арвилан хэмнэлт гаргах хөшүүрэг нь тариф тооцох аргачлал бус эрчим хүчний салбарын өрсөлдөөнт зах зээлийн зарчим байдаг.

Тайлбар 7. Мэдээллийн чанартай тайлбар тул тайланд оруулах шаардлагагүй

1.22 хэсэг: 2015 оны 7 дугаар сард хэрэглэгчийн тарифыг нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан. 2016 онд эрчим хүчний салбарт борлуулалтын орлогын 2 төрлийн өсөлт гарах боломж бүрдсэн. Үүнд: 1. 2015 онд нэмэгдсэн хэрэглэгчийн тарифын орлого 2016 онд бүтэн жилээр нэмэгдэж орсон; 2. 2016 онд 2015 оны гүйцэтгэлээс цахилгаан үйлдвэрлэл, борлуулалт 3.8 хувь, дулаан 4.0 хувиар нэмэгдсэн;

Тайлбар №8-ыг харна уу.

2015 оны гүйцэтгэлээс 2016 оны үйлдвэрлэлтийн төлөвлөгөөг нэмэгдүүлж төлөвлөөд, уг төлөвлөсөн хэмжээнд гүйцэтгэл гарч буй тохиолдолд тарифт нэмж тусгасан зардлын өсөлтийг алдагдалгүйгээр бүрэн нөхөх боломжтой бөгөөд энэхүү нөхцөл байдлыг тодорхойлсны үндсэн дээр 2016 оны тарифын зохицуулалтыг хийсэн болно. Тиймээс 79.5 тэрбум төгрөгийг тарифт нэмж тусгаад оны эцэст алдагдалгүй гарч байгаа нь тарифын төлөвлөлтийг үндэслэлтэй хийснийг баталж буй үзүүлэлт юм.

4. Бүлэг 1. Дэд хэсэг. Үнэ тариф тооцох зардлын 30 хувийг бүрдүүлж байгаа түлшний хэмжээг тооцоолох коэффициентүүдийг туршилтаар баталгаажуулах, шинэчлэн тогтоох шаардлагатай байна, Тайлангийн 1.24-1.27 хэсэг:

1.24 хэсэг: ДЦС-уудын нүүрсний зарцуулалтад олон хүчин зүйлс нөлөөлдөг ба үүнээс голлож дараах 3 үзүүлэлт чухал нөлөө үзүүлдэг. Үүнд: 1. Цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн хэмжээ; 2. Жишмэл түлшний хувийн зарцуулалт /түлшний хэмжээг тооцоолох коэффициент/; 3. Уурхайгаас нийлүүлэх нүүрсний илчлэг;

Энэхүү тайлангийн 1.24 хэсэгт дээрх 3 хүчин зүйлийн эхний 2-ийг авч үзсэн байна. Хүчин зүйлээр задалж авч үзвэл ДЦС-2 ТӨХК-ийн нүүрсний зарцуулалтын бууралт нь 100% илчлэгийн өсөлт, ДЦС-3 ТӨХК-ийн хувьд 61.5% илчлэгийн өсөлт, 38.5% жишмэл түлшний хувийн зарцуулалтын бууралт, ДЦС-4 ТӨХК-ийн хувьд 34.0% үйлдвэрлэлтийн бууралт, 31.0% жишмэл түлшний зарцуулалтын бууралт, 35.1% нь илчлэгийн өсөлт, Дарханы ДЦС ТӨХК-ийн хувьд 8.1% үйлдвэрлэлтийн бууралт, 49.1% нь жишмэл түлшний бууралт, 42.9% илчлэгийн өсөлтөөс тус тус шалтгаалжээ.

Тайлбар №9-ыг харна уу.

Тарифын тооцоонд уурхайгаас нийлүүлэх нүүрсний илчлэгийг уурхайн төслийн илчлэгээр тооцож авдаг ба илчлэгийн хэмжээ жил бүр харилцан адилгүй байдгаас



Тайлбар №10-ыг харна уу.

2016 оны тухайд илчлэгүүд бодит гүйцэтгэлээрээ нэмэгдэж гарсан нь нүүрсний зарцуулалт буурахад томоохон нөлөө үзүүлсэн юм.

ДЦС-3, ДЦС-4 ТӨХК-иудад 2014, 2015 онуудад суурилагдсан хүчин чадал нэмэгдэж, үйлдвэрлэлт, дотоод хэрэгцээ, жишмэл түлшний хувийн зарцуулалт гэх зэрэг техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд томоохон өөрчлөлт орсон ба 2015 ба 2016 оноос бүтэн жилийн дүнгээр түлшний зарцуулалтын бодит гүйцэтгэл /хэмжилт/ гарсан байна. Өөрөөр хэлбэл 2016 оны эхэнд тариф тооцох үед 2015 оны бүтэн жилийн дүнгээр бодит гүйцэтгэлүүд баталгаажиж гарч амжаагүй байсан.

Тайлбар №11-ийг харна уу.

5. Бүлэг 1. Дэд хэсэг. Зохицуулах хороо болон ТӨБЗГ-аас төрийн өмчит компаниудын төлөвлөлтийг харилцан уялдаатай хянаж чадахгүй байна, Тайлангийн 1.29-1.30 хэсэг: Дэд хэсгийн агуулгыг “Төрийн өмчит компаниудын удирдлага нь төлөвлөлтийг борлуулалтын бодит орлоготой уялдуулан хянаж чадахгүй байна” гэж өөрчлөх саналтай байна.

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлд Зохицуулах хорооны бүрэн эрхийг тодорхойлсон байдаг. Зохицуулах хороо нь хуулиар олгогдсон эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч аливаа этгээдийн зорилтот түвшин, төлөвлөлтийн үзүүлэлтийг хянах, батлах эрхгүй ба төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцдоггүй ба ТӨБЗГ-тай ажлын аливаа нийтлэг чиг үүрэг, зорилго байхгүй тул “төлөвлөлтийг уялдаатай хянаж чадахгүй байна” гэсэн дүгнэлттэй санал нийлэхгүй байна.

Тайлбар №12-ыг харна уу.

6. Бүлэг 2. Үнэ тарифын зохицуулалт нь урт хугацаанд үр дүнгүй байна: Бүлэг 2-ийн агуулгыг “ТЗЭ компаниуд үнэ тарифын зохицуулалтыг үр дүнтэй ашиглах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна” гэж өөрчлөх саналтай байна.

Тайлбар №13-ыг харна уу.

7. Бүлэг 2. Дэд хэсэг. Үнэ тариф тогтвортой байгаа боловч ТЗЭ-дэд хуримтлал бүрдэх боломжгүй байна, Тайлангийн 2.13-2.18: Дэд хэсгийн агуулгыг “Үнэ тариф тогтвортой байгаа нөхцөлд ТЗЭ нар хуримтлалын санг бүрдүүлэх талаар заавар, журмыг холбогдох эрх бүхий байгууллага гаргаж мөрдүүлэх” гэж өөрчлөх саналтай байна.

Тайлбар №14-ийг харна уу.

2.17 хэсэг: Олон улсын практикт цахилгаан эрчим хүчинд зах зээл нь загварчлагдаж, дулааны эрчим хүчний зах зээл байхгүй тохиолдолд цахилгаанд илүү өртөг хуваарилах, дулааны хөндлөн татаасыг цахилгаанд ногдуулах зарчим мөрдөгдөх хандлагатай байдаг. Жишээ нь Герман, Нидерланд, Дани гэх мэт хойд европын орнууд үүнийг хэрэгжүүлдэг. Цахилгаан, дулааны зах зээлийг хоёуланг нь загварчлан мөрдөж буй Скандинавын орнуудын хувьд дулааны бодит өртөгт үнэ тогтоогддог. Монгол улсын хувьд дулааны хөндлөн татаасыг цахилгаанд ногдуулж байгаа нь манай улсын цахилгаан эрчим хүчний зах зээлийн загварын хүрээнд олон улсын жишгээр авч хэрэглэж байгаа аргачлалын нэг хэлбэр.

Дулааны хөндлөн татаас нь цахилгааны тарифаар нөхөгддөг тул ТЗЭ-ийн ямар нэгэн санхүүгийн алдагдалд орох, хөрөнгө оруулалтын сан бүрдэхгүй байгаа нь дулааны хөндлөн татаастай огт холбоогүй юм.

Тайлбар №15-ыг харна уу.

Үнэ, тарифын аливаа зохицуулалт нь хөрөнгө оруулалтын санг бүрдүүлэх нөхцөл, хөшүүрэг, арга хэрэгсэлийн аль нь ч биш бөгөөд хүчин төгөлдөр мөрдөж буй тарифын хүрээнд олох орлогыг хэрхэн зарцуулах нь тухайн аж ахуйн нэгжийн



гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ, компанийн засаглалын хүрээнд хэрэгжих асуудал байдаг.

Тайлбар №16-г харна уу.

8. Бүлэг 3. Үнэ тарифын зохицуулалтад тавих хяналтын тогтолцоо бүрэн бүрдээгүй байна. Бүлэг 3-ийн агуулгын хүрээнд үнэ тарифын зохицуулалтын хяналт шалгалтаас гадна тусгай зөвшөөрөл олголт, түүний хяналт, зохицуулалтын үйлчилгээний хөлс, түүний зарцуулалтын талаарх дүгнэлтүүд хамт орсон байна. Иймээс үнэ тарифын зохицуулалтаас бусад хяналтын асуудлыг тусад нь бүлэг болгож дүгнэх нь зүйтэй. Энэ бүлгийн агуулгыг “Үнэ тарифын зохицуулалтад тавигдах хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна” гэж өөрчлөх саналтай байна.

Тайлбар №17-г харна уу.

9. Бүлэг 3. Дэд хэсэг. Үнэ тарифыг тогтоох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн, байнгын хяналтын тогтолцоо шаардлагатай байна, Тайлангийн 3.14-3.17: Зохицуулах хороо нь 2015-2016 онуудад зарим ТЗЭ-гчдийн нүүрсний хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, хөрөнгө оруулалтын засвар шинэчлэлийн ажлуудад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор тарифын зохицуулалтуудыг үнэ тариф тооцох аргачлалын хүрээнд хийсэн. Өөрөөр хэлбэл тариф тооцох аргачлалын үндсэн бүтэц нь БОШХ=Өртөг, зардал + ХО-ын өгөөж гэсэн байдаг. Дээрх тарифын түр зохицуулалтууд нь агуулгын хувьд ХО-ын өгөөж гэсэн ангиллаар шийдвэрлэгдсэн тул тариф тооцох аргачлалыг зөрчөөгүй болно.

Тайлбар №18-ыг харна уу.

Мөн тарифт тооцсон 2,598.6 сая төгрөгийн урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээ, баяр ёслолын зардлууд нь ЭХЯ, МЭХГУУ-н үйлдвэрчний эвлэлийн холбоо, МЭХА нарын хамтарсан 3 талт “Эрчим хүчний салбарын хамтын /тариф/ хэлэлцээр”-т заасан байдаг тухай 3.18 гэсэн шинэ хэсэгт дурдах шаардлагатай байна.

Тайлбар №19-ыг харна уу.

10. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатад өгөх зөвлөмжийн төсөлд “Эрчим хүчний зохицуулах хорооны үйл ажиллагааны зардлыг хянаж, баталж байх” гэж тусгасан байна. Эрчим хүчний зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллага нь олон улсын жишгээр бусдаас хараат бус, бие даасан байдал (орон тооны 3 зохицуулагчид болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, ажил олгогчдын эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий орон тооны бус 2 зохицуулагчид бие даан шийдвэр гаргадаг)-аар үйл ажиллагаа явуулах шаардлагатай байдаг. Үйл ажиллагааны зардал төсвийг Засгийн газраар хянуулж батлуулах нь энэхүү хараат бус, бие даасан байдалд сөргөөр нөлөөлөх учраас уг зөвлөмжийн хэсгийг хасах нь зүйтэй гэж үзэж байна.

11. Гүйцэтгэлийн аудитын нэгдсэн дүгнэлт, зөвлөмжид дээр дурдсан саналуудыг тусгаж зохих өөрчлөлтийг оруулах зэрэг саналтай байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Саналд өгсөн тайлбар

Тайлбарын дугаар	Саналыг хүлээн авсан эсэх	Тайлбар
Тайлбар №1	Үгүй	Хуулийн зарчмын дагуу үнэ тарифыг тогтоохгүй байгааг зүйл заалттай нь 1.1, 1.2 дахь хэсэгт дурдсан байгаа болно. Саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар №2	Үгүй	Тарифын саналыг хянан шалгах журмын 8.3-т зохицуулагчийн эрхийг зааж өгөөгүй бөгөөд үндэслэл болох зүйлийг дурджээ. Саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар №3	Үгүй	Үнэ тарифыг гүйцэтгэлд бус норм, нормативт үндэслэн тогтоох нь бодит өртөг зардалд тулгуурлана гэсэн хуулийн заалттай нийцэж байгаа юм. Саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар №4	Үгүй	Үнэ тарифыг өнгөрсөн оны гүйцэтгэлд бус түүхий эд материал, шатахуун, тээвэр, сэлбэг хэрэгсэл, хангамж, цалин зэрэг зардлын нормативыг үндэслэж тарифыг тооцох шаардлагатай. Ингэснээр бодит зардалд үндэслэгдэх гэсэн хуулийн заалт хэрэгжинэ. Саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар №5	Тийм	Саналыг хүлээн авч 1.4 дэх хэсэгт “Үнэ тариф тогтоох аргачлалыг зохицуулалттай өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллахад бэлтгэн сайжруулалт хийх шаардлагатай байна.” гэж найруулан өөрчлөв.
Тайлбар №8	Үгүй	Тайлангийн агуулгатай хамааралгүй тайлбар учир тайланд тусгах шаардлагагүй болно.
Тайлбар №9	Тийм	Нүүрсний зарцуулалтад нөлөөлөх хүчин зүйлүүдээс нүүрсний илчлэгийн талаар тайланд дурдаагүй байсан. Энэ саналыг хүлээн авч тайлангийн 1.13 дахь хэсэгт тусгасан.
Тайлбар №10	Үгүй	Тайлангийн агуулгатай хамааралгүй тайлбар учир тайланд тусгах шаардлагагүй болно.
Тайлбар №11	Үгүй	Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч ТӨХК-иуд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин Зохицуулах хорооны тарифт хянасан зардлын түвшингээс уг зорилтот түвшин 28,204.8 сая төгрөгийн зөрүүтэй тусгагдаж батлагджээ. Энэ нь ТӨБЗГ, ЭХЗХ хоорондоо уялдаагүй ажиллаж байгааг харуулж байна. Саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар №12	Үгүй	Хоёр дугаар бүлгийн гарчигийг аудитын зөвлөлийн хурлаар өөрчилсөн байгаа. ТЗЭ компаниуд хуримтлал үүсгэж ажиллах талаар анхаарч ажиллах нь зүйтэй учир уг саналыг тухайн гарчигийн агуулгад оруулсан болно.
Тайлбар №13	Үгүй	Аудитын сэдвээс агуулга өөр учир саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар №14	Үгүй	Тайлангийн агуулгатай хамааралгүй тайлбар учир тайланд тусгах шаардлагагүй болно.
Тайлбар №15	Тийм	Саналыг хүлээн авч 2.5-д “ТЗЭ-чид тогтоосон тарифын хүрээнд олсон орлогоороо хуримтлалын сан бүрдүүлэх талаар хангалтгүй ажиллаж байна.” гэж нэмж өөрчлөв.
Тайлбар №16	Тийм	Саналыг хүлээн авч гуравдугаар бүлгийг “Үнэ тарифын зохицуулалт болон тусгай зөвшөөрөл олголтот тавигдах хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрэн бүрдээгүй байна.” гэж өөрчлөв.
Тайлбар №17	Үгүй	Нүүрсний төлбөр, хөрөнгө оруулалт, засварын зардлыг жилийн эхэнд баталсан байтал оны дундуур дахин нүүрсний төлбөр, хөрөнгө оруулалт, засварын зардлыг баталж өгч байгаа нь уг аргачлалыг зөрчиж байна. Саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар №18	Тийм	Саналыг хүлээн авч тайлангийн 3.3 дахь хэсэгт оруулсан болно.
Тайлбар №19	Тийм	Саналыг хүлээн авч тайлангийн зөвлөмжийн хэсгээс хассан болно.

Дүгнэлт:

“Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитыг дараах 3 зорилтын хүрээнд төлөвлөж, хэрэгжүүлсэн билээ. Үүнд:

- ✓ Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, дамжуулах, хангах үйл ажиллагааны үнэ тариф бодитой тогтоогдож буй эсэх;
- ✓ Үнэ тарифын зохицуулалт хийснээр эрчим хүчний салбарт үр дүн гарч буй эсэх;
- ✓ Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалтад тавих хяналт үр дүнтэй эсэх.

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, дамжуулах, хангах үйл ажиллагааны үнэ тариф бодитой тогтоогдож буй эсэхэд хийсэн дүгнэлт

Үнэ тарифыг бодит өртөг зардалд бус гүйцэтгэлд үндэслэн тогтоож байгаа нь хуулиар тогтоосон зарчимтай нийцэхгүй байна.

- Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах өртөгт орж байгаа түүхий эд материал, шатахуун, тээвэр, сэлбэг хэрэгсэл, материал хангамж зэрэг бусад хувьсах зардлын норматив батлан мөрдөөгүй нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үйлдвэрлэлийн өртгийг бодитой тогтоох, улмаар үнэ тарифыг ЭХТХ-д заасны дагуу бодит өртөгт үндэслэн тогтоох нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.
- Төвийн бүсийн ҮТЗЭ-дийн эрчим хүчний төлөвлөсөн үйлдвэрлэл төдийлөн өсөөгүй байхад нийт зардал огцом нэмэгдсэн нь ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхгүй байгаа гол шалтгаан болж байна. Энэ нь нийт зардлын өсөлтийн 66.5 хувийг бүрдүүлж буй тогтмол зардлын өсөлтийг хязгаарлаж, арвилан хэмнэлтийн бодлого баримталж ажиллах шаардлагатай болсныг илэрхийлж байна.
- Эрчим хүчний үнэ тарифт тооцох зардлын 30 хувийг бүрдүүлж байгаа түлшний хэмжээг тооцоолох коэффициентүүдийг туршилтаар баталгаажуулж, шинэчлэн тогтоогоогүй байна.
- Зохицуулагчдын эрх үүргийг бүрэн тодорхойлоогүйн дээр үнэ тарифын саналыг хянаж, тогтоох асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэхдээ ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар мэдүүлэг гаргахгүй байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль⁴⁴ болон УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан журмыг⁴⁵ зөрчсөн байна.
- СЭХ-ний үнийг олон улсын жишгээс⁴⁶ 20 орчим хувиар өндөр тогтоож хуульчилсан, өнөөгийн суурилагдсан хүчин чадалтай тэнцэхүйц хэмжээний СЭХ-ний тусгай зөвшөөрөл олгосон нь эрчим хүчний дэмжих тариф 32.5 төг/кВт.ц-аар өсч, хэрэглэгчдэд төлбөрийн ачаалал нэмэгдэх тооцоолол гарч байгаа нь нэгдсэн сүлжээний горим ачаалал, хэрэглэгчийн үнэ өсөхөд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэл үүсгэж байна.
- Эрчим хүчний салбарын ТӨХК-иудын зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг ТӨБЗГ болон Зохицуулах хороо харилцан уялдаатай, нэгдмэл байдлаар хянаж батлахгүй байна.

⁴⁴ 8.1.Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, харууллаа хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

⁴⁵ Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 1.5 дахь заалт Мэдүүлэг гаргагч нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нэн даруй хүргүүлнэ.

⁴⁶ Сэргээгдэх эрчим хүчний технологи сайжирч өртөг зардал нь жилээс жилд буурч байна. 2005 онд салхин станцын өртөг 0.071 ам.доллар/кВт.ц байсан бол 10 жилийн дараа 2015 онд 0.06 ам.доллар/кВт.ц болж буурсан байна. Нарны станцын өртөг 2005 онд 0.285 ам.доллар/кВт.ц байсан бол 2015 онд 0.126 ам.доллар/кВт.ц болж буурсан байна. /Эх сурвалж: СЭХ-ний тухай хуулийн 11-р зүйл, World energy council 2016 IRENA/



Үнэ тарифын зохицуулалт хийснээр эрчим хүчний салбарт үр дүн гарч буй эсэхэд хийсэн дүгнэлт

Үнэ, тарифын талаархи өнөөгийн хууль эрх зүйн болон санхүү удирдлагын бодлого зохицуулалт нь эрчим хүчний салбарын урт хугацааны тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөхөөр байна.

- Зохицуулах хорооноос баталсан тариф нь хэрэглэгчийн тарифыг тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлсэн хэдий ч эрчим хүчний өртөг зардлыг бууруулах арга хэмжээ аваагүй, эдийн засгийн хувьд үр ашигтай техник, технологийн шинэчлэл хийх, хуримтлал бүрдүүлэх нөхцөлийг бий болгоогүй байна.
- ТЗЭ-дийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага тогтоосон тарифын хүрээнд үр ашигтай, арвилан хэмнэлттэй, сайн засаглалыг бий болгох талаар хангалтгүй ажиллаж байна.
- 2016 онд НХА-тай загварын борлуулалтын орлогын дансны үлдэгдэлд банкнаас 84.5 сая төгрөгийн хүү тооцож олгосон бөгөөд ДҮТ ХХК нь өөрийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.
- ДҮТ ХХК Соларповер интернэйшнл ХХК-иас 2017 оны 1-р улиралд 905.9 сая төгрөгийн 2.2 сая кВт.ц энерги худалдан авахаас 1805.0 сая төгрөгийн 4.4 сая кВт.ц энерги худалдан авч өндөр үнэтэй цахилгаан станцыг ачаалласнаар 988.9 сая төгрөгийн /НӨАТ орсноор/ өглөг үүсгэн үр ашиггүй ажиллаж, нэгдсэн сүлжээний дүрмийг зөрчсөн байна.

Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалтад тавих хяналт үр дүнтэй эсэхэд хийсэн дүгнэлт

Үнэ тарифын зохицуулалт болон тусгай зөвшөөрөл олголтод тавигдах хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрэн бүрдээгүй байна.

- Түлш, сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардлыг оны эхэнд тарифын тооцоонд тусгасан байхад нүүрсний өр барагдуулах, худалдан авалт хийх зэрэг үндэслэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчээс дахин тарифын санал ирүүлснийг Зохицуулах хороо хянаж, эх үүсвэр шийдвэрлэсэн, үйлдвэрлэлийн бус зардлыг тарифт тооцсон зэрэг нь үнэ тариф тогтоох явцад хөндлөнгийн болон дотоод хяналтын тогтолцоо байхгүйтэй холбоотой байна.
- ҮАГ-аас 2016 онд эрчим хүчний тусгай зөвшөөрөл олголтын байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн Зохицуулах хорооны үйл ажиллагаанд хамаарах зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.
- УБДС ТӨХК дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөлгүй 420 иргэн, ААН-тэй худалдах, худалдан авах гэрээ байгуулж, үйл ажиллагаа явуулж байгаа нь ЭХТХ, Зохицуулах хорооны 2014 оны 190 дүгээр тогтоолд заасантай нийцэхгүй байна.
- ДЦС-4 ТӨХК-ийн хөргөх цамхаг №4 барьсан, ПТ-80-130 ТГ-6 турбины хүчин чадлыг 20 МВт-аар нэмэгдүүлсэн, ЦДҮС-ийн өмнөд дэд станцад хүчний трансформаторын чадлыг нэмэгдүүлсэн, 2015 онд ДЦС-3 ТӨХК-ний тарифыг нэмэгдүүлэх замаар Даланзадгад ДЦС-ын 1 дүгээр турбины шинэчилсэн зэрэг төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг шалгахад нийт 15.5 тэрбум төгрөгийг үр ашиггүй зарцуулсан, холбогдох хуулиудыг зөрчсөн, улсад хохирол учруулсан байж болзошгүй зөрчлүүд гарсан байна.
- ЭХЗХ-ны үйл ажиллагааны төсөв жил бүр нэмэгдэж ирсний дотор зарим төрлийн зардлыг хэтрүүлсэн, үр ашиггүй зарцуулсан нь зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр бүрдүүлсэн үйл ажиллагааны төсвийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.
- Зохицуулах хорооны даргаар ажиллаж байсан С.Отгонбаяр нь ажлаас чөлөөлөгдсөн тушаал гарсны дараа 216.2 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрснийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах шаардлагатай байна.

**Зөвлөмж:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд:

- ЭХТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу орон тооны бус нэг гишүүнийг томилж Зохицуулах хороог бүрэн бүрэлдэхүүнээр нь ажиллуулах,
- Зохицуулагч нарын эрх үүрэг хариуцлагын тогтолцоог бий болгосон зохицуулалт бүхий хуулийн төслийг боловсруулж ЭХТХ-нд нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл Засгийн газрын тогтоолоор журам гаргаж тодорхой болгох,

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэнд:

- Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтад заасан сэргээгдэх эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулан, батлуулж хэрэгжүүлж ажиллах,
- Эрчим хүчний ТЗЭ-дийн хэмжээнд арвилан хэмнэлттэй, үр ашигтай, техник, технологийн шинэчлэл хийж, сайн засаглалыг бий болгох бодлого баримтлан ажиллах,
- ЭХТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтыг хэрэгжүүлж цахилгаан, дулаан үйлдвэрлэх өртөг зардалд тооцогдож байгаа түлш, түүхий эд материал, шатахуун, тээвэр, сэлбэг хэрэгсэл, материал хангамж зэрэг зардлын норматив, стандартыг баталж мөрдүүлэх,
- Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа 420 иргэн, ААН-ийг хуульд нийцүүлэн тусгай зөвшөөрөлтэй болгох асуудлыг шийдвэрлэх,
- ТӨБЗГ-тай хамтран эрчим хүчний салбарын хэмжээнд цалингийн жишиг хэмжээг тогтоох, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг нэгдсэн бодлогоор зохицуулах чиглэлийг тодорхойлох,
- Шинээр ашиглалтад орж байгаа СЭХ-ний ТЗЭ-дийн ДҮТ ХХК-тай байгуулсан худалдах, худалдан авах гэрээнд хяналт тавьж ажиллах,
- ДЦС-4 ТӨХК-ийн хөргөх цамхаг №4 барьсан, ПТ-80-130 ТГ-6 турбины хүчин чадлыг 20 МВт-аар нэмэгдүүлсэн, ЦДҮС-ийн өмнөд дэд станцад хүчний трансформаторын чадлыг нэмэгдүүлсэн, 2015 онд ДЦС-3 ТӨХК-ний тарифыг нэмэгдүүлэх замаар Даланзадгад ДЦС-ын 1 дүгээр турбины шинэчилсэн зэрэг төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг шалгахад илэрсэн 15.5 тэрбум төгрөгийг үр ашиггүй зарцуулсан, холбогдох хуулиудыг зөрчсөн, улсад хохирол учруулсан байж болзошгүй зөрчлийг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн тул зохих ёсны хяналт тавьж ажиллах,

Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейханд:

- СЭХ-ний тусгай зөвшөөрлийг хууль эрх зүйн акт, салбарын бодлого, ТЭЗҮ-тэй уялдуулж олгох, өмнө олгосон тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл шаардлагын биелэлтийг хангуулж ажиллах,
- Шинээр ашиглалтад орж байгаа СЭХ-ний ТЗЭ-дийн ДҮТ ХХК-тай байгуулсан худалдах, худалдан авах гэрээнд хяналт тавьж ажиллах,
- Зохицуулагч нар тарифын санал хянах бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан журмын 1.5⁴⁷ дахь заалтын дагуу гаргаж байх,
- ТӨХК-иудын зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг батлах үйл ажиллагааг боловсронгуй болгож, ТӨБЗГ-тай ажлын уялдааг сайжруулан, хамтран ажиллах,
- Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж үнэлгээ хийлгэсний дараа дахин тусгай зөвшөөрлийг олгох эсэхийг шийдэх,

⁴⁷ Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 1.5 дахь заалт Мэдүүлэг гаргагч нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нэн даруй хүргүүлнэ.



- Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хийж буй хяналт шалгалтын тоог нэмэгдүүлэх, хяналтыг үр нөлөөтэй болгох, үйлчлэх хүрээнд хамаарах байгууллагыг бүрэн хамруулж байх, ялангуяа эрчим хүчний гэрээт борлуулагч, эрчим хүчний үйлдвэрлэлд нүүрс нийлүүлдэг уурхайг хамруулах,
- Зохицуулах хорооны үнэ тариф тогтоох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн болон дотоод хяналтын тогтолцоог бий болгох,
- Эрх зүйн чадамжгүй гарын үсгээр зарцуулагдсан 216.2 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн тул зохих ёсны хяналт тавьж ажиллах,
- Зохицуулах хорооны үйл ажиллагааны зардлыг арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөх, зарцуулах бодлогыг баримтлах,
- Аудитаар өгсөн акт, албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг ҮАГ-т заасан хугацаанд тайлагнах.

ДҮТ ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Балдоржид:

- Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх,
- Аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг ҮАГ-т 2018 оны 01 дүгээр сарын 01-нд тайлагнах,
- Монгол улсын СЭХ-ний хэрэглээнд үндэслэн, эрчим хүчний мастер төлөвлөгөөтэй уялдуулж худалдах, худалдан авах гэрээг байгуулах, нэгдсэн сүлжээний дүрмийг баримталж гэрээнд хяналт тавьж ажиллах,

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осорт:

- ЭХ-ний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, томилсон ТУЗ, гүйцэтгэх удирдлагад хяналт тавьж, эдийн засгийн арвилан хэмнэлттэй, үр ашигтай ажиллуулахад анхаарч ажиллах,
- ДЦС-4 ТӨХК-ийн хөргөх цамхаг №4 барьсан, ПТ-80-130 ТГ-6 турбины хүчин чадлыг 20 МВт-аар нэмэгдүүлсэн, ЦДҮС-ийн өмнөд дэд станцад хүчний трансформаторын чадлыг нэмэгдүүлсэн, 2015 онд ДЦС-3 ТӨХК-ний тарифыг нэмэгдүүлэх замаар Даланзадгад ДЦС-ын 1 дүгээр турбины шинэчилсэн зэрэг төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг шалгахад илэрсэн 15.5 тэрбум төгрөгийг үр ашиггүй зарцуулсан, холбогдох хуулиудыг зөрчсөн, улсад хохирол учруулсан байж болзошгүй зөрчлийг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн тул зохих ёсны хяналт тавьж ажиллах,
- Эрчим хүчний ТӨХК-иудын зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг батлах үйл ажиллагааг боловсронгуй болгож, ЭХЗХ болон холбогдох байгууллагуудтай ажлын уялдааг сайжруулан, хамтран ажиллах.



Сэргээгдэх эрчим хүчний ТЗЭ-дийн үнэ тарифын санал хянаж, баталсан байдал

Хавсралт №1 /мян.ам.долл/

№	ТЗЭ	Тариф			Хүчин чадал мВт	Нийт хөрөнгө оруулалт		Зөрүү	Ашиглалтын зардал		Зөрүү
		Баталсан огноо	Жил	ам.ц ент/к Вт.ц		ТЗЭ санал	ҮТХ хянасан		ТЗЭ санал	ҮТХ хянасан	
1	"Мошеа-Эко Энержи"	2016	20	16.0	50	92,879.0	89,504.2	3,374.8	719.0	569.0	150.0
2	"Тэнүүн гэрэл констракшн"	2016	18	16.2	15	25,719.3	24,764.0	955.3	1,259.6	455.3	804.3
3	"Эвридэй ферм"	2016	20	17.3	10	18,583.3	17,538.3	1,045.0	556.1	426.7	129.4
4	"Мон-Кореа инженеринг"	2015	20	17.8	8	18,955.0	18,955.0	0.0	487.0	233.0	254.0
5	"Соларповер Интернейшнл"	2015	20	16.5	10	19,575.2	19,575.2	0.0	257.9	249.0	8.9
6	"Дөргөний НЦС"	2016	20	16.0	10	22,247.4	22,247.4	0.0	260.7	260.7	0.0
7	"И Эс Би Солар"	2016	10	17.3	10	16,506.6	16,506.6	0.0	612.7	369.8	242.9
8	"Сан степпе"	2016	18	15.2	50	90,030.0	81,210.3	8,819.7	1,334.6	601.5	733.1
9	"Нарантээг"	2016	15	15.3	15	25,951.8	25,480.5	471.3	976.1	424.6	551.5
	Дүн /НЦС/					330,447.6	315,781.5	14,666.1	6,463.7	3,589.6	2,874.1
10	"Клин Энержи Ази"	2015	20	9.4	50	111,322.9	98,123.0	13,199.9	3,624.3	2,932.8	691.5
11	"Ти Би Эф энерги зуун"	2016	15	9.4	50	107,497.2	91,089.7	16,407.5	1,631.0	1,631.0	0.0
	Дүн /СЦС/					218,820.1	189,212.7	29,607.4	5,255.3	4,563.8	691.5
	Нийт дүн					549,267.7	504,994.2	44,273.5	11,719.0	8,153.4	3,565.6

2015, 2016 онд төвлөрүүлээгүй зохицуулалтын үйлчилгээний хөлсний үлдэгдэл

Хавсралт №2 /сая.төг/

№	ААН	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрөл олгосон	Тусгай зөвшөөрлийн хугацаа /жил/	Мөнгөн дүн
1	УБ усан цэнэгт ХХК	СЭХ УЦЦС	2014.06.20	5	30.0
2	Таун комфорт ХХК	Дулаан түгээх Дулаанаар зохицуулалттай хангах	2014.07.03- 2014.07.03	5 5	1.4
3	Багануур-Ус НӨҮГ	Дулаан түгээх Дулаанаар зохицуулалттай хангах	2012.12.21 2012.12.21	5 5	0.8
4	Багануур Паэур	ЭХБББ, ДЦС	2015.07.30	5	90.0
5	Галуутай хүнгүйн	ЭХБББ, УЦС, СЭХ, АУЭХС	2010.10.01 2015.07.30	5	0.3
6	Богд Асар	Дулаахаар зохицуулалттай хангах	2013.10.15	3	0.9
7	БНДС	Дулаан үйлдвэрлэх Дулаан түгээх Дулаар зохицуулалттай хангах	2016.11.29 2009.12.28 2009.12.28	5 10 10	1.3
8	Есөнбулаг Эрчим хүч	ЭХБББ, СЭХ, УЦС АУЭХС	2010.06.30 2015.07.30	5	0.8
9	Дөргөний УЦС	Цахилгаан үйлдвэрлэх Дулаан үйлдвэрлэх	2013.10.15	5	5.16
10	Налайхын дулааны станц	Дулаан түгээх Дулаанаар зохицуулалттай хангах	2009.06.03 2016.08.15 2016.08.15	10 5 5	20.0
11	Нолго ХХК	Цахилгаан түгээх Цахилгаанаар зохицуулалттай хангах	2007.12.21 2007.12.21	25 25	0.8
12	ОСНААУГ	Дулаан түгээх	2014.11.28	5	0.1



		Дулаанаар зохицуулалттай хангах	2014.11.28	5	
13	Сэлэнгэ энерго	Дулаан үйлдвэрлэх Дулаан түгээх Дулаанаар зохицуулалттай хангах	2014.02.18 2014.02.18 2014.02.18	5 5 5	15.8
14	Тайшир Гуулин УЦС	Цахилгаан үйлдвэрлэх	2015.07.30	5	3.1
15	Шинэ азиа майнинг	ЭХБББ, ДЦС	2017.06.30	5	27.0
16	Төвчандмань	Дулаан үйлдвэрлэх Дулаан түгээх Дулаанаар зохицуулалттай хангах:	2014.09.30 2014.09.30 2014.09.30	5 5 5	3.1
17	Хөдөөгийн цахилгаан	СЭХ, НЦС	2014.12.11	3	25.5
18	Хасуу мегаватт	ЭХБББ, ДС	2014.10.3	3	26.8
19	Энерго сервис монтаж	ЭХБББ, ДС	2014.10.10	3	26.8
20	Энерготех сервис	ЭХБББ, ДС	2014.10.24	3	26.8
	Дүн				306.46

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөгүй ААН

Хавсралт №3

№	ААН	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Байршил, хүчин чадал
1	Ти Би Эф Энэржи зуун	ЭХБББ, СЭХ, СЦС	2015.07.07-2019.07.07	Өмнөговь аймаг Баян- Овоо сум Могойт баг, 50мВт
2	Багануур пауэр	ЭХБББ, ДЦС	2015.07.30-2020.07.30	Багануур дүүрэгт 700мВт
3	Баруун монгол энерги	ЭХБББ, ДЦС	2015.03.26-2020.03.26	Увс аймаг, 60мВт, ББНС
4	Термальмега ваттс	ЭХБББ, СЭХ, НЦС	2016.12.08-2019.12.08	Ховд аймаг Мянгад сум
5	Эрэл ХХК	ЭХБББ, СЭХ	2015.02.26-2018.02.26	УБ хотод барих 32мВт
6	Хөдөөгийн цахилгаан	ЭХБББ, СЭХ, НЦС	2014.12.11-2017.12.11	Говь-Алтай, Тайшир сум 10 мВт
7	Энерги стар	ЭХБББ, Дулааны станц	2014.12.10-2017.12.10	Төв аймаг, Зуунмод сум, 35мВт
8	Энерготех сервис	ЭХБББ, Дулааны станц	2014.10.24-2017.10.24	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 35 мВт
9	Энерго сервис монтаж	ЭХБББ, Дулааны станц	2014.10.10-2017.10.10	Дундговь аймаг, Сайнцагаан сум, 35 мВт
10	Хасуу мегаватт	ЭХБББ, Дулааны станц	2014.10.03-2017.10.03	Хэнтий аймаг, Чингис хот, Хэрлэн сум, 35 мВт

Хөрөнгө оруулалтын гэрээ, санхүүгийн эх үүсвэрийн баталгаагүй ААН-үүд

Хавсралт №4

№	ААН	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Байршил, хүчин чадал
1	Шинэ ази	ЭХБББ, ДЦС	2017.06.30-2020.07.30	Завхан, Тэлмэн, 100мВт
2	Клинтек	ЭХБББ, СЭХ, СЦС	2017.01.14-2020.01.14	Өмнөговь, Ханбогд сум, 250мВт
3	АБ солар винд	ЭХБББ, СЭХ, СЦС	2016.11.22-2018.11.22	Дорноговь, Даланжаргалан сум, 100мВт
4	Ти Би Эф Энэржи зуун	ЭХБББ, СЭХ, СЦС	2015.07.07-2019.07.07	Өмнөговь, Баян- Овоо, Могойт баг, 50мВт
5	Эрэл ХХК	ЭХБББ, СЭХ, Ус, биомасс	2015.02.26-2018.02.26	Хог боловсруулах ЭХЭУ УБ хотод барих 32мВт
6	Хөдөөгийн цахилгаан	ЭХБББ, СЭХ, НЦС	2014.12.11-2017.12.11	Говь-Алтай, Тайшир сум 10 мВт
7	Энерги стар	ЭХБББ, Дулааны станц	2014.12.10-2017.12.10	Төв аймаг, Зуунмод сум, 35мВт
8	Энерготех сервис	ЭХБББ, Дулааны станц	2014.10.24-2017.10.24	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 35 мВт
9	Энерго сервис монтаж	ЭХБББ, Дулааны станц	2014.10.10-2017.10.10	Дундговь аймаг, Сайнцагаан сум, 35 мВт
10	Хасуу мегаватт	ЭХБББ, Дулааны станц	2014.10.03-2017.10.03	Хэнтий аймаг Хэрлэн сум, 35 мВт
11	Мандал голомт	ЭХБББ, 348 МВт Дулааны станц	2014.10.10-2017.10.10	Говь-Алтай, Есөнбулаг
12	Клин Энэржи Ази ХХК	ЭХБББ, СЭХ, СЦС 50МВт	2014.09.30-2019.09.30	Өмнөговь, Цогтцэций ТБНС



13	Тавантолгойн цах станц	ЭХБББ, ДЦС, 450МВт,	2013.11.22-2018.11.22	Өмнөговь, Цогтцэций
14	Тавантолгой пауэр ХХК	Цахилгаанаар зохицуулалтгүй хангах	2013.11.22-2018.11.22	
15	Эрдэнэцогт энерги ХХК	ЭХБББ, ДЦС 600МВт, ТЭХС	2012.08.31-2017.08.31	Дорноговь, Алтанширээ, Эрдэнэцогтын уурхай
16	Цэцэнс майнинг энд энерги ХХК	ЭХБББ, ДЦС, 600МВт, ТЭХС	2012.06.20-2017.06.20	Төв аймгийн Баян, Баянжаргалан, Цайдамын хөндий, Бөөрөлжүүтийн тал

Ажиллагсдын цалингийн сан, орон тооны харьцуулалт

Хавсралт №5 /сая төгрөг/

№	ТЗЭ	Цалингийн нийт сан				Гүйцэтгэ лийн зөрүү	Ажиллагсдын тоо				Гүйцэтгэл ийн зөрүү
		2016 он		2015 он			2016 он		2015 он		
		Төл	Гүйц	Төл	Гүйц		Төл	Гүйц	Төл	Гүйц	
1	ДЦС-2	5,594.9	5,617.9	4,801.6	4,800.9	817.0	294	297	294	292	5
2	ДЦС-3	20,777.9	22,801.1	20,138.3	20,419.8	2,381.3	995	995	988	991	4
3	ДЦС-4	36,207.8	37,879.8	35,005.7	33,841.9	4,037.9	1492	1477	1492	1469	8
4	УБДС	7,549.7	7,759.6		6,918.2	841.4	345	358		337	33
5	ЦДҮС	18,783.2	19,751.9	17,347.2	16,581.8	3,170.1	1125	1086	1053	1053	21
6	УБЦТС	29878.7	29,984.5	26,678.6	26,677.2	3,307.3	1838	1861	1739	1752	109

Түлшний зардлын өөрчлөлт

№	ТЗЭ	2016 он			2015 он			Өөрчлөлт	
		Төл	Гүйц	Тарифт тооцсон	Төл	Гүйц	Тарифт тооцсон	Тарифт тооцсон	Гүйц
1	ДЦС-2	8,259.5	8,004.5	8,623.9	7,233.2	7,077.1	7,601.2	1,022.7	927.4
2	ДЦС-3	47,135.9	46,268.7	47,126.3	45,011.5	42,960.4	46,446.1	680.2	3,308.3
3	ДЦС-4	110,960.9	109,001.2	114,552.2	102,103.4	99,692.3	104,239.5	10,312.7	9,308.9

Хавсралт №6 /сая төгрөг/

Тарифт тооцсон элэгдлийн зардлын өөрчлөлт

№	ТЗЭ	Тарифт тооцсон			Өөрчлөлт			
		2017 он	2016 он	2015 он	Биет		Хувь	
					2017 он	2016 он	2017 он	2016 он
1	ДЦС-2	2,279.9	1,560.0	1,682.1	719.9	-122.1	46.1	-7.2
2	ДЦС-3	20,590.8	20,590.9	20,352.7	-0.1	238.2	0.00	1.1
3	ДЦС-4	36,637.2	35,578.8	29,227.2	1,058.4	6,351.6	2.9	21.7
4	УБДС	6,304.2	7,146.1	5,308.8	-841.9	1,837.3	-11.7	34.6
5	ЦДҮС	11,162.7	8,122.3	10,475.8	3,040.4	-2,353.5	37.4	-22.4

Хавсралт №7 /сая төгрөг/

Тэг үлдэгдэлтэй орлогын дансанд шилжүүлэх хувь хэмжээ

Хавсралт №8

№	Түгээх байгууллагын нэр	Тэг үлдэгдэлтэй орлогын данснаас шилжүүлэх хувь хэмжээ		
		Өөрийн үйл ажиллагааны зардалд	Диспетчерийн зохицуулалтын хөлсөнд	Тэг үлдэгдэлтэй орлогын дансанд
1	УБЦТС	25.73	0.91	73.36
2	ЭБЦТС	14.71	0.70	84.59
3	БЗӨБЦТС	48.39	0.94	50.67

Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данснаас хуваарилах хувь хэмжээ

Хавсралт №9

№	Үйлдвэрлэгч байгууллагын нэр	Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данснаас шилжүүлэх хувь хэмжээ
1	ДЦС-4 ТӨХК	38.0
2	ДЦС-3 ТӨХК	14.28
3	ДЦС-2 ТӨХК	3.79
4	ДДЦС ТӨХК	5.70
5	ЭДЦС ТӨХК	4.0
6	Салхит СЦСтанц	9.20



7	Ухаа худаг ДЦС	2.69
8	Солар повер интернэшнл НЦС	3.42
9	Импортын төлбөр	7.92
10	ЦДҮС ТӨХК	11.1

Хэрэглэгчийг бага өртгөөр хангах чиглэлээр УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн үүрэг даалгаврын хэрэгжилтийн байдал

Хавсралт №10

Ажлын хэсгээс гарсан үүрэг даалгавар

Ажлын үр дүн

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 64 дүгээр захирамжийн дагуу байгуулсан “Эрчим хүчний салбарын санхүүгийн байдал, төлбөрийн чадвар, ашиг, алдагдлын шалтгаан, нөхцөл, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, борлуулах байгууллагуудын өртөг, үнэ тарифын бүтцийг судалж өртөг зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх талаар санал, дүгнэлт гаргах” чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд:

1.1 Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системд одоо үйл ажиллагаа явуулж буй дотоодын эх үүсвэрүүдийн насжилт өндөрсөж, хүчин чадлаасаа давсан ачааллаар ажиллаж байгаа учир гэнэтийн осол саатал гарсан үед хязгаарлалт хийж, системд хүндрэл учрахаар байна. Иймд Таван толгойн орд газрыг түшиглэн барих цахилгаан станцыг улс өөрийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулах.

ЭХТТББ-ийн баримт бичигт тусгагдсан бөгөөд ажил хийгдээгүй байна.

1.2 ББЭХС болон АУЭХС нь том чадлын эх үүсвэр байхгүйгээс импортоор эрчим хүч авах, өртөг өндөртэй дизель станц ажиллуулж, алдагдалтай ажиллаж байна. 2 бүсэд эрчим хүчний эх үүсвэрийг шинээр барих ажлыг ойрын хугацаанд эхлүүлэх.

ЭХТТББ-ийн баримт бичигт тусгагдсан бөгөөд ажил хийгдээгүй байна.

1.3 Зорилтот түвшин бизнес төлөвлөгөөг боловсруулж, батлах үйл ажиллагааг боловсронгуй болгож, үйл ажиллагааны зорилтод түвшингийн үзүүлэлтийг ЭХЗХ-ны тооцсон тарифт үндэслэн ЭХЯ оролцон нэгдсэн байдлаар тогтоох.

Ажил хийгдээгүй байна.

2. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2014 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолын дагуу “Түлш эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 72 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж, санал дүгнэлт боловсруулах ажлын хэсгийн хүрээнд:

2.1 Төвийн бүсийн оргил ачаалал тохируулагч эх үүсвэр болгон томоохон чадлын УЦС-ууд барих.

Ажил хийгдээгүй байна.

2.2 Салбарын хэмжээнд мөрдөх цалингийн жишгийг хамтран гаргах, компаниуд цалин нэмэх шийдвэр гаргахдаа ЭХЯ, ЭХЗХ-оос зохих шийдвэр авдаг байх зарчмыг мөрдүүлэх.

Ажил хийгдээгүй байна.

**ДЦС-4 ТӨХК-ийн хөргөх цамхаг №4-т аудитын дүгнэлт гарсан тухай****Ерөнхий зүйл**

Цамхаг барих сонгон шалгаруулалтыг 2008-2011 онуудад явуулж байсан бөгөөд барих ажлыг 2011 оны 5 дугаар сарын 10-ны өдөр эхэлж, 2011 оны 10 дугаар сарын 31-ний өдөр ашиглалтад оруулахаар БНХАУ-ын Бээжин хотын “Шан ши хуатонг электрик повер энд инженеринг” ХХК, “Анненг повер стэшн экьюипмент” групп лимитед ХХК компаниудын түншлэлтэй /К о н с о р ц и у м/ 3.89 сая ам долларын гэрээг 2011 оны 5 дугаар сарын 10-нд шууд байгуулсан байна. Хөргөх цамхагийг 2012 оны 10 дугаар сарын 25-наас үйлдвэрлэлд ашиглаж эхэлсэн.

Хөргөх цамхаг барих ажлын тендер шалгаруултын талаар:

Хөргөх цамхаг барих нээлттэй тендерийг 2008 оны 4 дүгээр сарын 15-нд зарлаж, шаардлага хангасан материал ирүүлээгүй тендер цуцлагдсан гэх боловч аудитын явцад үүнтэй холбоотой нотлох баримт олдоогүй болно.

2010 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн компаний гүйцэтгэх захирлын /Б.Цэвээн/ 114 дүгээр тушаалаар үнэлгээний хороо байгуулж /үнэлгээний хорооны дарга ерөнхий инженер М.Амарбаясгалан/, тендерийг 2010 оны 9 дүгээр сарын 15-наас 2010 оны 10 дугаар сарын 15-ны хооронд зарлаж хоёр компани материал ирүүлсэн боловч тендерийн шаардлага хангасан материал ирүүлээгүй гэж үзэж 2010 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн үнэлгээний хорооны хурлаар тендерийг хүчингүй болгосон байна.

2010 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Монгол улсын Сангийн яамнаас уг ажил гүйцэтгэх тендерт гадаадын этгээд оролцуулах нь хуульд нийцэхгүй байгаа талаар 5/5508 дугаартай албан бичиг ирүүлсэн ирүүлжээ.

Гэвч тус компаний гүйцэтгэх захирал болон үнэлгээний хороо хуульд нийцэхгүй байгаа байдлыг харгалзан үзэхгүйгээр тендерийг 2010 оны 12 дугаар сарын 23-наас 2011 оны 02 дугаар сарын 09-ний хооронд дахин зарлаж, 5 компани тендерийн бичиг баримт худалдан авсан боловч 2 компани /“Баярсконстракшн” ХХК, “Шан ши хуатонг электрик повер энд инженеринг” ХХК/ тендерийн санал ирүүлсэн байна. Үүнээс “Шан ши хуатонг электрик повер энд инженеринг” ХХК болон түүний түншлэгч “Анненг повер стэшн экьюипмент” групп лимитед түншлэлийг шалгаруулсан байна. Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 9.3⁴⁸ дахь заалтыг зөрчсөн байна.

Тендер шалгаруулалтын талаар “Баярсконстракшн” ХХК 2011 оны 03 дугаар сарын 02-нд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт гомдол гаргаж, тус газар 2011 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/212 дугаартай албан бичгээр уг тендерийг хүчингүй болгож дахин зарлахыг мэдэгдсэн байна.

“ДЦС-4” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Цэвээн тендертэй холбоотой гомдлын асуудлаар дагуу эрх бүхий шинжээчдийн баг томилон дүгнэлт гаргаж өгөхийг хүссэний дагуу Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дарга, улсын ерөнхий байцаагч Д.Мандах 2011 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 1/313 дугаартай албан бичиг, дүгнэлтийг хүргүүлсэн байна. Уг бичигт шинжээчийн багийн “Үнэлгээний хорооны шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож, тендерийн үнэлгээг дахин явуулах, ТБОНӨХБАУХА хуулийн 30.4²-т заасны дагуу захиалагч уг хуулийн 30.4.3 болон 34.1³-ийг үндэслэн шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэн гүйцэтгэгчийг сонгох” гэсэн дүгнэлт гарсныг болон ТБОНӨХБАУХА хуулийн 55.3.1⁴-д заасны дагуу захиалагчийн шийдвэрийг бүхэлд хүчингүй болгож байгааг, мөн хуулийн 55.3.2-т заасны дагуу уг хуулийн 30.4.3; 34.1-ийг үндэслэн энэ тендерт оролцож, “хамгийн сайн” үнэлэгдсэн аж ахуйн нэгжтэй захиалагч шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэгчийг сонгохыг” тус тус мэдэгдсэн байна.

2011 оны “ДЦС-4” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар шууд гэрээ байгуулахыг зөвшөөрсний дагуу тус компаний гүйцэтгэх захиралд 2011 оны 5 дугаар сарын 10-нд “Анненг повер стэшн экьюипмент групп лимитед”, “Шан ши хуатонг электрик повер энд инженеринг”

⁴⁸ 9.2.Захиалагч нь 10,000,000,001 төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажил, 100,000.001 төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцохыг хориглож үл болно.

¹ 9.3.Энэ хуулийн 9.2-т зааснаас бусад тендер шалгаруулалтад гадаадын этгээдийг оролцуулж үл болно.

² 30.4.3.энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах ; 30.1.1.шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй;

³ 34.1.Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараахь нөхцөлд хэрэглэж болно: 34.1.1.энэ хуулийн 30.4.3, 33.4 -т заасан тохиолдолд;

⁴ 55.3.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гомдлыг авч хэлэлцээд захиалагч энэ хуулийг зөрчсөн гэж үзвэл дараахь шийдвэр гаргана: 55.3.1.энэ хуулийг зөрчсөн захиалагчийн үйлдэл буюу шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүчингүй болгох, өөрчлөх; 55.3.2.тухайн асуудалд хуулийн ямар заалт хэрэглэхийг заах;



ХХК болон Улаанбаатар хотын Барилга зам гүүрийн корпорацитай 3.89 сая ам.долларын гэрээ байгуулсан байна.

Гэрээг байгуулахдаа Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын мэдэгдлийг үндэслэл болгожээ.

Дүгнэлт:

1. Тендер шалгаруулалтыг явуулахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 9.3 дахь заалтыг зөрчиж олон улсын нээлттэй тендер зохион байгуулсан байна.
2. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын шинжээчийн дүгнэлтэд “Шан ши хуатонг электрик повер энд инженеринг” ХХК болон түүний түншлэгч “Анненг повер стэшн экьюипмент” групп лимитед түншлэлийг гүйцэтгэгчээр шалгаруулсан нь илт хууль зөрчсөн” гэж заасан байтал энэ түншлэлтэй шууд гэрээ байгуулсан байна.
3. Гэрээг түлхүүр гардуулах нөхцөлөөр байгуулсан боловч барилга байгууламжийн зураг, төсөв хийлгэх, батлуулах зэрэг ажлыг хэрхэн хийлгэх нь тодорхойгүй байна. Учир нь баримт материалыг шалгах явцад 2011 оны 5 дугаар сарын 24-нд захиалагч талын ерөнхий инженер М.Амарбаясгалан “...урьдчилгаа төлбөрөө гэрээний дагуу шилжүүлээд байхад барилгын ажлыг эхлүүлээгүй” гэдэг албан бичиг явуулж байсан байна. Энэ байдлаас үзэхэд монголд мөрдөгдөж байгаа хуулийг зөрчиж ажилласан нь тодорхой байна.
4. Шууд гэрээ байгуулсан БНХАУ-ын компаниудын тендерийн баримтыг үзэхэд тухайн компани хөргөх цамхаг барих албан ёсны эрх бүхий байгууллага мөн болохыг нотлох баримт байхгүй.
5. Түншлэлээр орсон Хятадын компаниудын аль нь юу хийх нь тодорхойгүй. Төслийн зөвлөх С.Хүрэл гэх өвөр монгол иргэн аль компанийг ямар хэмжээнд төлөөлөх эсэх нь тодорхойгүй, тендерийн бичиг баримтад энэ хүний талаар юу ч байхгүй. Гэхдээ энэ хүн гүйцэтгэгчийг төлөөлж захиалагчтай бүхий л хэлэлцээр, хурал, зөвлөгөөнийг хийж ажилласан байна.
6. Туслан гүйцэтгэгч Улаанбаатар хотын Барилга зам гүүрийн корпораци ХХК энэхүү төсөлд ямар ажил гүйцэтгэхээр орсон нь тодорхойгүй бөгөөд 600.0 сая төгрөгийн гэрээг “Анненг повер стэшн экьюипмент групп лимитед” компанитай байгуулсан байна. Аудитын явцад гүйцэтгэх захирал М.Тунгаадорж, төслийн зөвлөх С.Хүрэл нараас энэ талаар тодруулга хүссэн боловч ирүүлсэнгүй.

Хөргөх цамхагийн ажлын барилгын зураг төслийн талаар:

ДЦС-4 ТӨХК-иас хөргөх цамхаг барих ажил эхлэхэд зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, станцын бусад тоног төхөөрөмжтэй холбоотой технологийн даалгавар боловсруулж өгөөгүй байна. Энэ нь 2008-2016 онд мөрдөгдөж байсан Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1⁴⁹-10.1.1⁵⁰ дэх заалтуудыг зөрчиж хөргөх цамхагийн барилга байгууламжийг барьсан байна.

Зургийн болон технологийн даалгаваргүй БНХАУ-д зураг төсөл хийлгэснээр одоо баригдсан хөргөх цамхагийн ажиллах технологийн горим нь станцын технологийн горимтой зөрснөөс ашиглалтын үед мөстөлт үүсэх шалтгаан болсон байх магадлалтай байна. Станцын холбогдох мэргэжилтнүүдээс хөргөх усны технологийн горимын талаар мэдээлэл гаргаж өгөхийг хүссэн боловч өгсөнгүй.

Байгууламжийн инженер геологийн дүгнэлт хийгдсэн /газрын хөдлөлийн 7 баллтай/ боловч магадлалаар ороогүй, зураг төслийг магадлалаар баталгаажуулаагүй, БНХАУ-д зурагдсан ажлын зургийг шууд ашигласан буюу байгууламжийн зураг төслийг зохиогч хэн болох нь тодорхойгүй байна. Энэ нь 2008-2016 онд мөрдөгдөж байсан Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2⁵¹, 13.3⁵², 13.5⁵³, 17 дугаар зүйлийн 17.1.1⁵⁴, 17.1.6⁵⁵ дахь заалтуудыг тус тус зөрчжээ.

Түлш эрчим хүчний яамны ШУТЗ-ийн хурлаар 2008 оны 3 дугаар сарын 14-нд оруулсан гэх боловч аудитын явцад хурлын материалыг гаргаж өгсөнгүй.

Дүгнэлт:

⁴⁹ 10.1 “Барилгын зураг төсөл дараах шаардлагыг хангасан байна”,

⁵⁰ 10.1.1 “Зургийн даалгавар, зураг төсөл зохиох норм, дүрэм технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, газрын зөвшөөрөл, инженер геодезийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон ...”

⁵¹ 13.2 “Гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, эсхүл газар хөдлөлийн 6-гаас дээш баллын бүсэд баригдах, барилга байгууламжийн зураг төсөл, инженер геологийн төвөгшилтэй нөхцөлийн судалгааны дүгнэлт, техник, эдийн засгийн үндэслэлд магадлал заавал хийлгэнэ”,

⁵² 13.3 “Энэ хуулийн 13.2 дахь хэсэг гадаадын зохиогчийг зураг төсөл болон гадаадын байгууллагатай хамтран боловсруулсан зураг төсөл, хот байгуулалтын баримт бичигт нэгэн адил хамаарна”,

⁵³ 13.5 дахь “Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан зураг төсөлд магадлал хийгээгүй тохиолдолд барилгын ажил эхлэхийг хориглоно”,

⁵⁴ 17.1.1 “Тусгай зөвшөөрөлийн үндсэн дээр зураг төсөл боловсруулах ажил үйлчилгээ эрхлэх”,

⁵⁵ 17.1.6 “Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгэх үүрэгтэй”

1. Байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгаврыг холбогдох норм дүрмийн дагуу боловсруулж, төслийн цар хүрээг тодорхой болгоогүй.
2. Станцын одоо ажиллаж байгаа тоног төхөөрөмжтэй холбогдон ажиллах байгууламжийн технологийн даалгавар, ажиллах горимыг тодорхой гаргаж гүйцэтгэгчтэй тохиролцоогүй тул баригдсан хөргөх цамхаг нь ашиглалтын шаардлага бүрэн хангахгүй байна.
3. Гүйцэтгэгч нь гадаадад боловсруулсан зураг төслийг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн баталгаажуулаагүй нь гэрээний үүргээ биелүүлээгүй гэж үзэхээр байна.
4. Захиалагч нь зураг төсөлгүйгээр барилга угсралтын ажил эхлүүлж, санхүүжилт олгосон нь энэхүү төсөл чанаргүй болох гол шалтгаан болсон байна.

Хөргөх цамхагийн барилга угсралтын ажлын талаар:

Тендерт шалгарсан БНХАУ-ын “Шан ши хуатонг электрик повер энд инженеринг” ХХК болон “Анненг повер стэшн экуюипмент групп” лимитед түншлэл нь барилга угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл авалгүй, барилга угсралтын ажлыг гүйцэтгэжээ. Энэ байдал нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1⁵⁶, 14.2⁵⁷, 14.9⁵⁸ дэх заалтуудыг баримтлаагүй байна.

ЗГ-ийн 2012 оны 151-р тогтоолоор батласан дүрмийн дагуу “Барилга угсралтын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл” аваагүй барилга байгууламжийг барьсан нь Барилгын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6⁵⁹-д заасныг зөрчсөн байна.

ДЦС-4 ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2011 оны 5 дугаар сарын 20-ний өдрийн 96 дугаар тушаалаар хөргөх цамхаг барих ажлыг зохион байгуулах, байгууламжийн ажлын явцад техникийн хяналт тавих, ажлын талбайд дотоод дүрэм, журмыг мөрдүүлэх, хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж хүлээн авах зорилготой ажлын хэсэг байгуулсан байна. Уг ажлын хэсгийн гишүүдэд үндсэн цалин дээр 10-30 хувийн нэмэгдэл олгохоор шийдвэрлэж байжээ.

Дээрх байдлаас үзэхэд барилга угсралтын ажлын явцад хөрөнгө оруулагч, захиалагч /ДЦС-4 ТӨХК/ хуулийн хүрээнд хяналт хийж чадаагүй нь Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6⁶⁰, 17 дугаар зүйлийн 17.1.3⁶¹-т заасныг баримталж ажиллаагүйгээс болжээ.

Гэтэл байгууламжийн барилга угсралтын ажил дуусаад ашиглаж эхлэснээс хойш буюу 2017 оны 3 дугаар сарын 13-ний өдөр Эрчим хүчний хөгжлийн төвтэй “Эрчим хүчний барилга угсралтын ажлын явцад техник хяналт хийх” гэрээг байгуулж 10.0 сая төгрөг олгосон байна. Эрчим хүчний хөгжлийн төв гэрээнд заасан ажлаа хийсэн эсэх нь тодорхойгүй, 2012 онд барилга угсралтын ажил гүйцэтгэсэн байгаа бөгөөд далдлагдсан ажлыг 5 жилийн дараа хяналт хийх гэрээ байгуулсан нь ойлгомжгүй байна.

Барилга угсралтын ажлын явцад ил далд ажлын акт баталгаажуулахдаа хавсаргасан материал эдлэлийн сертификат, лабораторийн дүгнэлтүүд зөрүүтэй. Тухайлбал: Гүйцэтгэлийн бичиг баримт №2 хавтаст 37 дугаар хуудас №53-р акт. “Цутгамал төмөр бетон бүтээцийн 2012 оны 6 сарын 20-ны өдөр **-2,200м доод, +7,000м дээд** түвшинд цамхагийн босоо худгийн цутгалт” гэсэн актын комиссын шийдвэр хэсэгт **+10,5м** түвшинд цутгалтын ажлын үр дүнг зөвшөөрсөн байна. Мөн хавсаргасан фото зураг нь 2012/9/15, 2012/08/03 гэсэн огноотой, лабораторийн шинжилгээ нь 2012/5/20-2012/06/02 хооронд хэвлэсэн шоог 2012/6/9-нд шахаж шалгасан хариу байх жишээтэй.

Мөн барилга угсралтын ажлын явцад Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын барилга техник хяналтын улсын ахлах байцаагч Л.Оюун, эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч Б.Мөнхсайхан нарын 2011 оны 11 дүгээр сарын 08-ний өдрийн 06/65/307 тоот шаардлагыг биелүүлж эргэн тайлагнаагүй байна. Уг албан шаардлагад техникийн бичиг баримтын бүрдэл хангаагүй, барилга угсралтын ажлын явцад гарал үүсэл тодорхойгүй материал, хийц эдэлхүүн хэрэглэсэн, барилгын талбайд хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны шаардлага хангаагүй зэрэг зөрчил илэрсэн тул зөрчлийг арилгах хүртэл хугацаанд барилга угсралтын ажлыг зогсоохоор заажээ. Гэтэл барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн барьж дуусгасан байна.

Техникийн болон улсын комисс ашиглалтад хүлээн аваагүй байхад барилга байгууламжийг ашиглаж эхэлсэн нь Барилгын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2⁶² дахь заалтыг дахин зөрчжээ.

⁵⁶ 14.1-д “Барилга байгууламжийн зураг төсөл, барилгын ажил, материал үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэнэ.”

⁵⁷ 14.2-т “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж энэ хуулийн 14.1-д заасан тусгай зөвшөөрөл авах өргөдөлд тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийг хавсаргана”

⁵⁸ 14.9-т “Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30м-с дээш өндөр, 60м-с дээш алгасалтай байгууламж, 16-гаас дээш давхар барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлийг зөвхөн тухайн байгууламжийн хувьд олгоно”

⁵⁹ 16.6-д “Барилга угсралтын ажлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр эхлэх, үргэлжлүүлэхийг хориглоно”

⁶⁰ 15.1.6 “Барилгын захиалагч зураг төсөл, барилгын ажилд хөндлөнгийн хяналт хийлгэх”

⁶¹ 17.1.3 “Энэ хуулийн 15.1.2-т заасны дагуу барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих”

⁶² 19.2-т “Барьж дуусаагүй, дууссан боловч ашиглалтанд хүлээн аваагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно”

Эрчим яамны сайдын 2013 оны 98 тоот тушаалаар батлагдсан “Эрчим хүчний тоног төхөөрөмж, барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулах журмын 2.2-т зааснаар “Улсын комиссын бүрэлдэхүүнийг Эрчим хүчний яамны сайдын тушаалаар, Техникийн комиссын бүрэлдэхүүнийг Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилж ажиллуулна” гэсэн байхад 2016 оны 11 дүгээр сарын 02-ний өдөр станцын гүйцэтгэх захирал С.Анхбаярын А/126 дугаартай тушаалаар хөргөх цамхагийн барилга угсралтын ажлыг хүлээн авах комиссыг байгуулжээ. Тус комисс нь 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр хуралдаж өвлийн туршид халаагч шугамаар залгаж ашиглах зэрэг 11 зүйл бүхий шийдвэр гаргажээ.

Хөргөх цамхагийг улсын комисс албан ёсоор хүлээн аваагүй байхад журам зөрчиж байгуулсан техникийн комисс ашиглалтад авах шийдвэр гаргасан байна.

Хөргөх цамхаг барих ажлын гэрээг 2012 оны 12 дугаар сарын 11-ний өдөр станцын гүйцэтгэх захирал Б.Цэвээн, ерөнхий инженер М.Амарбаясгалан, ЭЗСА-ны дарга Д.Энхтуяа, СХА-ны дарга Г.Галбадрах, хуулийн мэргэжилтэн Д.Ган-Эрдэнэ, СХА-ны менежер Г.Баяраа нар дүгнэж хөргөх цамхагийн ажлыг бүрэн хийж дуусган хүлээлгэн өгсөн тул баталгаат хугацаанд ашиглалтад залгаснаас хойш 1 жил дууссаны дараа 5 хувь буюу 194.46 мянган ам долларыг гүйцэтгэгч талд шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт:

1. Захиалагч ДЦС-4 ТӨХК хуулийн хүрээнд хяналт хийж чадаагүй байна.
2. Уг байгууламжийн ажлын зураг баталгаажаагүй байхад зохиогчийн хяналт хийх эрх үүсэхгүй бөгөөд энэ төслийн хувьд зохиогч тодорхойгүй, ямар нэгэн зохиогчтой гэрээ хийгдээгүй тул зохиогчийн хяналтгүйгээр барилга угсралтын ажил явагдсан байна.
3. Гүйцэтгэгч компани нь холбогдох тусгай зөвшөөрөлгүй, батлагдсан зураг төсөлгүйгээр ажил гүйцэтгэсэн байна.
4. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын албан шаардлагыг үл ойшоож орхигдуулсан байна.
5. Захиалагч, гүйцэтгэгч байгууллагууд уг объектийг ашиглалтад оруулах талаар холбогдох байгууллагад хандаж, Улсын комисс ажиллуулах ямар нэгэн ажил зохион байгуулаагүй байна.

Хөргөх цамхагийн барилгын чанар байдал, ашиглалтын талаар:

Хөргөх цамхагийн барилга угсралтын ажил 2012 оны 12 дугаар сарын 11-ний өдөр дууссан гэж үзэж ашиглаж эхлэсэн боловч 2017 оны 10 дугаар сарын 17 өдөр УАГ-т ирүүлсэн тайлбарт нийт 1 жил 7 сар 11 хоног ажилласан, 3 жил 5 сар 10 хоног засварт зогссон гэж мэдээлсэн байна.

Ашиглалтын явцад мөстөлт үүссэн, хана, багана, дам нуруу зэрэг төмөр бетон хийцүүдийн бетоны хамгаалалтын үе унаж арматур ил гарсан байлаа.

Иймд ашиглалтыг удаа дараалан зогсоож, гүйцэтгэгч компаниар засвар үйлчилгээ хийлгэсэн гэсэн тайлбарыг захиалагч тал өгч байгаа боловч гүйцэтгэгч талаас ус тусгаарлагч хийгдээгүй байхад ашиглаж, эхлэснээс ийм байдалд хүрсэн гэсэн тайлбар өгч байна.

Иймээс 2013 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс зогсоож 6-9 дүгээр сард ус тусгаарлах ажил хийж, ашиглаж эхэлсэн боловч 2014 оны 03 дугаар сарын 13-наас дахин шаардлага хангахгүй байдалд хүрсэн тул зогсоосон байна. Хоёр дахь удаа зогсоосны дараа гүйцэтгэгч нь БНХАУ-ын холбогдох мэргэжилтнүүдийг авчирч оношлуулсан бөгөөд мөн л бетон хийцийн ус тусгаарлалт учир дутагдалтай байгааг хүлээн зөвшөөрсөн байна. Энэ удаад өмнө будсан ус тусгаарлах будгийг элсээр бүрэн угааж цэвэрлэсний дараа ХБНГУ-ын Костер нэрийн ус тусгаарлах бүтээгдэхүүнээр дахин хийхээр болж, хийцүүдийн эмтэрсэн, хамгаалалтын үе унасан хэсгүүдийг засварлаж, Костер нэрийн бүтээгдэхүүнээр ус тусгаарлагчийг хийжээ.

Үүнээс хойш ашиглаж эхэлсэн боловч дахин мөстөлт үүсэж технологийн шаардлага хангахгүй болсон тул хүйтний улиралд зогсоосон байна. Хөргөх цамхагийн төмөр бетон хийцийн чанар байдалд хэсэгчилсэн байдлаар ШУТИС-ын БАС-ийн оношлогоо, зураг төсөл, судалгааны “Реконстракшн” төвийн болон Барилга хөгжлийн төвийн лабораториор тус тус шинжилгээ хийлгэсэн бөгөөд шинжилгээний үр дүн хангалтгүй гарсан байна. Тухайлбал:

- **“Реконстракшн” төвийн дүгнэлтэд:** “Төмөр бетон хөргөх цамхагийн их бие, баганын бетоныг анх цутгах үед бетоны хүйтэн тэсвэршлийг нэмэгдүүлэх, агаар оруулагч нэмэлт хийгээгүй учир ашиглалтын явцад төмөр бетон их бие, баганын бетон өгөршиж арматурын хамгаалалтын бетон үе унаж, арматур ил гарч байна” гэжээ.
- **Барилга хөгжлийн төвийн дүгнэлтэд:** Барилгын материалын сорилт шинжилгээний итгэмжлэгдсэн лабораторийн 2017 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн № 0002099 12м-ийн түвшинд 8 цэг дээр үл эвдэх аргаар хийсэн сорилт, шинжилгээний үр дүнд 50 хувь нь төслийн маркад хүрээгүй байна.

Мөн 2014 онд УАГ-аас “Эрчим хүчний салбарын төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үр дүн”-гийн аудитаар тус станцын хөрөнгөөр барьж ашиглалтад оруулсан “Хөргөх цамхаг 4”-ийг ашиглах явцад гэмтэл гарсан зөрчлийг илрүүлж 2014 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн 02/87 УАГ/ГАГ/2014/09/ГА дугаартай албан шаардлага хүргүүлжээ. Уг албан шаардлагад “...холбогдох бусад байгууллагад уламжилж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг 2015 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд батлуулж, хэвийн ажиллагаанд оруулж, улсын комисст хүлээлгэж өгөх асуудлыг шийдвэрлэхийг даалгасан” байна. Гэвч албан шаардлагын хариуг одоо хүртэл өгөөгүй байна.

Дүгнэлт:

1. Захиалагч тал барилга угсралтын ажил бүрэн дуусаагүй, улсын комисс ажиллаж ашиглалтад оруулах шийдвэр гараагүй байхад байгууламжийг ашиглаж эхлэснээс байгууламжийн чанар байдалд сөргөөр нөлөөлсөн байх магадлалтай байна.
2. Хяналтын байгууллагуудаас өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, барилга угсралтын ажлын явцад технологийн алдаа гаргаснаас байгууламжийн хийц эдэлхүүнүүдийн чанар байдал ашиглалтын явцад эвдрэлд орж чанарын шаардлага хангахгүй болохоор байна.
3. Удаа дараа гүйцэтгэгчээр засвар үйлчилгээ хийлгэж байгаа боловч өнөөг хүртэл ашиглалтын шаардлага хангахгүй байгааг захиалагч болон гүйцэтгэгчийн аль аль нь хүлээн зөвшөөрөхгүй байна.

Хөргөх цамхагийн барилгын хөрөнгө оруулалт, төсөвт өртөг, санхүүжилтийн тооцооны талаар:

Хөргөх цамхагийн барилга барих төслийг хэрэгжүүлэхийн өмнө ТУЗ нь шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоо, техник эдийн засгийн үндэслэл боловсруулаагүйг харгалзан үзэхгүйгээр хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн шийдвэр гаргасан байна. Энэ нь уг ажил удаашрах, чанаргүй болох нөхцөлийг бүрдүүлсэн байна. Учир нь техник технологийн хувьд хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон боловч хөргөх цамхагийн хийцлэл, эдийн засгийн үр өгөөжийн судалгаа хийгдээгүй байсан тул тендерт шалгарсан гэх БНХАУ-ын компанийн саналыг ямар ч харьцуулалтгүйгээр зөвшөөрсөн байна. Үүнээс шалтгаалан барилгын ажлын явцад захиалагч тал хяналт тавих боломжгүй байсан байна.

Хөргөх цамхаг барих ажлыг ТЭЗҮ-гүй эхэлсэн, түлхүүр гардуулах нөхцөлөөр хэрэгжсэн боловч аудитын явцад ямар нэгэн хяналтын төсөв олдсонгүй.

Тендерт шалгарсан “Шан ши хуатонг электрик повер энд инженеринг” ХХК болон “Анненг повер стэшн экюипмент” групп лимитед түншлэлийн ирүүлсэн тендерийн материалд үнийн санал ирүүлсэн төсөв байхгүй байлаа.

ДЦС-4 ТӨХК-ийн санхүүгийн албанаас барилгын гүйцэтгэл олгосон төсөв байгаа эсэхийг тодруулсан боловч зөвхөн нэхэмжлэлийг үндэслэн 2011 оны 5 дугаар сарын 16-аас 2013 оны 7 дугаар сарын 4-ний хооронд 3.6 сая ам доллар буюу 4.7 тэрбум төгрөгийг олгосон тооцоолол ирүүлсэн болно. Байгууламжийн баталгаат хугацаа дууссаны дараа нийт үнийн дүнгийн 5 хувийг олгохоор гэрээнд заасны дагуу 194.4 мянган ам. доллар олгоогүй байна.

Гүйцэтгэгч компаниас 2017 онд тэргүүлэх төсөвчин н.Энэбишээр баталгаажуулсан гүйцэтгэлийн төсөв ирүүлсэн нь 2012 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн ЗТБХБ-ийн сайдын 181-р тушаалаар батлагдсан үнийн бүрдлийн үндсэн дүрмийг баримтлан гүйцэтгэсэн байна. Харин энэхүү ажлын гэрээ 2011 оны 5 дугаар сард хийгдсэн учир хуучин мөрдөж байсан⁶³ зэргийг үндэслэн төсвийн тооцоололыг хийх шаардлагатай байна.

Аудитын явцад барилга байгууламжийн зураг төсөл эцэслэн батлагдаагүй тул ажлын тоо хэмжээг тулган шалгах боломжгүйд хүргэж байна.

Улсын комисс хүлээн аваагүй, Төрийн өмчийн хорооны тогтоол гараагүй байгууламжийг барилга угсралтын ажлын гэрээ дүгнэсэн протоколыг үндэслэн 2013 онд үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэж, 637.18 сая төгрөгийн элэгдэл тооцож байгуулсан байна. 2016 онд ашиглаагүй засварт зогсоосон тул элэгдэл тооцоогүй байна.

⁶³ “Нэмэгдэл зардал, ашгийн жишиг норм тогтоох тухай” Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1998 оны 09 дүгээр тушаал, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1995 оны 273 дугаар тушаалаар баталсан “Барилга байгууламжийн прейскурант боловсруулах, хэрэглэх дүрэм”/БНБД IY-14-89/, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1998 оны 200 дугаар тушаалаар баталсан “Барилгын төсөв зохиох заавар”/БНБД (IY) 81-2-98/, “Нэмэгдсэн өртгийн албан татварын эх үүсвэрийг төсөвт тусгах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2007 оны 31 дүгээр тушаал, “Жишиг нормд өөрчлөлт оруулах тухай” Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 327 дугаар тушаал, Барилга, архитектур, техник хяналтын улсын хорооны 1985 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Үндсэн дүрэм”/БНБДИY-1-85/, Улсын барилгын хорооны 1990 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Барилгын төсөвт өртгийг тодорхойлох дүрэм”/БНБДИY-15-90/, Барилга, хот байгуулалтын комиссын 1992 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Барилгын өртгийн хязгаар хэлцлийн үнэ зохиох аргачлал, гүйцэтгэлийн төсөв боловсруулах заавар

Тус хөргөх цамхагийг тарифт тусгасан байдлыг авч үзэхэд Эрчим хүчний зохицуулах хорооноос үндсэн хөрөнгийн элэгдлийг байгуулж /зарим жилд байгуулаагүй/ ирсэн боловч тухайн хөрөнгийн элэгдлийн зардал тарифт тусгагдаагүй гэж үзэж болохоор тайлбар өглөө. Аудит хийх явцад ДЦС-4 ТӨХК-аас уг төслийн хэрэгжилттэй холбоотой санхүүгийн баримт бичгийг дэлгэрэнгүй ирүүлээгүй тул нарийвчлан шалгах боломж бүрдээгүй болно.

Эцсийн дүгнэлт:

Хөргөх цамхаг байгуулах төсөл арга хэмжээ нь технологийн хувьд станцын хүчин чадал нэмэгдүүлэх чухал төсөл байсан боловч захиалагч байгууллага нь хууль журмын дагуу ажлаа зохион байгуулаагүйгээс чадваргүй гүйцэтгэгч шалгаруулан, чанаргүй байгууламж бариулж өнгөрсөн 6 жил гаруй хугацаанд 3.6 сая ам долларын хөрөнгө зарцуулсан боловч өнөөг хүртэл үр дүн гараагүй байна. Хөргөх цамхаг ажиллагаанд ороогүй тохиолдолд 5,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж өргөтгөсөн ТГ-6 турбин генераторыг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах боломжгүй болох эрсдэл үүссэн байна.

Хавсралт №12

ДЦС-4 ТӨХК ПТ-80-130 ТГ-6 турбины хүчин чадлыг 20 МВт-аар нэмэгдүүлсэн өөрчлөлтийн ажилд аудитын дүгнэлт гаргасан тухай

Ерөнхий зүйл:

ПТ-80/100-130/13 маягийн турбин ст№6 –ийн номиналь чадлыг 20мВа-аар нэмэгдүүлэх төслийг тухайн үеийн турбин цехийн дарга байсан М.Амарбаясгалан боловсруулж, ДЦС-4 ТӨХК-ийн 2008 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн техникийн зөвлөлийн хуралд танилцуулснаар дэмжигдэн хэрэгжиж эхэлсэн байна. Төслийг ТГ-5 дээр хийсэн ажлын үр дүнгээр тооцоолж, хийхээр шийдвэрлэсэн байна.

Энэхүү шинэчлэлийн ажил хийгдсэнээр турбины хүчин чадал нэмэгдэж, станцад эдийн засгийн хувьд ашигтай байсан ч худалдан авах ажиллагаа, ашиглалтад оруулах үйл явц хууль тогтоомжийн хүрээнд хийгдээгүй байна.

Гэрээ байгуулах үйл явцын талаар:

2008 оны 12 дугаар сарын 25-ны өдөр станцын “Техникийн зөвлөлийн хурал” –аас ТГ-6 турбиныг өмнө ТГ-5-ыг өргөтгөсөн аргаар өргөтгөхийг дэмжих шийдвэр гарсан байна. Энэ асуудлыг дараагийн шатны хурал буюу салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурал, ТУЗ-ын хуралд оруулж танилцуулах шийдвэр гарсан байна. Гэвч салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурал, ТУЗ-ын хурлын тэмдэглэл, шийдвэр ирүүлсэн материал дотор байхгүй байлаа.

ТГ-6 турбиныг өргөтгөх ажлын зураг төсөл, төсөв, ТЭЗҮ байхгүй, уг төсөлд ямар хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай, хэзээ ямар хугацаанд хөрөнгө оруулалтаа нөхөх тооцоо, судалгаа байхгүй нь Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно.” гэснийг зөрчсөн байна.

2009 оны 3 дугаар сарын 24-нд ДЦС-4 ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Цэвээний №35 дугаар тушаалаар Турбогенератор №6-ийн нам даралтын роторын сүүлийн хэсгийн өөрчлөлт, их засварын ажлыг зохион байгуулах тухай дараах шийдвэр гарсан байна. Үүнд:

- ТБОНӨХБАҮ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2⁶⁴-ийг үндэслэл болгон БНХАУ-ын Харбин хотын цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэртэй шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсүгэй гэжээ.

Гэтэл БНХАУ-ын Харбин хотын цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэр нь тухайн тоноглолын патентыг эзэмшдэг нь тодорхойгүй, байгуулсан гэрээ нь зуучлагчаар /Хүрэл интернэйшнл трейд Ко.Лтд/ дамжуулан бараа материал нийлүүлэх гэрээ байгуулсан байгаа нь оюуны өмчийн эрхийг хангах шаардлагаар шууд гэрээ байгуулсан үндэслэлтэй тохирохгүй байна.

- ТБОНӨХБАҮ худалдан авах тухай хуулийн 34.1.5⁶⁵-ийг үндэслэл болгон туслан гүйцэтгэгчээр Турбин ХХК, МЭЗ ХХК-тай гэрээ байгуулан ажиллахыг зөвшөөрсүгэй гэжээ.

Техникийн зөвлөлийн хурлын тэмдэглэлээс харахад цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, орлогын эх үүсвэр нэмэгдүүлэх зорилгоор төлөвлөгөөт засварын ажлын хүрээнд ТГ-6 турбин генераторийг өргөтгөн шинэчлэх ажлыг гүйцэтгэхээр зохион байгуулсан байна. /2009 оны 4 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд гүйцэтгэхээр гэрээг байгуулсан/

⁶⁴ 34.1.2.оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол;/

⁶⁵ 34.1.5.гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол;

ТБОНӨХБАҮ худалдан авах тухай хуулийн 34.1.5 дахь заалтыг үндэслэн гэрээ байгуулахдаа онцгой байдал үүссэн тухай холбогдох газрын мэдээлэл байхгүй байгаа тул гэрээ байгуулсан үндэслэл тохирохгүй байна. Гэтэл гэрээгээр гүйцэтгэх ажлууд нь БНХАУ-с нийлүүлсэн тоног төхөөрөмжийг угсрах, туршиж тохируулах ажлууд байлаа.

Уг төслийн ажлын хүрээнд доорхи гэрээнүүдийг байгуулсан байна.

Материал нийлүүлэх гэрээ						
№	Гэрээний дугаар	Гэрээний нэр	Нийлүүлэгч	Гэрээний дүн / юань, төгрөг/	Гэрээний хугацаа	Гэрээ байгуулсан
1	Г-2009/04	Монгол улс УБ хотын 4-р цахилгаан станцын ПТ80/100-130/13 уурын турбины хүчин чадал нэмэгдүүлэх засварын ажил	Нийлүүлэгч: “Хүрэл интернэшнл трейд” /Бээжин/ Лтд компани Үйлдвэрлэгч: Харбин уурын турбин ба дулааны станцын тоног төхөөрөмж Лтд компани	22,993,650.0 юань 5,073.275,869.0 төгрөг	60 хоног	09.01.23
2	Г-2009/10	Худалдах худалдан авах гэрээ	Худалдагч: “Хүрэл интернэшнл трейд” /Бээжин/ Лтд компани	1,464,596.0 юань 323,968,635.0 төгрөг	09.06.01	09.04.06
		Нийт дүн /юань/		24,458,246.0		
		Нийт дүн / төгрөг/	/ханш~220,68/	5,397,244,504.0		
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ						
№	Гэрээний дугаар	Гэрээний нэр	Гүйцэтгэгч	Гэрээний дүн /төгрөг/	Гэрээний хугацаа	Гэрээ байгуулсан
1	Д-2009/96	Барилгын засвар угсралтын ажил гүйцэтгэх гэрээ	“Корунд” ХХК	57,367,784.0	09.05.25	09.04.22
2	Д-2009/77	Засварын ажлын гэрээ	“МЭЗ” ХХК	145,000,000.0	09.10.01	09.04.06
3	Д-2009/76	Засварын ажлын гэрээ	“Турбин” ХХК	142,284,582.0	09.10.01	09.04.06
		Нийт дүн / төгрөгөөр/		344,652,366.0		
ТӨСЛИЙН НИЙТ ӨРТӨГ				5,741,896,870.0		

“Хүрэл интернэшнл трейд” /Бээжин/ Лтд компани, “Корунд” ХХК-тай гэрээг ямар тушаал, шийдвэрийг үндэслэн байгуулсан нь тодорхойгүй байна.

Мөн ТГ-6 турбин генераторын өөрчлөлтийн ажлын зураг, хяналтын төсвийг аудитад ирүүлээгүй байгаа тул гэрээний үнийн дүн, хийгдэх ажлын тоо хэмжээг шалгах боломжгүй байлаа.

Гэрээний хэрэгжилтийн талаар:

2009 оны 12 дугаар сарын 25-ны өдөр станцын ерөнхий инженер М.Амарбаясгалан даргатай 17 хүний бүрэлдэхүүнтэй комисс ажиллаж, “Уурын турбиныг их засвараас хүлээн авсан акт №11”-ийг үйлдэж баталгаажуулсан байна. Уг актанд “Турбиныг 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдөр ашиглалтад хүлээн авсанд тооцов” гэсэн тул энэ өдрөөс ашиглаж эхэлсэн байна.

Аудитад ирүүлсэн төслийн ажлын гүйцэтгэлийн бичиг баримтуудад нийлүүлсэн тоног төхөөрөмжийн гарал үүсэл тохирлын гэрчилгээ, гүйцэтгэгч компаниудын тусгай зөвшөөрөл байсангүй.

ДЦС-4 ТӨХК нь хүчин чадал нэмэгдүүлсэн турбин генераторийг улсын комисст өгөөгүй, ашиглалтын тусгай зөвшөөрөлгүйгээр 2010 оны 1 дүгээр сараас одоог хүртэл ашиглаж байгаа нь Барилгын тухай хуулийн 19.2⁵ дугаар заалтыг зөрчсөн байна.

Гэрээний санхүүжилтийн талаар:

Төслийн хүрээнд 5,741,896.870.0 төгрөгийн гэрээ байгуулсан байгаа боловч их засвараас хүлээн авсан акт дээр нийт хөрөнгө оруулалт нь 6.4 тэрбум төгрөг гэсэн байгаа бөгөөд гүйцэтгэгч талыг төлөөлж гарын үсэг зурсан 5 компаниас “Тас хайрхан” ХХК, “Атом маш” ХХК, “ЭДС” ХХК-иудын талаарх мэдээлэл аудитад ирүүлээгүй болно.

Дүгнэлт:

1. ТБОНӨХБАҮХА хуулийн дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулсан бөгөөд үндэслэл болгосон хуулийн заалтууд нь тухайн үйл ажиллагаатай тохирохгүй байна. Иймээс нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахаас зайлсхийх зорилгоор нийт ажлыг хэсэгчлэн хувааж, материал тоног төхөөрөмж нийлүүлэлтийг салгасан байх магадлалтай байна.



2. Мөн хоёр гэрээг тушаал шийдвэр, сонгон шалгаруулалтгүйгээр шууд байгуулсан байна. /”Хүрэл интернэшнл трейд”/Бээжин/ Лтд компани, “Корунд” ХХК/
3. Батлагдсан зураг төсөл, хяналтын төсөвгүйгээр ТГ-6-ийн өргөтгөл шинэчлэлийн ажлыг гүйцэтгэсэн байна.
4. Техникийн болон Улсын комисс хүлээн аваагүй байхад ашиглалтад оруулсан.
5. Төрийн өмчийн хорооны тогтоолгүйгээр үндсэн хөрөнгөд бүртгэж элэгдэл тооцсон.
6. Эрчим хүчний тусгай зөвшөөрлийн өөрчлөлтийг хийгээгүй байна.

Хавсралт №13

Хүчний трансформаторын чадлыг нэмэгдүүлсэн ажилд аудитын дүгнэлт гаргасан тухай

Ерөнхий зүйл:

Өмнөд дэд станц нь 1980 онд 2х25 МВА-ийн хүчин чадалтай 2 трансформатортайгаар ашиглалтад орсон байна.

2008 онд дэд станцад томоохон осол гарсан тул 2009 онд шинэчлэлтийн ажил хийсэн байна. Үүнд: 0,4 кВ-ын ДХТ, 110 кВ-ын Секц.С-аас бусад тоноглолд бүрэн шинэчлэлт, 10 ба 6 кВ-ын секцэнд автомат удирдлагат реактор суурилуулжээ.

ЭХЯ-наас олгосон 2014 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 51/2014 техникийн нөхцөлийн дагуу Хүчний трансформаторын чадлыг нэмэгдүүлж 2х63 МВА болгожээ.

2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 22 цаг 40 минутад Өмнөд дэд станцын 6,10 кВ-ын хуваарилах байгууламжаас гарсан кабель шугамуудын үзүүр буудаж, гал гарсан байна. Тус дэд станцын 6 кВ-ын 2 дугаар секцийн “Пауэр Юнайт” ХХК-ийн эзэмшлийн “АПК-3” шугамын “XLPE” маркийн полиэтилен тусгаарлагатай 3х240 мм² хөндлөн огтлолтой хос кабель шугамын хөндийрүүлэг муудсаны улмаас гэмтэн шатаж, улмаар дэд станцын кабелийн туннельд гал гарч зэргэлдээ байгаа “19-р хороолол”, “Зогсоол”, “РП-38Б”, “АПК-4” ячейкууд гэмтсэн аваар гарсан байна.

2017 оны 7 дугаар сарын 24-нд ЦДҮС ТӨХК-ийн “Үйлдвэрлэл, техникийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүдийн ээлжит бус хурал”-аас хүчний трансформаторыг 25 МВА болгон солих шийдвэр гарсны дараа, хуучин буулгасан трансформаторыг буцаан суурилуулжээ.

Түлш, эрчим хүчний салбарын ТӨК-иудын санхүүгийн чадавхийг бүрдүүлэх замаар 2013-2014 оны нүүрсний аюулгүйн нөөц, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах зорилгоор МБ-ны Ерөнхийлөгч, ЭХ-ний сайдын 2013 оны А-148/95 дугаар хамтарсан тушаалаар баталсан хөтөлбөрийн хүрээнд SFSZ11-63000 110/11/6.6 маркийн 2ш хүчний трансформатор нийлүүлэх 2.8 тэрбум төгрөгийн зээл авсан байна.

Трансформаторыг шинэчлэн өөрчлөх ажил зохион байгуулсан талаар:

2008 оноос 2009 онд хийгдсэн 0,4 кВ-ын ДХТ, 110 кВ-ын Секц.С-аас бусад тоноглолд бүрэн шинэчлэлт, 10 ба 6 кВ-ын секцэнд автомат удирдлагат реактор суурилуулсан шинэчлэлтийн ажлын талаар материал аудитын явцад ирүүлээгүй.

2014 онд ЭХЯ-наас олгосон 2014 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 51/2014 техникийн нөхцөлийн дагуу Хүчний трансформаторын чадлыг нэмэгдүүлж 2х63 МВА болгох ажлыг ЦДҮС ТӨХК зохион байгуулж гүйцэтгэсэн байна.

Тус техникийн нөхцөлийн 8.6; 8.11-т зааснаар трансформаторыг 63 МВА болгосон боловч холбогдох тоноглолыг 25 МВА тооцож тавихыг заасан байна.

Мөн техникийн нөхцөлийн 9.7-д ЭХЯ-наас зургийн даалгавар авах, 9.1; 9.3-т уг техникийн нөхцөлийн дагуу зураг төсөл хийлгэх, холбогдох байгууллагаар хянуулахыг, 9.4-т УМХГ болон холбогдох газраар хяналт тавиулах, 9.6-т тоног төхөөрөмжийг залгах аас өмнө бичиг баримтыг захиалагч хүлээн авсан байна гэжээ. Гэтэл аудитын явцад уг тоног төхөөрөмжийг угсрах ажлын зураг ирүүлээгүй болно.

Эрчим хүчний сайдын 2013 оны 120 дугаар тушаалыг үндэслэн ЦДҮС-ийн гүйцэтгэх захирал Ж.Равдандорж 2013 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр “Тэдэ Энержи” ХХК-тай SFSZ11-63000 110/11/6.6 маркийн 2 ш хүчний трансформатор нийлүүлэхэд нийт 2.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий шууд гэрээ байгуулжээ. Шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 зүйлийн 8.2⁶⁶ дахь заалтыг зөрчсөн байна.

⁶⁶ 8.2.Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.

2014 оны 7 дугаар сарын 16-нд ЦДҮС-ийн Ерөнхий инженер Ц.Жаргалсайхан, 33Х-ийн дарга Т.Самдандорж, РХАХ-ийн дарга Ч.Амарсанаа, ХҮХ-ийн дарга Я.Гансүх, ШЗХ-ийн дарга З.Өлзийбаяр, ҮТХ-ийн инженер Д.Мөнхзаяа, СЭЗТХ-ийн нябо Д.Хүрэлгинж, УБС-ын ерөнхий инженер Д.Жаавай, УБС-ын АА-ны дарга Л.Хасбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр трансформаторыг хүлээн авсан тухай №13/50 дугаар акт үйлдсэн байна. Уг трансформаторыг хүлээн авснаас хойш **хэзээ, хэн, ямар зураг төслөөр угсарч ажиллагаанд оруулсан тухай** бичиг баримт аудит явцад ирүүлсэнгүй.

Дэд станцын нийт ачаалал 63 мВА хүчний трансформаторт багтах боловч уян шин, нэвтрэх изолятор, 10, 6 кВ-ын шин, хуваарилах байгууламжийн тоноглолууд 25 мВА чадалтай трансформаторт зориулж хийгдсэн тул ачааллыг бүрэн шилжүүлэх техникийн боломжгүй байгаа боловч ЦДҮС-ийн удирдлага, техникийн ажилтнууд ашиглалтад оруулсан байна.

2017 оны 6 дугаар сарын 6-нд ЦДҮС-ийн тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Д.Чинбат даргатай 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс ажиллаж 110/10/6 кв-ын “Өмнөд” дэд станцад гарсан технологийн зөрчлийг судалсан акт №05 актыг гаргажээ.

Актад зөрчил үүссэн шалтгааныг “Техник ашиглалтын дүрэмд зааснаар хөндийрүүлэгдсэн нейтралтай 6 кВ-ын сүлжээнд газардлагын гүйдлийн зөвшөөрөгдөх хэмжээ 30 А, 10 кВ-ын сүлжээнд 20 А байдаг. Өмнөд дэд станцын хувьд 6,10 кВ-ын сүлжээний багтаамжийн гүйдлийг 2016 онд ОХУ-ын “Болид” компанийн мэргэжилтнүүдтэй хамтарсан хэмжилтээр 6кВ-ын сүлжээнд 63А, 10 кВ-ын сүлжээнд 47,6А гарсан нь зөвшөөрөгдөх хэмжээнээс 2-3 дахин их байгааг нотолсон болно.

Энэ нөхцөл байдал нь Өмнөд дэд станцын 6,10 кВ-ын хуваарилах байгууламжаас гарсан кабель шугамуудын үзүүр буудаж, гал гарах үндсэн шалтгаан болж байна” гэснээс үзэхэд хүчний трансформатор 63 МВА болсноос хойш гүйдлийн утга өндөрсөж, 25 мВА чадалд тохирсон тоноглолуудын хэвийн ажиллагаа алдагдаж, аваар гарах нөхцөл бүрдсэн байхаар байна.

Ийм байдал үүссэн тул 2017 оны 7 дугаар сарын 24-ний өдөр ЦДҮС ТӨХК-ийн “Үйлдвэрлэл, техникийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүдийн ээлжит бус хурал”-ын шийдвэрээр хүчний трансформаторыг 25 МВА болгон солихыг ТБЗХ-ийн дарга Б.Энхбат, Улаанбаатар салбарын ерөнхий инженер Д.Жаавай нарт үүрэг болгосноор 2014 онд сольсон 63 МВА-ын 2 ш трансформаторыг хуучин 25 МВА-ынхаар сольж суурилуулан ажиллуулж байна. Гэвч энэ ажилтай холбоотой техникийн бичиг баримтыг аудитад ирүүлсэнгүй.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад /2 сарын хугацаанд/ ЦДҮС ТӨХК-наас холбогдох бичиг баримтыг ирүүлээгүй тул бүрэн хэмжээнд дүгнэлт гаргах боломжгүй байлаа. Одоогоор ирүүлсэн бичиг баримтын хэмжээнд дараах дүгнэлтийг гаргалаа.

- 2014 онд хүчний трансформаторыг 63 КВА болгох техникийн нөхцөл гарсан байхад 2013 онд трансформатор худалдан авах 2.8 тэрбум төгрөгийн гэрээг хийсэн нь ойлгомжгүй байна.
- Батлагдсан зураг төсөлгүй техникийн нөхцөлийн заалтуудыг зөрчиж хүчний трансформаторыг угсарч, ажиллагаанд хүлээн авсан нь осол гарах гол шалтгаан болж 160.9 сая төгрөгийн хохирол учирсан байна.
- ЦДҮС ТӨХК-ийн удирдлага “Үйлдвэрлэл, техникийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүдийн ээлжит бус хурал”-аас трансформаторыг буцаан солих шийдвэр гаргасан нь техникийн хувьд хамгийн боломжтой шийдвэр боловч эдийн засгийн хувьд 2.8 тэрбум төгрөгийн шууд алдагдал хүлээсэн байна.
- Эрчим хүчний сайдын 2013 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 98 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний тоног төхөөрөмж, барилга байгууламжийн угсралтын ажлыг ашиглалтад оруулах журам”-ын дагуу угсралтын ажлыг хүлээн аваагүй, ТӨХ-ны үндсэн хөрөнгөд бүртгэх тухай тогтоол гараагүй байхад байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.
- 2013 онд тус компани 2.0 тэрбум төгрөгийн зээлийг богино хугацаат өр төлбөрт бүртгээд, 2015 оны 12 дугаар сарын 31-нээр зээлийг төлж дууссанаар нягтлан бодох бүртгэлд тусгагдсан байна.

**“ДзДЦС” ТӨХК-ийн турбин генераторыг шинэчлэн солих ажлыг хэрэгжүүлсэн тухай**

Засгийн газрын 2015 оны 293 дугаар тогтоолоор “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн найдвартай ажиллагаа, 2015-2016 оны өвлийн бэлтгэлийг хангах зорилгоор эвдэрсэн турбин генераторыг шинэчлэн солих ажлыг түлхүүр гардуулах нөхцөлөөр гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулан 2015 оны 11 дүгээр сарын 25-ны дотор ашиглалтад оруулахыг Эрчим хүчний сайд Д.Зоригтод даалгаж, энэхүү ажилд шаардлагатай байгаа 1.3 тэрбум төгрөгийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхийг Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар), Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт тус зөвшөөрсөн байна.

Энэ тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЭХС 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 184 дүгээр тушаал гаргаж эрчим хүчний салбарын НХА-ийн мөнгөн урсгалын гүйцэтгэлийн хүрээнд зохицуулалт хийх асуудлаар ЭХЗХ-той зөвшилцөн шийдвэрлэхээр яамны БХЗГ-т даалгасан нь Засгийн газрын тогтоолыг зөрчсөн байна.

Энэ шийдвэрийн дагуу “ДзДЦС” ТӨХК-д турбины шинэчлэлийн 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зохицуулалт хийхдээ “ДЦС-3” ТӨХК-ийн 2016 оны 1 дүгээр улирлын цахилгааны тарифыг 5.12 төг/кВт.ц-аар нэмэгдүүлж, 84.37 төг кВт.ц болгох шаардлагатай болсон тул ЭХЗХ-нд 2015 оны 12 дугаар сарын 23 –ны өдрийн 1/2314 дугаар албан бичгээр санал ирүүлсэн байна. ЭХЗХ 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 318 дугаар тогтоолоор ДзДЦС ТӨХК-ийн турбины шинэчлэлийн төслийн ажилд санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор “ДЦС-3” ТӨХК-ийн “ЦДҮС” ТӨХК-д худалдах цахилгааны тарифыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд /НӨАТороогүй/ 84.37 төгрөг кВт.ц байхаар баталсан байна. ЗГ-аас гаргасан тогтоолыг ЭХС Д.Зоригт хэрэгжүүлэхдээ эх үүсвэрийг санхүүжүүлэх байгууллагыг тодорхой зааж өгсөн байхад ЭХЗХ-нд үүрэг чиглэл өгч компанийн худалдах тарифыг нэмсэн байна. Эрчим хүчний сайдын шийдвэрээр ДЦС-3 ТӨХК-ийн ДҮТ ХХК-д худалдах тарифыг нэмэгдүүлж эх үүсвэр гарган 2015-2016 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор Даланзадгадын дулааны станцын турбины засварт хорооны 2015 оны 318-р тогтоолоор 1.3 тэрбум шийдвэрлэж өгсөн байна.

ЭХЗХ 2016 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “ДЦС-3” ТӨХК-ийн “ДҮТ” ХХК-д худалдах цахилгааны тариф, “УБДС” ТӨХК-д худалдах дулааны тарифыг дахин өөрчлөн баталж, аргачлал өөрчлөгдсөн тул 2015 оны 318 дугаар тогтоолыг хүчингүй болгосон байна. Эрчим хүчний сайдын 2015 оны 07 дугаар сарын 16-ний өдрийн 102 дугаар тушаалаар “Даланзадгад ДЦС” ТӨХК-ийн гэмтсэн турбингенератор №1-ийн суурин дээр 3 МВт-ийн хүчин чадалтай дулаацуулгын авлагатай турбингенератор худалдан авч суурилуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилж 2015 оны 09 дүгээр сарын 14-ний ЭХЯ-ны хурлаар түлхүүр гардуулах нөхцөлөөр “ДзДЦС” ТӨХК-ийн найдвартай ажиллагаа, 2015-2016 оны өвлийн бэлтгэл хангах үүднээс эвдэрсэн турбингенераторыг шинэчлэн солих ажлыг 1,298,000,000 төгрөгөөр “Хүрэл Интернэшнл” ХХК-тай гэрээ байгуулах эрх ДзДЦС ТӨХК-д олгох шийдвэр гарсан.

1-р турбингенераторын эвдрэлийг шинэчлэн солих ажлыг “Хүрэл Интернэшнл” ХХК болон Монгол талын итгэмжлэгдсэн төлөөлөгч “Anneng Power Station Equipment Group” тай хамтран гүйцэтгэхээр 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу хуучин суурийг тайрах ажлыг 2016 оны 01 дүгээр сарын 27 өдрөөс 01 дүгээр сарын 30 өдрийг хүртэл хийсэн. Гэрээний үнийн дүнгийн 30 хувийг “Anneng Power Station Equipment Group Limited” дансанд-ын дагуу 2 сарын 22-нд 389,399,992.13 төгрөг шилжүүлсэн. Турбингенератор, конденсаторын суурийн гүйцэтгэлийн ажлыг 03 дугаар 06-наас 03 дугаар сарын 21 хүртэл “суурийн ажил дуусахад гэрээний үнийн дүнгийн 15 хувийг “Хүрэл Интернэшнл” ХХК-ийн дансанд”-ын дагуу 03 дугаар сарын 18-нд 194,700,000 төгрөг шилжүүлсэн, “Тоног төхөөрөмж Монгол улсын хил дээр ирэхэд гэрээний үнийн дүнгийн 40 хувийг “Anneng Power Station Equipment Group Limited” дансанд 03 дугаар сарын 21-нд 233,639,998.47 төгрөг, 04 дүгээр сарын 19-нд 285,559,994.16 төгрөг тус тус 2 хувааж шилжүүлжээ. Засвар угсралтын ажлыг гүйцэтгэхээр “Anneng Power Station Equipment Group”-ийн инженер техникийн 6 ажилтан хүрэлцэн ирж 2016 оны 04 дүгээр сарын 26-аас эхлэн 5-р сарын 23-ны хүртэлх хугацаанд угсарч, дуусаад 25-ны өдөр 1230-д ТГ-1 ийн уурын шугамыг халааж эхэлсэн. Гэвч гэмтэл саатал, зогсолт гарснаар гэрээний дагуу туршилтын 72 цаг ажиллаагүй түлхүүр гардуулах нөхцөл бүрдээгүйн улмаас хөрөнгийг хүлээж аваагүй байна. Тухайн үеийн ЭХС Д.Зоригт Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлээгүйгээс тариф нэмэгдүүлж хөрөнгө оруулалтын эх үүсвэр бүрдүүлэн суурилуулсан турбин генераторыг шинэчлэн солих ажил үр ашиггүй болж иргэд, ААН-ийн төлсөн эрчим хүчний төлбөр үр дүнгүй зарцуулагдсан байна.



“Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үр дүн” аудитын тусгай хавсралт

Аудитаар илэрсэн зөрчилтэй холбоотой албан тушаалтны нэрс

Илэрсэн зөрчил	Тухайн үеийн албан тушаал	Зөрчил	Овог нэр
Зохицуулах хорооны даргаар ажиллаж байсан С.Отгонбаяр нь ажлаас чөлөөлөгдсөн тушаал гарсны дараа 216.2 сая төгрөгийг зарцуулсан байна.	Эрчим хүчний зохицуулах хорооны дарга	Ажлаас чөлөөлөгдсний дараа 216.2 сая төгрөгийг зарцуулсан.	С.Отгонбаяр
2015 онд ДЦС-3 ТӨХК-ний тарифыг нэмэгдүүлэх замаар Даланзадгад ДЦС-ын 1 дүгээр турбины шинэчилэх ажилд шилжүүлсэн 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт үр ашиггүй болсон. Одоо тус станцын 1 дүгээр турбин ашиглалтад ороогүй байна. Тухайн үеийн эрчим хүчний сайд Засгийн газрын тогтоолыг зөрчсөн байна.	Эрчим хүчний сайд	Засгийн газрын тогтоолыг зөрчсөн, тендер зарлаагүй шууд ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.	Д.Зоригт
	Эрчим хүчний зохицуулах хорооны дарга	ДЦС-3 ТӨХК-ний тарифыг нэмэгдүүлж баталсан.	С.Отгонбаяр
ДЦС-4 ТӨХК-д хэрэгжсэн хөргөх цамхаг байгуулах хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь хууль журмын дагуу ажлаа зохион байгуулаагүй, чадваргүй гүйцэтгэгч шалгаруулж, чанаргүй байгууламж бариулснаас хойш 3.6 сая ам долларын хөрөнгө зарцуулсан боловч өнөөг хүртэл үр дүн гараагүй байна.	ДЦС-4 ТӨХК-ийн гүйцэтгэх захирал	Төсөл арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулаагүй, өнөөг хүртэл үр дүнгээ бүрэн өгөөгүй.	Б. Цэвээн
ДЦС-4 ТӨХК ПТ-80-130 ТГ-6 турбины хүчин чадлыг 20 МВт-аар нэмэгдүүлсэн шинэчлэлийн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа, ашиглалтад оруулах үйл явц хууль тогтоомжийн хүрээнд хийгдээгүй байна.		Төсөл арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.	Б. Цэвээн
ЦДҮС ТӨХК-ийн удирдлага батлагдсан зураг төсөвгүй, техникийн нөхцөлийн заалтуудыг зөрчиж, хүчний трансформаторыг угсарч, үйл ажиллагаанд хүлээн авсан нь 2.8 тэрбум төгрөгийн шууд алдагдал хүлээсэн байна.	ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал	Батлагдсан зураг төсөвгүй, техникийн нөхцөлийн заалтуудыг зөрчиж, хүчний трансформаторыг угсарч, үйл ажиллагаанд хүлээн авсан.	Ж. Равдандорж

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/218

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.39-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, “Диспетчерийн үндэсний төв” ХХК-д тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /У.Хүрэлсүх/, Эрчим хүчний сайд /Ц.Даваасүрэн/, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга /А.Тлейхан/, “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн захирал /Д.Балдорж/ нарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитаар илэрсэн зөрчилтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /М.Давааням/-т даалгасугай.
5. Аудитын хүрээнд бий болсон нотлох баримт бусад баримт материалыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон архивт хүлээлгэн өгөхийг Аудитын багт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Tushaал\2017\1124GAG4.Docx

071381



Монгол Улсын Ерөнхий аудитормын
2017 оны 11 дүгээр сарын 2-ний өдрийн
А/2/18 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Аудитаар тогтоосон телберийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Телбер, зөрчил хариуцах		Телбер, зөрчлийн товч утга	Дугаар	Телберийн актын дүн	Албан шаардлагын дүн
	Байгууллага	Албан тушаал				
1	Эрчим хүчний зохицуулах хороо	Хорооны дарга	Улсын төсөвт төвлөрүүлэх тэмдэглэлийн хураамжийг төсөвт төвлөрүүлэх.	01/36-УАГ-ГАГ/2017/05ГА	213.2	
2	Эрчим хүчний зохицуулах хороо	Хорооны дарга	Урлаг, спорт олон нийтийн арга хэмжээ, баяр ёслол тэмдэглэх зэрэг үйлдвэрлэлийн бус зардлыг тарифт тооцсон.	03/02/101-УАГ- ГАГ/2017/05ГА		2,598.6
3	Эрчим хүчний зохицуулах хороо	Хорооны дарга	2015, 2016 онд зохицуулалтын үйлчилгээний хөлс дутуу төвлөрүүлсэн.	01/36-УАГ-ГАГ/2017/05ГА		306.5
4	ДҮТ ХХК	Гүйцэтгэх захирал	ДҮТ ХХК-аас арилжааны банкуудтай хийсэн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж хариуцлага тооцох, мөнгөн урсгалыг зохицуулж буй програм хангамжийг шинэчлэх талаар зөрчил арилгуулах.	01/99-УАГ-ГАГ/2017/05ГА		825.2
	Нийт				213.2	3,730.3

--- ооо ---